

MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 5 САР. №09 (067)


ЭДИЙН ЗАСАГ
ЦОГТЦЭЦИЙГЭЭС ГАШУУНСУХАЙТ
ХҮРТЭЛХ СААРАЛ АМЬДРАЛ-1,2

ЭДИЙН ЗАСАГ
107-ГИЙН БАЛАГ

ЭДИЙН ЗАСАГ
ЭГИЙН ГОЛ БА МӨРӨӨДӨЛ



ГОВЬ эдийн засгийг өсгөх үү, уруудуулах уу





ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ДЭЛХИЙН ШИЛДГЭЭР ТОДОРЛОО

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Оксфордын олон улсын нэр хүнд бүхий "Европын Бизнесийн Ерөнхий Чуулган" (EBA-European Business Assembly)-аас 2014 оны дэлхийн "Шилдэг Байгууллага"-ын нэгээр Монгол улсаас анх удаа Худалдаа, хөгжлийн банкийг өргөмжиллөө. Уг шалгаруулалтаар бизнесийн үйл ажиллагаагаа амжилттай явуулж буй дэлхийн 32 орны 50 гаруй байгууллага болон шилдэг удирдагчдыг тодруулсан юм.



Дэлхийн Шилдэг байгууллага
"Худалдаа, хөгжлийн банк"

Оны Шилдэг Удирдагч
ХХБ-ны Гүйцэтгэх Захирал
Балбарын Мэдрээ



5-н жилийн хугацаатай "Шилдэг
Байгууллага" бүхий Худалдааны тэмдэг
Худалдаа, Хөгжлийн Банк



ОЛОН УЛСЫН СОКРАТЫН ХОРОО

Олон улсын Сократын хорооноос олгодог Шилдэг удирдагч шагнал нь олон улсын хүрээнд эдийн засаг, улс төр, боловсрол, соёлын салбарын удирдагчдаас өөрийн шаргуу хөдөлмөр, бизнесийн ухаанаараа дэлхийд тэргүүлэгч эрхмүүдэд олгогддог билээ. Энэхүү нэр хүндтэй шагналыг нарийвчилсан сонгон шалгаруулах үйл ажиллагааны дагуу олгодог бөгөөд олон улсын хэмжээнд танилцуулдаг болно.



ЕВРОПЫН БИЗНЕСИЙН ЕРӨНХИЙ ЧУУЛГАН

Европын Бизнесийн Ерөнхий Чуулган (EBA) нь эдийн засаг, нийгэм, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа, хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд шинжлэх ухааны болон эдийн засгийн салбарт гаргасан амжилт, туршлагыг үнэлэн, бизнесийн шилдэг байгууллагуудыг шалгаруулдаг билээ.

Шилдгээр шалгарсан байгууллагуудад олон улсын түвшинд бизнесийн найдвартай түнш болохыг батламжилж, бизнесийн үйл ажиллагаандаа 5-н жилийн турш ашиглах дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн "Худалдааны тэмдэг" олгогдоороо онцлогтой юм.

ХӨГЖИЛД ТЭМҮҮЛЖ, ДЭВШИЛД ХӨТӨЛДӨГ ХАРИЛЦАГЧИДДАА БАЯРЛАЛАА



“ВАГНЕР АЗИ ИНДАСТРИАЛ” ХХК-ийн Албан Ёсны Нээлтийн Арга Хэмжээ



БҮХ ТӨРЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН **ДУУДЛАГА ХУДАЛДАА**

2013 оны 5 сарын 9-ны өдөр, 10.00 цагт
22-ын товчоо дахь “Вагнер Азийн Техник Угсралтын Талбай”-д

Холбоо барих: Б.Энхтулга,
enkhtulga_b@wagnerasia.com, 8808-8142
www.wagnerasia.com
www.wai.mn



WAGNER ASIA
GROUP Ltd.

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын сэтгүүлдийн эвлэлийн
“2013 оны Шилдэг сэтгүүл”

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:

Лиззи Хүү

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

ВЭБ МАСТЕР:

Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барянжав / 9409-2904

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох / 9409-2906

“ECONOMY” ТВ СТУДИ

СЭТГҮҮЛЧ:

Ц.Соёлмаа

ЗУРАГЛААЧ:

Ш.Гантуул

КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:

Т.Баярсайхан

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AV center. 503 тоот

15160 Улаанбаатар,

Төв шуудан, ш/ х-2762


www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn




РЕДАКЦИД
ЗАХИАЛБАЛ
ХҮРГЭЛТ
ҮНЭГҮЙ

MONGOLIAN ECONOMY
ОНЛАЙН СЭТГҮҮЛ
mongolianeconomy.imedia.mn

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ

8 Эдийн засгийг уруудуулсан Монголын улс төр



- 10 Амьдрал ямар байна вэ
- 11 “Өчигдрийн амьдрал мөрөөдөл шиг минь байж ээ”
- 14 Цогтцэцийгээс Гашуунсухайт хүртэлх саарал амьдрал-1
Цэцийчүүдийн ирээдүй манантай байна
- 18 Цогтцэцийгээс Гашуунсухайт хүртэлх саарал амьдрал-2
Нүүрс үнэгүйдэхийн учир
- 21 Б.Батгэрэл: Гаалийн бүрдүүлэлтийг цахим хэлбэрт шилжүүлсэн
- 24 “Хямрал хурцдахын хэрээр шударга бус өрсөлдөөн гаарч байна”
- 31 107-гийн балаг
- 33 Дуусдаггүй хэлэлцээр
- 34 Туркийн бизнесмэнүүдээс Монгол илүү ихийг хүлээж болно
- 36 Тогтоож дийлсэн үү
- 38 Өсөлт саарах ч, хямрах дохио биш
- 40 Эгийн гол ба мөрөөдөл

“ECONOMY” ТВ СТУДИ

“ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ” нэвтрүүлэг

Нэвтрүүлэх суваг: NTV телевиз

Нэвтрүүлэх цаг: 2014.05.06-ны 18.30 цагаас

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МIН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал



facebook.com/Mongolian.Economy



twitter.com/EconomyMongolia



youtube.com/user/MongolianEconomy

Борлуулах цэгүүд:

“Интер ном”
“Цэцэг төв”
“Минж плаза”
“Алтантүлхүүр” номын дэлгүүр
“Номин” супермаркетин бүх салбар
“Макс” супермаркетин бүх салбар
“Фреско” супермаркет
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг
“Гранд Плаза” дахь супермаркет
“Мир” номын дэлгүүрийн
“Grand plaza”
“Metro mall”
“Sky” супермаркет
“Улаанбаатар” их дэлгүүр дэх салбар
“Max mall” салбарууд

МОНГОЛД

Банк, санхүү

Монгол Улсад банкны салбар үүсч хөгжөөд 90 жил болж байна. Энэ сард түүхэн 90 жилийн ойгоо тус салбарынхан тэмдэглэх юм. Үүний сүүлийн 24 жилд нь хоёр шатлалт банкны тогтолцоо бий болж, анхны арилжааны банк байгуулагдсан байдаг. Энэ хугацаанд манай улсад 31 банк байгуулагдсанаас 15 нь дампуурч, гурван банк нэгдэж, өнөөдрийн байдлаар нийт 13 банк үйл ажиллагаа явуулж байна. Банк нь санхүүгийн салбарын 97 хувийг бүрдүүлж, ДНБ-ий 80-90 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг эргэлдүүлж буй.

Бүтээн байгуулалт

Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн 267 км төмөр замын газар шорооны ажил 70 хувьтай явж байна. Одоогоор 173 сая ам.долларын ажил хийгдээд байгаа аж. Дараагийн ээлжийн 200 сая ам.долларын санхүүжилт орж ирээгүй байна. "Монголын төмөр зам" ТӨХК /МТЗ/ компани өөрийн хөрөнгөө барьцаалж банкнаас зээл авч Америкийн "Маккензи" компаниар техник эдийн засгийн үндэслэлээ хийлгэжээ.

Тавантолгой

"Эрдэнэс Тавантолгой" компани Хятадын "Шинхуа энерги" компанид 20 жилийн хугацаанд нэг

тэрбум хүртэл тонн нүүрс нийлүүлэхээр боллоо. Өнгөрсөн сард 450 мянган тонн нүүрсийг 48.5 мянган ам.доллараар борлуулах гэрээ байгуулсан бөгөөд нүүрсний нийт төлбөр нь 21.8 сая ам.доллар аж. Үүний 80 хувь болох 17.4 сая ам.долларыг урьдчилгаа болгон манай талд шилжүүлсэн байна.

Судалгаа

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны дүн гарчээ. Судалгаанд манай улсын нийт өрхийн 86 хувь нь хамрагдсан байна. Ингэснээр 714 мянган өрхийн мэдээллийг амьжиргааны түвшингээр эрэмбэлэн, өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулжээ. Одоогийн байдлаар мэдээллийн нэгдсэн санд багтсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, хүнсний эрхийн бичиг авах нийт 15131 өрхийн 87 мянган иргэнд үйлчилгээ хүргэхээр болжээ. Энэхүү судалгааг Хүн, амын хөгжил, нийгмийн хамгааллын яам хийсэн юм.

Уул уурхай

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаас хойш Монголбанкинд 2.040 кг алт тушаасан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 дахин нэмэгджээ.

Өнгөрсөн оны өдийд Монголбанкинд 1134.5 кг алт тушааж байжээ. Цаашид алтны олборлолтыг нэмэгдүүлэхийн тулд Монголбанк, Эдийн засгийн хөгжлийн яам болон Уул уурхайн яамнаас "Алтны салбарын санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох арга хэмжээ"-ний хөтөлбөрийг батлан гаргажээ. Тус хөтөлбөрт хамрагдахаар "Алт үйлдвэрлэгчдийн холбоо"-ны гишүүн 35 компани хүсэлтээ ирүүлсэн байна. Санхүүжилтийг хоёр үе шаттай олгох аж.

Даатгал

Улсын хэмжээнд даатгалын 17 компани үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн онд даатгалын зах зээл дээр ажиллаж буй компаниудын нийт хөрөнгө 126.4 тэрбум төгрөгт хүрчээ. Хөрөнгийн 20.3 хувийг гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд эзэлж байна. Даатгалын салбарын нийт хураамжийн орлого өнгөрсөн оны эцэст 93.8 тэрбум төгрөгт хүч, 2012 оныхоос 1.2 дахин өссөн байна.

Чингис бонд

Аймгийн төвүүдийг холбох орон нутгийн автозамын төсөлд "Чингис" бондоос нийт 369 тэрбум төгрөг олгожээ. Ингэснээр 1800 км зам баригдахаас 930 км-ыг бүрэн хучиж дуусгасан байна. Үүний 620 гаруй км зам нь шинэ аж. Мөн ойролцоогоор 150 км замын

суурийн ажил хийгдэж, хучилт хийхэд бэлэн болжээ.

Засгийн газар

Засгийн газраас "Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоног" төслөө танилцууллаа. Төсөлд үндэсний үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдээ дэмжих. Уул уурхайн салбар дахь ашигт малтмалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх. Барилга, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарыг эрчимжүүлэх. Эдийн засгийн чадавхыг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалт татах чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөжээ. Тухайлбал, дотоодын ухаалаг хэрэглээг урамшуулах. 100 ам.доллараас дээш хөрөнгө оруулалт татаж буй банк санхүүгийн байгууллагын ашгийн татварыг тэглэх зэргээр бизнес эрхлэгчдэд бодит дэмжлэг үзүүлэх аж.

Хөдөө аж ахуй

Манай улс энэ жил 375 мянган га газарт үр тариа тариалахаас 304 мянган га-д улаанбуудай, 15.5 мянган га-д төмс, 8.1 мянган га-д хүнсний ногоо, үлдсэн талбайд тосны ургамал болон тэжээл тариалах аж. Ийм хэмжээний тариалалт хийснээр 426 мянган тонн улаанбуудай, төмс 198 мянган тонн, хүнсний ногоо 106.8 мянган тонн, малын тэжээл 26 мянган тонныг тус тус хураан авах юм. ▶

ДЭЛХИЙ ДАХИНД

Америк

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама Ази тивийн орнуудад хийсэн айлчлалаа Японоор эхэлсэн. Тэрбээр тус улсад хийсэн айлчлалынхаа үеэр Хятадтай маргаантай асуудлын тал дээр Японы талд зогсоно гэдгээ мэдэгдсэн юм. Тэрбээр Хятадын зүүн тэнгис дэх хэсэг арлын асуудлаар Хятадтай зөрчил үүсвэл АНУ Японд тусламж үзүүлэх үүрэгтэй хэмээн хэлснийг “Телеграф” агентлаг мэдээлжээ. Хойд Солонгос тогтвортой байдалд нь заналхийлж, Хятад өөртөө улам итгэлтэй болж байгаа энэ үед Вашингтон Ази дахь холбоотнуудтайгаа харилцаагаа бэхжүүлэх нь уг айлчлалын зорилго аж.

Хятад

Хятадын эдийн засгийн өсөлтийн оргил үед гол үүрэг гүйцэтгэж байсан Хангжоу хот (Шанхай хотоос урагш 175 км-т байрлах)-ын гангийн болон оёдлын үйлдвэрүүдэд олгох зээл багасах болжээ. Энэ талаар “Ройтерс” агентлаг мэдээлэв. Энэ нь зарим компани зээлээ эргүүлэн төлөх чадваргүй болсонтой холбоотой. Иймээс санхүүгийн боломжтой бусад компани нь хөлд нь чирэгдэж байгаа аж. Хангжоу хот өдгөө найдваргүй зээл бүхий хотуудын жагсаалтын гуравдугаарт оржээ. Тус улсын Засгийн газраас уг хотын Шиаошан

мужыг улсын хэмжээнд хамгийн баян дүүргүүдээс долдугаарт эрэмбэлжээ. Энэ хотын хөгжил, цэцэглэлтийн тулгууруудын нэг нь хувийн жижиг компаниуд. Харин одоо тэд асуудалтай тулгараад байна.

Япон

Өнгөрсөн сард Японд жижиглэнгийн худалдаа хамгийн өндөр буюу сүүлийн 17 жилд байгаагүй үзүүлэлттэй байсныг ВВС мэдээлсэн байна. Жилийн өмнөх мөн үеийнхтэй харьцуулахад өнгөрсөн сард борлуулалт 11 хувиар нэмэгдсэн нь 1997 оноос хойш үзэгдээгүй амжилт болжээ. Энэ оны дөрөвдүгээр сарын 1-нд борлуулалтын албан татвар таван хувь байсныг найман хувь болгон нэмэгдүүлсэн. Энэ нь нэг талаас, улсын өрөө хязгаарлах боломж эрэлхийлсээр ирсэн. Нөгөө талаас, дундаж наслалт нь

нэмэгдэж буй иргэддээ өгөх нийгмийн халамжийн зардал өссөнтэй холбоотой. Тус улсын өр ДНБ-ий 230 хувьтай тэнцэж буй нь үйлдвэржсэн ертөнцдөө хамгийн өндөрт тооцогдож буй.

Их Британи

Английн Ерөнхий сайд Дэвид Камерон Европын холбооны гишүүнчлэлийн асуудлыг дахин хэлэлцэхээ амлажээ. Гэхдээ тэрбээр ирэх онд болох сонгуулиар Консерватив нам нь дахин ялалт байгуулсан тохиолдолд 2017 оны сүүлчээр гишүүнчлэлийн талаарх олон нийтийн санал асуулга явуулна гэв. Камерон ийнхүү мөрий тавьж байгаа нь эдийн засгаараа дэлхийд зургаад эрэмбэлэгдэх 2.5 их наяд ам.доллар бүхий Английн эдийн засгийг Европын холбооноос гаргахад ч хүргэж магад. Үүнд Лондонд төвлөрч буй дэлхийн томоохон банкууд, даатгал

болон хөрөнгө оруулалтын том компаниуд санаа зовж байна.

Орос

Ирэх зургаадугаар сар болтол бодлогын хүүгээ нэмэхгүй хэмээн ОХУ-ын Төвбанкны Ерөнхийлөгч Эльвира Набиуллина мэдэгдэж байв. Гэвч тус банк санаагаа гэнэт өөрчлөн хүүгээ 7.5 хувь болгон нэмэгдүүлжээ. Энэ талаар тайлбарлахдаа инфляци болон эдийн засгийн өсөлтийн хоорондох тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэсэн арга хэмжээ авсан гэв. Гэвч энэ нь зээлийг улам үнэд оруулж, аль хэдийнэ эрчээ алдах болсон эдийн засаг нь бүр ч удаашрах магадлалтай. Бодлогын хүүний ханш 50 суурь оноог давсан байна. Өнгөрсөн гуравдугаар сард бодлогын хүү долоон хувьтай байв. Харин түүний өмнө 5.5 хувьтай байжээ. ■



ӨӨР ӨНЦӨГ

ЭДИЙН ЗАСГИЙГ УРУУДУУЛСАН МОНГОЛЫН УЛС ТӨР



Д.БЭХБАЯР
("Mongolian Economy"
сэтгүүлийн эрхлэгч)

Ард иргэдийг тэнэг мангар хэвээр нь байлгах хэрэгтэй. Цагаан цаасан дээр улс төр хийхэд амар хялбар байдаг. Иргэдийн боловсрол мэдлэггүй байдлыг ашиглаж улс орны өсөн нэмэгдэж буй төсвийн мөнгөнөөс хумслахад улстөрчдийн бодлого чиглэдэг юм гэж нэгэн улстөрч найз эмчдээ ярьжээ. Иргэдийн эрүүл мэндийн манаанд зогсдог эмч хүн эрүүл мэндийн салбарт ийм бодлого, дүрэм хэрэгтэй байгаа талаар улстөрч найз нартайгаа уулзаж, танилцуулахад ийм л утгатай тайлбар сонсдог гэнэ. Иргэд нь улам өвчлөөд, салбар нь саланги бодлоготой үлгэн салган явбал гадаад, дотоодын эх үүсвэрээс орж ирэх мөнгөний хэмжээ ихэсдэг нь тэдэнд хэрэгтэй юм билээ хэмээн манайдаа нэртэй эмчийн ярьсныг би байнга л бичмээр санагдах. Манай бүх л салбарт ийм байдал ажиглагддаг. Эрдэм мэдлэгтэй нь хэлж яриад залхчихсан. Гэхдээ хэвлэл мэдээллийн хувьд байнга л ярьж, бичиж байх нь зөв болов уу.

Монголын улстөрчдийн увайгүй байдлаас улс орны эдийн засаг уруудаж, иргэдийн амьдрал хүндэрч байгаа нь туйлын үнэн. Ер нь үе үеийн Засгийн газрууд Монгол орны хөгжлийн төлөө нэгдсэн нэг сэгтгэлээр зүтгэж ирсэн түүх бий гэж үү. Азаар


дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ өсвөл манай жижиг зах зээлийн байдал дагаад дээрддэг тохиолдлуудаар тухайн үеийн Засгийн газар, эрх баригчид сайн ажилласан мэтээр ярьж өөрсдийгөө дөвийлгөдөг өөдөсхөн бодолтой байсан нь харин үнэн.

Шинэчлэлийн нэртэй засгийн тэргүүн Н.Алтанхуяг эдийн засаг хүнд байгааг дэлхийн зах зээл дээр уул уурхайн зарим бүтээгдэхүүний үнэ унаж, улс орнууд ч хүнд буйтай холбон тайлбарлалаа. Тэгвэл МАН-ын цэгцтэй зөв бодлогоор улс орон хурдацтай хөгжсөн зүйлгүй гэвэл хилсдэхгүй л байх. Энэ хоёр намын УИХ дахь намын бүлгүүдийн дарга Д.Эрдэнэбат, С.Бямбацогт нар Монголын эдийн засгийн чуулганы индэр дээр танай, манай намын буруу, зөв бодлогын үргэлжлэл одоо ч байсаар байна хэмээн УИХ-ын танхим дотор зөрчилддөг шигээ ааш үзүүлэн хуралд оролцогчдын дургүйг хүргэсэн билээ.

Телевизийн камерийн өмнө би чи дээрээ тулсан дүр үзүүлээд хөшигний цаана улс орны аль ашигтай, орлоготой нь хувааж идэх асуудал дээр нэгдэн нийлж сайдалцдаг нь дээрх намуудын үнэн төрх. Үүний жишээ нь Оюутолгой. С.Баярын тэргүүтэй хамтарсан Засгийн газрын үед Оюутолгойн гэрээг хамтдаа хийж, ажлыг эхлүүлсэн. Өнөөдөр танай, манай нам буруутай, гэрээг өөрчилнө, энэ тэр идэж уусан гээд л сууж байна. Тавдугаар цахилгаан станцын төсөл байна. Өмнөх засаг тендер зарлаж асуудлыг шийдсэн ч өнөөдрийн Засгийн газар гарч ирэнгүүт ямар нэгэн шалтаг хэлээд хойшлуулсаар өнөөг хүрээ. Эгийн голын усан цахилгаан станцын төсөл хэдэн засгийн нүүр үзлээ. Оюутолгой, Тавантолгой, Сайшанд, төмөр зам бүгд л зөвхөн улстөржилтөөс

үүдэн зогсонги байдалд орсон төслүүд. Эдгээр төслийг хурдан шийдээд урагш хөдөлгөхгүй мөртлөө гадаадын хөрөнгө оруулагчдыг татах бодлого барьж байгаа гэсэн зүйл ярих. Өнөөдрийн хүндрэлээс гарах хамгийн зөв зам бол Оюутолгойн асуудлыг хурдан шийдээд өгвөл эдийн засаг аяндаа сайжраад ирэх тухайд хувийн хэвшлийнхэн ярьж байна. Хилийн чанадад Монголыг чиглэсэн маш их мөнгө байна. Гагцхүү монгол төрийн тогтвортой байдал, мега төслүүд тэр дундаа Оюутолгойн талаар ямар шийдвэрт хүрэхийг гадаадын хөрөнгө оруулагчид ажиглан сууна. Дэлхийн хэмжээний энэхүү төслийн асуудлыг бүрэн дүүрэн шийдээгүй байхад бид өөр төсөл сонирхоод яах вэ гэсэн хандлага гаднын хөрөнгө оруулагчдад байгаа ба дотоодын бизнесмэнүүд хэлж анхааруулсаар.

Харин улсын төсвийн ихэнхийг бүрдүүлдэг хувийн хэвшлийнхэн элгээрээ мөлхөж эхэллээ. Тэд дэлхийн зах зээл дээрх бүтээгдэхүүний үнэ унаснаас бус дотоодын улс төрийн арчаагүй байдлаас ажиллаж чадахгүйд хүрч байна. Монголын төр хувийн хэвшлийнхнийг дэмжин, тулахаасаа илүүтэй дарамтлан шахаж, айлгаж байна. Дотоодын олон мянган аж ахуйн нэгж хаалгаа барьсан мэдээ бий. Улирал нь эхэлчихээд байхад барилгын компаниудын үйл ажиллагаа идэвхжихгүй байна. Төрөөс хамгийн их дэмжсэн ноос, ноолуурын үйлдвэрүүд 70, 80 хувийн хямдрал зарлаад ч бүтээгдэхүүн нь борлохгүй байгаа тухай манай сэтгүүлийн редакцид зочилсон "Хатан сүлжээ" компанийн захирал Б.Бадамханд яриу. "Бридж" группийн ТУЗ-ийн дарга Л.Даваажаргал "Манай компани том аж ахуйн нэгжид ордог. Хүнд байдалд байна. Ер нь аж ахуйн нэгжүүд ямархуу байгаа нь тодорхой" хэмээн ярих. BSB компанийн хувьд компьютер, тавилгын худалдааны ➤



Шог зургийг А.Амарсайхан

► борлуулалт нь унажээ. “Нарантуул”, “Хүчит шонхор”, “Барс” болон барааны дэлгүүрүүд орлогогүй, зоогийн газрууд ч хоосон байдаг болжээ. Үйлдвэр, компаниуд, иргэд мөнгөгүй байна. Амьдрал ийм байхад улстөрчид дан, давхар дээл, сайдуудыг огцруулна, архи, тамхины хуулийн талаар ярьж, хэрэлдэж, муудалцаж сууна. Яагаад гэвэл УИХ, Засгийн газрын гишүүд эдийн засгийн хүнд байдалд автах хүмүүс биш. Хадгаламжийн дансандаа хэдэн тэрбумаар тоологдох мөнгөтэй хүмүүст дээрх бодит байдал хамаагүй. Харин өөрсдийнх нь эрх ашиг, ар талын бизнест эсрэг асуудал үүсэх вий л гэж санаа зовж, анхаарч явдаг улс. Тамхины тухай хууль ярилцахад асуудалд яаж хандаж буйг иргэд цэнхэр дэлгэцээр харсан биз ээ. Учир нь манай УИХ архи, тамхины бизнес хийдэг, ямар нэг байдлаар холбоо сүлбээтэй хүмүүсээс бүрдэж ирсэн уламжлалтай газар болохоор тэр.

Мөн давхар дээл, архи, тамхины асуудал ярихаар УИХ-ын гишүүдийн ирц 100 хувь болдог. Бусад үед ирц нь

бүрэлдэхгүй, цөөн гишүүн нүүр тахалж сууж харагддаг шүү дээ.

Ерөнхий сайд Н.Алтанхуягийн эдийн засаг ерөнхийдөө гайгүй байгаа гэх утгатай тайлбарыг өнөөдөр хэн ч таатай хүлээн авахгүй. Ялангуяа МАН-ынхан энэ тайлбарыг ихэд онцлон толгой сэгсрэн ярих нь телевизээр харагдах. Сөрөг хүчнийхэнд Монголын эдийн засгийн бодит байдал улс төрийн тоглолт хийх сайхан боломж олгов. Тэд иргэдийнхээ төлөө санаа зовдог, хувийн хэвшлийнхнээ үнэн сэтгэлээсээ ойлгодог, сонсдог, иргэдийн амьдрал дунд ордог дүр эсгэж шоу үзүүлж байна. МАН засгийн эрх авахаараа бас л өнөөгийн эрх баригчид шиг л хувиа хичээн ажилладгийг иргэд хэдийнэ мэддэг болсон тул тэд үнэн, худал төрхийг ялгаж салгаж хардаг болжээ. Ерөнхий сайдын дээрх тайлбарыг нөгөө талаас нь аваад үзвэл Засгийн газрын тэргүүний амнаас унасан үг маш нухацтай байх ёстой цаг ирсэн гэдгийг харуулах мэт. Монголчуудаас гадна хөрөнгө оруулагчид түүний хэлэх үгийг анхааралтай чгнаж

суугаа. Н.Алтанхуяг эдийн засаг хэцүү боллоо, байдал бишдлээ гээд ярихад олон улсын хэвлэлүүд шүүрэн авч нийтлэх бөгөөд энэ нь манай улс руу хөрөнгөө оруулахаар төлөвлөж суугаа хөрөнгө оруулагчдын шийдвэрт хэрхэн нөлөөлөх бол. Монгол дэлхийн нэг хэсэг болжээ гэдэг нь энэ юм. Өмнө нь буюу 2000-гаад онд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын хэлэх үг гадныханд тийм ч хамааралтай байгаагүй билээ. Өдгөө өөр цаг ирснийг намууд, улстөрчид ухамсарлах нь чухал юм. Дэлхийн томоохон компани, группийн захирлууд сонин хэвлэлд ярилцлага өгөөд байдаггүй, ярилаа гэхэд ихэд бодож тунгаасан үг хэлдэг. Захирлын амнаас гарах үг компанийнх нь хувьцааны үнэ ханшийг дээш, доош савлуулдаг учраас нэлээд анхааралтай ханддаг аж. Монголын 100-гаад хүний үгийг гадныхан чих тавин сонсож, анализ хийж, хөрөнгө оруулах эсэхээ шийддэг. Үүний 30 гаруй нь төрийн түшээд, бусад нь хувийн хэвшил, төрийн бус байгууллага, эдийн засагч, хуульч, хэвлэлийнхний төлөөлөл гэнэ. ►►

► Төрийн ордныг цэвэршүүлэх цаг иржээ. Төрийн минь сүлдтэй Ордонд төрийг үймүүлэх, самууруулах, тогтворгүй болгох, төрийн нэрээр орж ирэх мөнгийг луйвардан хувааж авах тухай бодож ярьж явдаг, телевизийн камер харахаараа улсаа, иргэнээ бодсон мэт жүжиглэж, ерөөндөө орохоороо нам, фракц, нутаг нуга ярьж эвлэрдэг, Монголын улстөрчдийн увайгүй энэ байдал эх орны минь хөгжлөөс хойш татсаар. Засаг, төр, нам солиод ч нэмэр алга. Шинэчлэлийн Засгийн газар шинэ цагийн шинэ арга барилаар ажиллах талаараа ярьж гарч ирсэн. Үр дүн нь хэр буйд олон нийт уг нь хоёр жилийн дараа эцсийн дүн тавих ёстой. Гэхдээ яг өнөөдрийн түвшинд иргэдийн зүгээс ямар дүн тавих нь тодорхой. Лав л онцсайн үнэлгээ авахгүй. Ялангуяа хувийн хэвшлийнхэн үгээ хэлчихсэн яваа. Дээр нь АН доторх фракцууд нь зөрчилдөж эхэлж. Ерөнхий сайд Н.Алтанхуяг МАН, Авлигатай тэмцэх газар ажил хийлгэхгүй байна хэмээн ярьсан нь бий. Гэхдээ энэ хоёроос илүүтэй өөрийнх нь нам, фракцууд ажлыг нь санаснаар нь хийлгэхгүй байгаа юм биш үү.

Гуравдагч хүчин гэх улс төрийн намууд нь үлбэгэр сул, боловсон хүчингүй, бас л хэнтэй, ямар намтай нийлж, ямар албан тушаалд очиж хувааж идэж, баяжих уу л гэсэн бодол тээн бор хоногийг өнгөрөөсөн жижиг улс төр хийн явах. Гадаадад, дотоодод боловсрол эзэмшсэн залуусын ихэнх нь амар аргаар мөнгө олж, дарга болохын тулд ихэнхдээ МАН, АН-д элсэхийг хүсэх. Энэ хоёр нам нь Монголын сонин хэвлэл, телевизийг хуваан авчихсан монополий эрхээр өөр өөрсдийн бодлогыг ард иргэдэд тулгах үзэл суртлын нэвтрүүлэг, нийтлэл гаргаж байна. Улс төрөөс хараат бус байх ёстой сэтгүүлчид нь ч хоёр намд хуваагдан орж, өөрсдийн намын бодлого, үйл ажиллагааг хамгаалан бие биенийхээ эсрэг үг чулуулах нь бодит байдал.

Монголын улс төрийн амьдрал ийм байдлаар цааш үргэлжилбэл үндэсний эрх ашиг хэрхэх вэ? Эх орон маань хэзээ хурдацтай хөгжиж, эдийн засаг сайжирч, иргэдийн амьдрал дээшлэх бол оо? ■

ОНЦЛОХ

АМЬДРАЛ ЯМАР БАЙНА ВЭ

И.ОТГОН

Мongolian Economy” сэтгүүлийн шинэ дугаарын голлох нийтлэлүүд эдийн засгийн таагүй байдлыг хэрхэн даван туулах вэ, гарц шийдэл юу байна вэ гэдэгт чиглэлээ. Бид өмнөх дугаартаа иргэдийн аж амьдрал, бодит эдийн засаг ямар байгаа талаар Улаанбаатар хотын томоохон зах, худалдааны төвүүдээс сурвалжлага хийж, олон нийт болон шийдвэр гаргагчдын анхааралд хүргэсэн билээ. Энэ удаагийн дугаартаа мөн иргэдийн тэр дундаа ядуурал ямар байгаа, уул уурхайд түшиглэсэн орон нутгийн аж амьдрал, нүүрсний экспорт ямар байгааг газар дээр нь очиж сурвалжиллаа. Манай сэтгүүлийн сурвалжлах баг өнгөрсөн сарын 14-21-нд Өмнөговь аймгийн Цогтцэций-Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд ажилласан цуврал сурвалжлага, нийтлэл, ярилцлагыг энэ дугаараас эхлэн хүргэж байна.

Мөн бид ядууралд байнга анхаарал хандуулж ирсэн. Тиймээс эдийн засгийн байдал зүтгүү үед иргэдийн аж амьдралыг харуулах зорилгоор жил гаруйн өмнө сэтгүүлдээ бичиж байсан хоёр айлынхаа амьдралыг эргэн сурвалжиллаа. Эдгээр өрхийн амьдрал өнгөрсөн хугацаанд дээрдсэн үү, дордсон уу гэдгийг уншигч Та ч бас сонирхоорой.

Засгийн газраас “Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоног”-ийн арга хэмжээ тогтоолын төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэж эхэллээ. Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногт 23 арга хэмжээ авах санал тусгасан. Тухайлбал, хувийн хэвшлийнхнийг ихээхэн чирэгдүүлдэг төрийн хяналт, шалгалтуудыг хязгаарлах, Ашигт малтмалын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулж, хайгуулын лиценз шинээр өгөх, маргаантай лицензүүдийн асуудлуудыг шийдвэрлэхээр тусгажээ. Мөн жижиг, дунд үйлдвэр, ноос, ноолуурын салбарыг тусгайлан дэмжиж, импортыг орлох экспортыг дэмжсэн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ гэх мэт асуудал багтсан болно.

Түүнчлэн манай сэтгүүл хувийн хэвшлийн салбарт олон жил ажилласан туршлагатай захирлуудын төлөөллийг редакцийн уулзалтад урьж, “Бизнесийн амьдрал” сэдвийн дор өнөөдрийн эдийн засаг, бизнесийн салбарт үүсээд буй нөхцөл байдал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар хэлэлцсэн. Хэлэлцүүлгээс өнөөдөр хувийн хэвшилд ямар бодитой хүндрэл нүүрлээд байгаа болон хүндрэлийг даван туулахын тулд компаниуд ямар стратеги төлөвлөгөөтэй ажиллаж буй, компанийн захирлууд төрийн бизнес дэх оролцоог хэрхэн үзэж байгаа нь манай уншигчдад сонирхолтой байх биз ээ. Тэдний яриа татварын шинэчлэлийг хэрхэн зөв хийх ёстой, “Чингис”, “Самурай” бондын дотоодын үйлдвэрлэлд олгосон мөнгөөр хэрхэн үр бүтээлтэй үйлдвэрлэл эрхлэх, Монголбанкны “Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөр”-өөр бизнесийг дэмжих нь өгөөжтэй юу, монгол хүний ажил хөдөлмөрт хандах хандлага, хүмүүжлийн асуудлыг ч хөндсөн. Баялаг бүтээгчид төр засгийг юу ч хийхгүй байна гэж шүүмжлэхээсээ илүү хямралыг хэрхэн хохирол багатай даван туулах вэ, төрийн зохицуулалтаар бизнесийг хэрхэн дэмжих нь зохистой талаар халуун яриа өрнүүлсэн.

Мэргэн уншигчид маань оюун бодолдоо шүүн тунгаана биз ээ. ■

ЯДУУРАЛ

“ӨЧИГДРИЙН АМЬДРАЛ МӨРӨӨДӨЛ ШИГ МИНЬ БАЙЖ ЭЭ”

ЗОРИГТ

“Mongolian Economy” сэтгүүл иргэдийн амьдрал бодит эдийн засаг ямар байгааг нийслэлийн томоохон зах, худалдааны төвүүдээс сурвалжлага хийж өмнөх дугаараараа хүргэсэн билээ. Харин энэ удаа ядуурал ямар байна вэ гэдгийг гаргахаар бид өнгөрсөн оны хоёрдугаар сард сурвалжлагаар очиж байсан айлуудаараа дахин зочиллоо. Мөн ядуурлын талаар судалдаг судлаач, Санхүү эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн зөвлөх Ж.Дэлгэрсайхантай ярилцсан юм.



Зүүн гар талаас Батболд, Цэвэлмаа, Лхагвасүрэн

Фотог зохиогч

Хуучин дурсамж

Хан-Уул дүүргийн тавдугаар хорооны ойр орчимд хөгшид хүүхэд нарлаж харагдана. Цаг наашилж дулаарсан болоод ч тэрүү архи ууж гудамжинд “тасарсан” хүн ч олширчээ. Тэднийг тоож байгаа хүн алга. Машинтай зарим нь дайрчих шахан давхих аж. Тоож байгаа нь ердөө золбин ноход бөгөөд “тасарсан” нөхдүүдийг үнэрлэхээд л яваад өгнө. Энэ

мэтийг ажиглан гэр хорооллын гудамжаар явсаар Яармагийн долдугаар гудамжны 201 тоотод амьдардаг Ц.Батболдын ирлээ. Өнгөрсөн оны хоёрдугаар сард ирэхэд бүтэн байсан хашааны хаалга нь эвдэрчихэж. Хэмхэрхий хашаанаас 40 орчим насны согтуу гурван залуу гуйвсаар гарч ирээд нэгнийгээ шоолон инээлдэнэ. Тэднээс Батболдын хүн байгаа эсэхийг лавлахад тоож байгаа нь үгүй.

Гэрэл муутай навтгар байшинд явж ороход гэрийн эзэн Батболд зүүн талын орон дээр унтаж байлаа. Одоогоос долоон жилийн өмнө цус харвасан Цэвэлмаа эгч болон Батболдын дүү Лхагвасүрэн нар байсангүй. Батболдыг дуудсан боловч сэрсэнгүй. Гэрийн байр байдлыг ажиглавал бүх зүйл хуучин янзаараа. Хир даг болсон хоёр ор, хэзээ хамгийн сүүлд цэвэрлэсэн бол гэж бодмоор ширээ. Хөг нь гарсан банзан гитар. Эвгүй үнэр, хөөтэй зуух, халтар цонх гээд өмнө нь намайг энд ирэхэд ямар байсан яг л тэр хэвээрэй. Нохой хуцах чимээнээр цонхоор харвал Лхагвасүрэн охин Намуунаатайгаа ирж байна. Араас нь Цэвэлмаа эгч орж ирлээ. Тэдний амьдрал улам л дорджээ. Батболд татаж унадаг өвчтэй тул ажил эрхлэх боломжгүй. Лхагвасүрэн бүсгүй төмөр замын ослын улмаас гаргүй болсон тул мөн л эрхэлсэн ажилгүй. Цэвэлмаа эгчийн хувьд нэг үеэ бодвол хүний туслалцаагүй явж чаддаг болсон хэдий ч юм ярьж чадахгүй хэвээрээ бөгөөд ойрын үед ухаан санаа нь орж гардаг болсон гэнэ. Лхагвасүрэн “Амьдрал улам л хэцүү болоод байна. Чамайг жил гаруйн өмнө ирэхэд бидэнд хорооноос улиралдаа нэг удаа үхрийн мах, шуудай гурил, нэмэлт тэжээл өгдөг байсан бол одоо бүр өгөхөө байсан. Хажуу өрөөгөө түрээслүүлээд хэдэн төгрөг олчихдог байсан чинь ойрын хэдэн сар өрөө түрээслэдэг эмээ, өвөө хоёр мөнгөө өгч чадахгүй болсон. Тэтгэврийн хэд нь цахилгааны мөнгөнөөсөө дээшээ гарахгүй байгаа бололтой” гэв. Энэ өрх тавдугаар хороондоо нэн ядуу ангилалд ордог. Гэхдээ сарын орлого нь овоо байсан санагдана. Тухайлбал, ▶

▶ Цэвэлмаа гуайн 240 мянган төгрөгийн тэтгэвэр, улсаас өгч буй хүүхдийн мөнгө болох 20 мянга, Лхагвасүрэн, Батболд нарын халамж нийтдээ 206 мянга, хажуу өрөөний түрээс сарын 30 мянга гээд нийлүүлээд тооцвол 500 гаруй мянган төгрөгийн сарын орлоготой байсан юм. Тиймдээ ч тэд жил гаруйн өмнө өдөрт хоёр удаа хоол хийж иддэг. Баярын өдрүүдээр сүүтэй цай чанаад уучихдаг байжээ. Харин одоо мах авч чадахгүй болсон тул малын дотор гэдэсний өвдөл цөвдлийг нийлүүлсэн “жижиглэн” идэж байгаа аж. Батболд “Хонотг ганц л удаа хоол идэж байна. Хоёрдугаар гурил, 800 төгрөгийн “жижиглэн” буюу муухайгаар хэлбэл нохойн хоол сайхнаар хэлбэр дотор гэдэсний цуглуулгаар бор ходоодоо дүүргэж байна ш дээ. Хүнсний ногоо авах чинь мөрөөдөл болсон. Өмнө нь чамайг ирж сурвалжлага авч байхад мөрөөдлийн амьдралаар амьдарч байсан юм шиг санагдаж байна. Өнгөрдөг өвлийг арай л гэж давлаа. Хорооноос нүүрсний, хүнсний тасалбар өгнө гээд байсан боловч өгөөгүй” гэсэн юм. Уг нь улсаас өгдөг халамжийн мөнгө болон тэтгэврийн хэмжээ тус тус 11 мянган төгрөгөөр нэмэгджээ. Гэтэл Батболдын гэр бүлийн амьдрал улам л ядуураад байдаг. Арга ч үгүй биз. Жилийн өмнө 25 килограммын шуудайтай нэгдүгээр гурил 15 мянган төгрөгийн үнэтэй байсан бол өнөөдөр 19 мянга болчихжээ. Импортын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хувьд ярих ч юм биш. Дээрээс нь тэдний хэлж байгаагаар амьдралд нь том нэмэр болдог байсан хорооноос үзүүлдэг тусламж нь алга болчихоор байдал улам дордох нь ойлгомжтой. Мөн жил гаруйн өмнө ээжийгээ эмчлүүлэх гэж зээлсэн мөнгө, өнгөрдөг өвөл нүүрс зээлээр авсан өрөө төлөх гээд тэдний хувьд зарлага мунддаггүй аж. Тус хэсгийн ахлагч Н.Соёлчимэгээс Батболдын хорооноос тусламж яагаад үзүүлэхгүй байгаа талаар тодруулахад “Тусламж буурсан болохоос огт өгөхөө больсон хэрэг биш. Буурсны учир нь гаднын тусламжийн байгууллагын хандив болон бусад төрлийн тусламж, үйлчилгээ буурсантай холбоотой. Нөгөө талдаа төрөөс өгч байгаа хөнгөлөлтийн тасалбарыг тараадаг боловч заримдаа хүрэлцдэггүй. Мөн авсан нэг нь архины мөнгөнөөс өгчих нь энүүхэнд” гэв. Харин Лхагвасүрэнгийн хэлснээр ер нь сүүлийн үед төр ядуу

иргэддээ хатуурхдаг болжээ. Адаглаад Цэвэлмаа гуайг харах хүнтэй учраас хорооноос өгдөг зарим тусламжаас хассан аж. Мөн Лхагвасүрэн, Батболд нарыг ажил хий гэж хорооны ажилчид нь дүрэмддэг аж. Гэтэл цагаа тулахаар ажилд авдаг газар олдохгүй байгааг тэрбээр учирласан юм. Лхагвасүрэн “Ахыг ажилд орох гэхээр 40 гарчихсан архичин хар юм гээд авахгүй. Намайг болохоор бохир заваан, нэг гаргүй гээд хөөгөөд гаргадаг. Тийм байхад яаж ажил хийх юм бэ. Хэрвээ биднийг үнэхээр ажил хий гээд байгаа юм бол төрөөс бидэн шиг хүн хийж болдог ажил гаргаад өг л дөө” хэмээн уурсангуй хэлсэн юм. Харин нэг сайшаалтай зүйл нь жил гаруйн өмнө сурвалжлагаар ирэхэд Батболд долоо хоногтоо 3-4 удаа архи уучихдаг байсан бол сүүлийн хагас жил архи амсаагүй гэнэ. Өчигдөр

гэхэд нэг найзынхаа оронд манаачийн ажил хийгээд архи өгөхөд нь авалгүй 10 мянган төгрөгөө нэхсээр байгаад авсан аж. Тэр мөнгөнөөсөө Лхагвасүрэнгийн охин Намуунд ундаа авч өгчээ. Намуун охин хуванцар савтай жүүснээс нэг том балгасанаа бүрэн залгилгүй талыг нь буцааж ундааны савандаа хийж харагдана. Учрыг нь асуувал “Ундаагаа том балгаж уугаад байвал хурдан дуусчихна” гэж хариуллаа. Тэрбээр “Ойрын үед амттай зүйл идээгүй. Ээждээ алим идмээр байгаагаа хэлсэн боловч авч өгөөгүй” хэмээн гомдоллоо. Охиныхоо энэ үгийг сонссон Лхагвасүрэн бүсгүй тамхи асааж харагдана. Хааяа нэг архи уучихдаг байсан тэрбээр уухаа бүр больсон гэнэ. Харин тамхи сорчихдог болжээ. Тэр тамхи татахаар тайвширдаг тухай ярьж байлаа.

Ж.Дэлгэрсайхан: /Санхүү эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн зөвлөх/

Нөхцөл байдал

-Ядуурал бол үе үеийн Засгийн газрын ужгирсан буруу бодлогын үр дүн юм. Дотоодын нийт бүтээгдэхүүн өсч, уул уурхай дагасан эдийн засгийн өндөр өсөлт бий болсон ч ядуурлыг бууруулж чадаагүй хэвээр л байна. Энэ нь уул уурхайн баялгаас орж ирсэн мөнгийг нийгэмд тэгш хуваарилах төрийн мөнгө санхүүгийн, нийгмийн халамжийн, төсвийн бодлого нь буруу явж ирсэнтэй холбоотой. Үүн дээр нэмэгдээд энэ Засгийн газар валютын ханшийг алдчихлаа. Валютын ханшийн савалгаа нь угаасаа ядууралтай байсан эмзэг хэсгийг улам л ядууруулж байна. Үүнийг батлахын тулд хэдхэн жишээ дурдаж болно. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, иргэдийн орлогын өсөлтийг харьцуулаад харахад л ойлгомжтой. Цаашдаа ч гэсэн нөхцөл байдал улам муудах төлөвтэй байна.

БАРИМТ ҮСХ /2013 оны жилийн эцсийн тайлангаар Монгол улсын нэг өрхийн дундаж орлого 959247 төгрөг байна гэж гарчээ. Мэдээж орлогын хамгийн их хэсгийг нь буюу 45.8 хувийг цалин хөлс бүрдүүлж байна. Тэгвэл нэг өрхийн дундаж зарлага нь 961677 төгрөг байгаа юм. Зарлагын ихэнх буюу 64.4 хувийг хүнсний бус бараа үйлчилгээнд зарцуулж байгаа бол 23.5 хувийг хүнсний бүтээгдэхүүн буюу хоол хүнсэндээ зарцуулдаг байна. Харин ядуу иргэдийн хувьд үүнээс хэд дахин бага орлоготой./

Гарц

-Ажил хийх сонирхолтой иргэдийг төрөөс дэмжих хэрэгтэй. Байгаа хуулийнхаа хүрээнд төрөөс авч хэрэгжүүлж болох олон арга зам бий. Тухайлбал, хөдөлмөрийн хуулинд зааснаар аливаа байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлуулах үүрэгтэй. Тэр үүргийнх нь дагуу төрөөс хяналтаа тавиад явчихад хэчнээн хүн ажилтай болох бол. Нийгмийн эмзэг хэсгийг дэмжих хэрэгтэй гэхээр л шууд утгаар нь дэмжих буюу халамж өгөх гэж ойлгоод байдаг. Гэтэл дам утгаар нь хэрхэн дэмжих вэ гэдэгт төрөөс анхаарал хандуулахгүй байна. ▶▶

▸ Ядуурал гэдэг мөнгөгүй байхын нэр биш

Бидний дараагийн зорьсон айл бол Б.Батмандалынх юм. Зах замбараагүй гэр хорооллын пургисан их шороон дундаас зорьсон айлаа олно гэдэг өвсөн дундаас зүү хайхтай адил хэцүү байсан гэхэд дэгсдүүлсэн болохгүй болов уу. Арга ядаад Хан-Уул дүүргийн тавдугаар хорооны байранд ирж тэднийг сураглахаар ортол аз болж тэнд Батмандал компьютерийн ард инээмсэглээд сууж байлаа. Өдөр бүр гурилтай шөлнөөс өөр хоол иддэггүй, сарын дундаж орлого нь 220 мянган төгрөг байсан Батмандалынх өдгөө өөдөлжээ. Ээжийнхээ гэрт амьдардаг байсан тэрбээр Яармагийн хуучин эцэст өрх тусгаарласан гэнэ. Жил гаруйн өмнө гэр бүлийн хүнтэйгээ хамт дээд сургуульд сурдаг байсан бол өдгөө төгсөөд дор бүрнээ ажилтай болцгоосон байна. Эхнэр Мөнхзаяа, дөрвөн настай охины хамт ам бүл гурвуулаа амьдардаг энэ өрхийн сарын дундаж орлого 800 орчим мянган төгрөг болж өсчээ. Батмандал “Нэг үеэ бодвол амьдрал харьцангуй дээрдсэн. Би “Ард даатгал” компанийн жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хариуцсан мэргэжилтнээр сүүлийн нэг сар ажиллаж байна. Хэрвээ сайн ажиллавал жинхэлнэ. Эхнэр англи хэлний сургалт болон мэргэжлийн зөвлөгөө өгдөг компанид ажиллаж байгаа. Одоогоор өөрсдийнхөө хэмжээнд болоод л байна” гэв.



Б.Батмандал

Тэрбээр ажлын байрандаа байгаа тул надтай ярилцах цаг зав гаргаж чадсангүй. Харин ээж Н.Соёлчимэгийг дуудаж өгсөн юм. Соёлчимэг эгч өдгөө ганцаараа амьдарч байгаа ажээ. Тэрбээр “Өө эгч нь одоо бол ганц биеийн жаргал эдэлж байна. Үр хүүхдүүд өрх тусгаарлаад ажилтай болсон. Дээрээс нь эгч нь хэсгийн ахлагчаа хийгээд сарын 192 мянган төгрөгийн цалингаа авчихна. Ганц

хүнд энэ мөнгө хангалттай хүрээд байна” гэв. Ганцаараа амьдардаг болсноос хойш Соёлчимэг эгч өөрийгөө хөгжүүлэхэд ихээхэн анхаардаг болжээ. Одоогоор компьютерийн дамжаа, жолооны курсд суухаар төлөвлөсөн гэнэ. Өнгөрсөн хагас жилийн хугацаанд эрүүл мэнддээ ихээхэн анхаарчээ. Бүх төрлийн хавдрын болоод бас бус шинжилгээг бүгдийг нь өгсөн байна.

Шинжилгээ нь санасныг бодвол сайн гарсан болохоор сэтгэл санаа нь тун өөдрөг байлаа. Гэхдээ харьяа дүүргийнхээ эмнэлэгт хэвтээд авчээ. Мөн мэдлэгийнхээ хүрээг тэлэхэд анхаардаг болсон гэнэ. Адаглаад хэрэглээний англи хэл сурах зорилго өмнөө тавьсан байна. Мөн мод



Н.Соёлчимэг

тарих, элдэв төрлийн хурал зөвлөлгөөнд хамрагдах гээд нийгмийн идэвх нь ч дээшилсэн аж. Түүний нийгмийн идэвх дээшлэхийн хэрээр төр засагтаа дайх

үг ч бас олширсон гэдгийг дурдаж байлаа. Ядуурал гэдэг зөвхөн мөнгөгүй байхын нэр биш юм. Харин эрүүл мэнд, боловсрол гээд хүний амьдралд нэн шаардлагатай чухал зүйлс дутагдах ч гэсэн ядуурал гэдгийг тэрбээр ойлгосон аж. Соёлчимэг “Өнөөдөр нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээг төрөөс иргэн бүрт хүргэхэд анхаармаар байна. Тухайлбал, хороо бүрт шүдний эмнэлэг нээж өгөх хэрэгтэй. Манай хорооны иргэдийн 70-80 хувь нь шүдний өвчтэй. Мөн зарим нэг өвчний нарийн шинжилгээг эндээ хийдэг болмоор байна. Мөн амжиргааны түвшин доогуур иргэдэд хөнгөлөлттэй үнээр хэрвээ болдог бол үнэгүй үзлэг оношилгоо хийдэг баймаар. Эм тарааж өгөх кампанит ажлыг төрөөс хийж болдоггүй юм болов уу. Тэгэхгүй бол эрүүл мэнд нь дорой хүн ажил хийж чадахгүй. Ажилгүй бол энэ нийгэмд амьдрах нөхцөл алга. Юмны үнэ нь хоног хоногоор өсч байхад иргэдийнх нь орлого их байдаг гэр хорооллын ядуурал их байдаг гэр хорооллын иргэдийн амьдрал улам л муудсаар байгааг төр засгийнханд хэлмээр байна” гэсэн юм. Энэ мэтийг хуучлаад тэрбээр ажилтай хэмээн яаран одлоо.

Ж.Дэлгэрсайхан: /Санхүү эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн зөвлөх/

Шийдэл

-Өндөр хөгжилд хүрсэн орны хувьд иргэдийнх нь амжиргааны түвшин ромбо хэлбэртэй байдаг. Энэ нь дундаж давхарга нь их гэсэн үг юм. Гэтэл манай орон пирамид хэлбэртэй. Энэ нь дээд хэсэгт нь цөөхөн хэмжээний баячууд маш их хэмжээний хөрөнгөтэй. Дундаж давхрага нь цөөхөн, доод хэсэгт нь бага орлоготой ядуу иргэд маш их байдаг гэсэн үг юм. Тиймээс төрөөс дундаж давхаргыг бий болгоход анхаармаар байна. Мөн төрийн бодлогын хэмжээнд бүсчилсэн хөгжлийг бий болгох хэрэгтэй. Энэ бодлогыг аль ч Засгийн газар гарсан дурсдаггүй. Орон нутгийн иргэд хотод ихээр ирж байна. Гэтэл тэдгээр иргэд гэр хорооллыг тэлж, ядуу иргэдийн тоог л нэмдэг. Нийгмийн үзүүлэлт муудаж байгаа томоохон шалтгааны нэг бол энэ. Тиймээс иргэдэд орон нутагт сайхан амьдрах боломжийг бүрдүүлж өгөх хэрэгтэй. Мөн ядуурлын түвшин ядуурлыг бууруулахын тулд богино дунд урт хугацааны бодлоготой байх учиртай. Түүнээс биш, цаг зуурын бодлогоор ядуурал буурахгүй. Мөн хэн нэгэн улстөрчийн хэрэгтэй үедээ гаргаж ирдэг тоо баймааргүй байна. Нарийн тооцож гаргадаг судалгаатай түүндээ тулгуурласан бодлоготой байх нь ядуурлыг бууруулах чухал алхам юм.

БАРИМТ ҮСХ /Ядуурлын судалгааг хоёр жил тутам гаргадаг. Монгол Улсад ядуурлын төвшин 2010 онд 38.7 хувь байсан бол 2012 онд 27.41 хувь болж 11 нэгжээр буурсан байна. Албан бус судалгаагаар манай улсын ядуурлын гүнзгийрэл 29 хувьтай байна. Энэ нь нийт ядуу иргэдийг 100 хувь гэж үзвэл түүний 30 орчим хувь нэн ядуу гэсэн үг юм./ ■

ТОМИЛОЛТ

ЦОГТЦЭЦИЙГЭЭС ГАШУУНСУХАЙТ



Өмнийн говь газрын доорх баялгаараа олон улсад Монголыг таниулаад байгаа. Баялгаасаа

болж баларсан хийгээд манлайлан хөгжсөн дэлхийн олон улс бий. Харин манайх үүний аль нь болох бол. Хэдийгээр уул уурхай улс орны эдийн засгийн чадавхыг дээшлүүлж, хөгжлийн шинэ чиг хандлагыг бий болгож буй ч бусдын алдаанаас суралцаж, хөгжил өөд тэмүүлэхэд бид анхаарах ёстой. Баялаг шавхагдаад дуусахад ухаж сэндиичсэн нүх, овоолсон шорооноос өөр зүйлгүй үлдэхгүйн тулд уул уурхайд хариуцлагатай хандах нь чухал болоод буй. Өөрөөр хэлбэл, манайхан эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг бодон гаднынханд найр тавих биш, бүх асуудалд нарийвчилсан төлөвлөгөөгөөр явах шаардлага амьдралаас урган гарч ирж байна. Тиймээс уул уурхайд түшиглэн хөгжиж буй хөдөө орон нутгийн аж амьдрал бодит байдал дээр ямар байгааг “Mongolian Economy” сэтгүүл энэ удаа хөндөн цуврал сурвалжлага бэлтгэсэнээ уншигч таны өмнө дэлгэе.



ЦЭЦИЙЧҮҮДИЙН ИРЭЭДҮЙ МАНАНТАЙ БАЙНА

С.БАТЗАЯА

Ойр орчмын зүйл харагдахгүй, битүү тоосон хөшиг татжээ. Энэ замаар адуун сүрэг дөнгөж сая давхиад өнгөрч дээ гэж эхэндээ бодов. Төд удалгүй агаар дахь тоос шороо замхарч, ойролцоох юмс тодров. Дөрвөн зүг ээлжлэн нүдээ бэлчээвэл бүх зүйлс ундуй сундуй, гудамж, хороолол, байшин барилга ч эмх цэгцгүй аж. Бөртийх ч үүлгүй цэлмэг тэнгэр хормын дотор орвонгоороо эргэж, хуй эрчлэн эргэлдсээр орчин тойрныхоо хамаг юмсыг хаман одно. Өдөр бүр ийм дүр зурагтай нүүр тулан амьдардаг хүмүүс бол Өмнөговь аймгийн Цогтцэций сумынхан.

Говийн наран үүр хаяарахтай зэрэгцэн манддаг аж. Алтан шар нарны тусгал тал газрын хөрсөн дээр тусахыг хараад говь нутгаар бахархах сэтгэл төрнө. Гэвч үүрийн гэгээ орсон үеэс эхлэн говийнхон тоос шороо, хуй салхин дунд амьдрах. Нарийн ширхэгтэй шороо пургиж, цагаан тоос манарах нь хэвийн үзэгдэл болсон учраас хүмүүс нь ч дасан зохицсон аж. Үүнээс болж малын уушиг, дотор муудсан жишээ

бишгүй олон бийг малчдын төлөөлөл хэлж байсан. Цогтцэций 10 жилийн өмнө Монголын хөдөөгийн жирийн нэг сум байсан бол өдгөө аймаг, дүүргээс дутахааргүй олон хүн холхисон их хөлийн газар болжээ.

Мэдээж энэ газарт манай улсыг дэлхий дахинд таниулаад буй Тавантолгойн орд байдагтай холбоотой. Энд орон нутгийн “Тавантолгой”, “Эрдэнэс Тавантолгой”, “Ухаахудаг” гээд Монголын нүүрсний томоохон гурван уурхай олборлолт явуулдаг. Эдгээр уурхайд туслан гүйцэтгэгчээр ажиллаж буй орон нутагт татвар төлдөг аж ахуйн нэгж олон. Сумын татварын албанд бүртгэлтэй 300 орчим аж ахуйн нэгж байдгаас идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг нь 240 гаруй аж. Суманд ийм тооны аж ахуйн нэгж байна гэдэг маш том тоо. Эдгээрийн ихэнх нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Уул уурхайг дагаад ажлын байр, хөл хөдөлгөөн бий болсноор иргэдийн амьжиргааны түвшин, хөгжил цэцэглэлтэд эерэгээр нөлөөлдөг гэх ч тус сумын хувьд тийм биш байв.

6000 гаруй хүнтэй Цогтцэцийд ▶

ХҮРТЭЛХ СААРАЛ АМЬДРАЛ-1



“Мөрөөдөл” цэцэрлэгийн гаднах талбай



Фотог Зохиогч

явуулын 15 мянган хүн ирэн очин амьдардаг. Сумын хэмжээнд 1000 гаруй автомашин бүртгэлтэй. Өдөрт тийм хэмжээний тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцдог байна. Гэтэл ердөө 12-хон км засмал замтай. Суманд ахадсан гэмээр олон төмөр хүлэг давхилдах учир тоос шороо дийлдэхгүй байх нь аргагүй аж. Дээрээс нь говийн хөрс зөөлөн. Цайны газрынхан ширээгээ арчаад төд удалгүй харахад л хуруу зузаан тоос тогтсон байдаг тухай зовлонгоо тоочиж байв. Ус нь хатуулаг ихтэй учир ундандаа хэрэглэх нь учир дутагдалтай гэсэн дүгнэлтийг холбогдох газраас гаргажээ. Гэсэн ч үүнээс өөр сонголт говийнхонд үгүй учир гүний худгийнхаа усыг цэвэршүүлэн хэрэглэдэг байна. Энд литр ус хоёр төгрөг. Сумын төвийн төв хэсгийн худгууд усаа сайн шүүдэг учир ундандаа хэрэглэхэд асуудалгүй гэсэн. Харин захдуу байрлах худгийн уснаас хужир амтагддаг талаар нутгийн иргэд өгүүлж байлаа. Уул уурхай эрчимтэй хөгжиж эхэлсэн жилүүдэд мөнгөтэй нэг нь дуртай газраа барилга барьсан нь сумыг эмх замбараагүй, төлөвлөлтгүй болгосон гэх. Сумын нийт нутаг дэвсгэрийн талбай 7242 ам.км ч гудамжууд нь ямар ч зохион байгуулалтгүй аж.

Ус ашиглах талаар судалгаа байхгүй

Уул уурхайн баялагтай сум хамгийн их байгаль орчноо сүйтгүүлдэг нь

бичигдээгүй хууль. Бэлчээрийн доройтол, усны хомсдолоос эхлээд цэцийчүүдийн зовлон мундахгүй их аж. Хэдэн жилийн өмнө 50 гаруй булаг шанд байсан бол одоо гарын арван хуруунд багтахаар цөөхөн болжээ. Одоогийн байдлаар 12-13 худаг усгүй болж. Харин “Энержи Ресурс” компанийнхан тус сумын төв дээр хоёр худаг барьж, орон нутгийн ахуйн үйлчилгээний “Цог-Өрнөх” компанийн мэдэлд бүрэн шилжүүлэн өгчээ.

Гэсэн ч усны нөөцөө хамгаалахын тулд Өмнөговь аймгийн ИТХ хуралдаж, 2016 оны нэгдүгээр сарын 1-нээс уул уурхайд Балгасын улаан нуурын ус хэрэглүүлэхгүй байх тогтоол гаргаж. Гэтэл улс орны эдийн засгийн чадавхийг сайжруулах хамгийн чухал зүйл нь уул уурхайн салбар. Тиймээс говьд байгаа байгалийн баялгийг ашиглахаас өөр аргагүй. Ашиглахын тулд “Та нар энэ тогтоолоо эргэж хараач ээ” гэсэн лүндэнг Засгийн газраас Өмнөговь аймгийн ИТХ-д буулгажээ. Үүнийг харгалзан үзээд цуцлахаар болоод буй аж. Учир нь, улсын төсвийн орлогын тодорхой хувийг уул уурхайгаас бүрдүүлж байгаа нь шийдвэрээсээ буцахад нөлөөлжээ. Энэ асуудалд сумын Засаг дарга Н.Амгалан “Тогтолцоо нь буруу яваад буй учраас бүх зүйл эсрэгээрээ байна. Уул уурхайн хөгжлийг дагаад сумд хөгжих учиртай. Гэтэл бүх зүйл эсрэгээрээ байгаа учраас орон нутаг уул уурхайгаа ашиглуулах сонирхолгүй болчихдог юм байна” хэмээв.

Усгүйн зовлонг говийнхон л мэднэ гэж монголчууд ярьдаг. Уул уурхай хөгжиж, амьдрал дээшилсэн орчин цагт тэд усны гачланг бүр ч илүү мэдэрч сууна. Монголчууд хэдийгээр хар ус харамладаггүй гэж ярьдаг ч говийнхны хувьд өөр. Тавантолгой, Оюутолгойн ордыг түшиглэн олборлох, баяжуулах үйлдвэр, цахилгаан, дулааны станц зэрэг усны хэрэглээ өндөртэй үйлдвэрүүд баригдах тооцоо бий. Эдгээр ордын усны хэрэгцээг газрын гүний усаар хангахаар төлөвлөсөн. Эрдэнэс Тавантолгойн ордын усны хэрэгцээг “Балгасын улаан нуур”-ын усны орд газраас хангахаар болоод байгаа. Усны нарийвчилсан хайгуул судалгаа хийх шаардлагатайг усны мэргэжилтнүүд хэлдэг ч өнөөдрийн байдлаар ямар нэгэн тоймтой шинэ судалгаа гараагүй байгаа аж.

Цогтцэций аймагтаа хамгийн цөөхөн малтай сумын нэг. Нийт 65 мянган тоо толгой малтай. Орон нутгийн Тавантолгой компани 50 орчим жил ажиллаж буй. Тухайн үед ойролцоох гурван аймгийг нүүрсээр хангадаг байснаас тоосжилт, зам харгуй бий болсон учир мал аж ахуй хөгжихөд халтай байжээ. Улмаар 2005 оноос уул уурхай эрчимжиж, тоосжилт ихэссэн байна. Үүнээс дайжиж малчдын олонх нь уул уурхайн олборлолт явуулдаггүй хэсэг рүү суурьшиж эхэлжээ. Харин энэ газарт Гашуунсухайт-Тавантолгой чиглэлийн төмөр зам тавих гэж буй нь гал дээр тос нэмсэн явдал болсон гэнэ. Төмөр зам малын бэлчээрээр ►►

► дайрч буй нь малчдыг тэнд амьдрах аргагүйд хүргэж байгаа аж. Тиймээс тэд төмөр замыг нутгийн хойд хэсгээр тавих хэрэгтэй гэж үзэж байна.

Уул уурхай юу, эрүүл мэнд үү

Хөгжиж цэцэглэх газрын хүн амын эрүүл мэнд дэндүү бараан байна. Үүнийг цэцийгийн гурван хүн тутмын нэг нь амьсгалын замын, хоёр хүний нэг нь харшилтай гэдгээс харж болно. Уг судалгааг орон нутгийн холбогдох байгууллагаас гаргасан байна. Тоосжилтоос үүдсэн амьсгалын замын өвчлөл хүн амын дунд хамгийн их аж.

Тэр дундаа бага насны хүүхдүүд илүү өртөмтгий гэнэ. Хүн ам олноор төвлөрч буй учир сумын эмнэлэг 2012 оноос Сум дундын эмнэлэг болон өргөжжээ. Гэсэн хэдий ч хуучин барилгадаа үйл ажиллагаа явуулж байгаа учир хүчин чадал муутай юм. Нэг давхар навтгар цагаан байшинд олон хүнд үйлчлэхэд дэндүү давчуухан. Хэвтэн эмчлүүлэх наймхан ортой. Үүний хоёрт нь хүүхэд, хоёрт нь төрөх эхчүүдийг хүлээн авдаг. Агаарын бохирдол их учраас 0-5 насны хүүхдүүдийн дундах амьсгалын замын өвчин нийт өвчлөлийн 60 хувийг эзэлдэг байна. Ялангуяа өвөл, хаврын улиралд өвчлөл ихэсдэг гэх. Тус эмнэлэг хүүхэд, дотор, сүрьеэ, лабораторийн зэрэг 10 их эмчтэй. Суманд анх удаа лабораторийн их эмчтэй болж, есөн төрлийн шинжилгээ хийж буй аж. “Хүмүүс осол гэмтэлд өртөж, хөдөлмөрийн чадвараа алдаж байгаа нь харамсалтай. Манайд мэдээгүйжүүлэлтийн эмч, аппарат хэрэгтэй байна. Мөн зөөврийн рентген шаардлагатай. Ийм аппаратгүйгээс хатгаатай хүүхдийг таних боломж хомс юм. Шүд амны хөндийн өвчлөл ч хүүхдүүдийн дунд өндөр байна” хэмээн тус сумын эмнэлгийн эрхлэгч Д.Дэлгэрмаа ярьсан.

2011 онд 356, өнгөрсөн жил 187 осол бүртгэгджээ. Нэг

үеэ бодвол буурч буй ч ахуйн гаралтай гэмтэл өндөр аж. Шилжилт хөдөлгөөн их учраас БЗХӨ ч өндөр хувийг эзэлдэг байна. Түүнчлэн зүрх судасны өвчлөл дээгүүрт тооцогддог. Үүнд компаниуд 12 цагаар ажиллуулдаг, хувь хүний ажил амьдралын дадал зуршил нөлөөлдөг гэх.

Сумын төвөөс долоон км-ийн зайд “Энержи ресурс” компани олборлолт явуулж байна. Ядаж байхад уурхай салхин талдаа байрлах аж. Өдөр шөнөгүй хөрс хуулалт явагдаж буй учраас дуу чимээ ихтэй. Аргаа барсан цэцийчүүд “Ашигт малтмалын тухай хуульд хүн ам төвлөрсөн газар уул уурхай ашиглах зөвшөөрөл өгөхгүй баймаар байна. Зөвшөөрөл өгч байгаа нь биш нутгийн иргэд хохирч үлдэнэ. 1966 онд анх уурхай байгуулагдахад сумын төвөөс 15 км-ийн цаана үйл ажиллагаагаа эхэлж байсан. Одоо дүрэм журам нь өөр болж” хэмээн бухимдангуй өгүүлж байсан.

Энэ чиглэлийн хуульд инээдтэй ч юм шиг эмгэнэлтэй ч гэмээр сонин заалт байдаг аж. Дээрх гурван уурхайг агаар бохирдуулагч гэж үзэн нэг кг нүүрснээс нэг төгрөг “Цэвэр агаар” сангийн дансанд ордог гэнэ. Энэ мөнгөөр нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахаар Засгийн газраас утаагүй зуух, шахмал түлш гэх мэтийн аар саархан ажил хийдэг. Гэтэл агаар бохирдож буй газар нь Цогтцэций. Татварын бодлого нь зөв ч зохицуулалт нь өрөөсгөл аж. Ядаж энэ мөнгөний 70 хувийг нийслэлд үлдсэнийг нь суманд зарцуулах хөшүүрэг байх ёстой талаар тэд хэлж байсан.

Тансаг хэрэглээтэй сумын даржин төрх

Цогтцэций гурван жилийн өмнөхөөс тэс өөр болсон тухай нутгийн иргэд хэлж байна. Ямар ч бизнес эрхэлсэн худалдан авах чадваргүй болсон гэнэ. Энэ талаар баар, ресторан, дэлгүүр ажиллуулж үзсэн гэх худалдаа эрхлэгч Д.Туул “Уурхайгаас хамааралтай ▶

“

“Цэвэр агаар” сангийн дансанд ордог гэнэ. Энэ мөнгөөр нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахаар Засгийн газраас утаагүй зуух, шахмал түлш гэх мэтийн аар саархан ажил хийдэг. Гэтэл агаар бохирдож буй газар нь Цогтцэций.

”



Сум дундын эмнэлэг



“Цэций” хороолол

▸ байна гэдэг маш хэцүү. Сая хэдэн сар зогсоход дэлгүүр худалдан авагчгүй болсон. Тэгэхэд “Банкны өрөө яаж төлөх вэ” гэсэн хүмүүс олон байсан” гэв. Тэрбээр энд ахуй амьдралаа сайжруулах зорилгоор гурван жилийн өмнө нийслэлээс шилжин иржээ. БНСУ-д 10 жил ажиллаад Монголд ирэхэд Цогтцэцийд л амьдрал байна хэмээн хамаатан садан нь хэлж, бөөнөөрөө ирсэн юмсанж. Борви бохисхийлгүй ажиллаж бизнес нь овоо урагшилж байтал уул уурхай түр хугацаагаар зогссон нь хүнд цохилтод оруулжээ. Учир нь, энд нийтийн болон худалдаа үйлчилгээний чиглэлээр түрээслэх байр нийслэлийн зарим газраас ч өндөр үнэтэй. Зөөврийн устай 5*6 харьцаатай жижиг цайны газрын сарын түрээс хамгийн багадаа 1.5 сая төгрөг аж. Төвийн халаалттай устай газрууд 3-5 сая төгрөгийн хооронд хэлбэлздэг. Д.Туул гурван жил байр түрээслэн амьдарчээ. Энэ хугацаанд зөвхөн түрээст 10 сая төгрөг зарцуулж. Зөөврийн устай нийтийн нэг өрөө сарын 200-250 мянган төгрөг. Хэрэв хажуу өрөө түрээслэе гэвэл 300-350 мянгаас буудаггүй гэнэ. Тэрбээр “Цайны газар жил гаруйн хугацаанд түрээслээд түрээслэгчдээ 18 сая төгрөг өгч байлаа. Өөрөө ашиггүй ажилласан. Уул уурхайгаас хараат учраас орлого харилцан адилгүй байдаг юм. Орлогогүй ч түрээсээ өгч л таарна” хэмээв.

Караоке түрээсэлдэг гэх Р.Болд нийслэлээс нэлээд хэдэн сая төгрөгтэй иржээ. Гурван жилийн дотор мөнгөө арвижуулах гэсэн биш харин ч эсрэгээрээ дансаа улайлгачихаад байгаа гэсэн. Д.Туул одоо хот руу буцаж, хөөцөлдөж байгаад БНСУ руу гарах зорилготой болжээ. Түүнтэй адил хаалгаа барьсан түрээслэгч нар олон бий аж. Тус суманд “Номадс”, “Броадвэй” сүлжээ рестораны салбар үүдээ нээгээд 2-3 жил болжээ. Орлого нь уул уурхайн зогсонги байдлаас болж хумигдсан байна. Энд дундаж тохижилттой зочид буудал хоногийн 70-80 мянган төгрөгийн үнэтэй. Захын цайны газрын хоол хамгийн багадаа 6000 төгрөг.

Сумын төвийн дэлгүүрүүд нэг үе хөл гишгэх зайгүй шахам үйлчлүүлэгчтэй байжээ. Одоо байдал эсрэгээрээ болж. Банкны өрнөөс болж амиа хорлосон тохиолдол ч гарч. Уул уурхай зогсоод тал цалинг нь хэсэг байж байгаад өгнө гэх хооронд банкны зээл нь

нэхэгдсэн аж. 20-30 сая төгрөгийн өртэй хүн сэтгэлзүйн хүнд цохилтод орж, амиа хорлосон тухай нутгийн иргэд хэлж байна.

Он гарсаар цэцийд шинээр байшин барилга баригдаагүй гэнэ. Бэлэн мөнгөний хомсдолд орсон учир амьдрал хүнд болоод буй тухай учирлах. Уул уурхайг дагаад худалдан авах чадвар сайн байсан учир бараа бүтээгдэхүүний үнэ нэлээд өндөр юм. Үүнд нь ажилгүй орлогогүй эсвэл төрийн албан хаагчид өртчих гээд байдаг талтай аж.

Сургуулийн хүрэлцээ ч муу. Уул уурхай хөгжөөд 50 жил болж буй газар энэ мэтийн бүхий л асуудлаа шийдсэн баймаар. Сумын ЗДТГ-ын урд талд байрлах 440 хүүхдийн суудалтай сургуульд 800 гаруй сурагч суралцаж буй аж. Зарим анги гурван ээлжээр хичээллэдэг байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас уг сургуулийг ашиглаж болохгүй гэсэн дүгнэлт гаргасан ч ашигласаар буй аж. Харин “Энержи ресурс” компани Өмнөговь аймагтаа хамтран хөрөнгө оруулалт хийж, тус суманд “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулжээ. Өдгөө тус сургуульд 600 гаруй хүүхэд суралцаж байна. Сургууль сумын төвөөс 5-6 орчим км-ын зайтай юм. Тэнд “Энержи ресурс”-ын ажилтнуудын хүүхдүүд ч мөн суралцдаг байна. Түүнчлэн тус компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Цогтцэцийд хийсэн бүтээн байгуулалтын ажлыг энд дурдалгүй өнгөрч болохгүй. Үүний дотор сумын хөгжил цэцэглэлтэд өнгө нэмсэн нь Цэций орон сууцны хороолол, “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэг байсан юм.

Бодлогоор хүн амын төвлөрлийг бий болгосон учраас УИХ цэцийгийн тоосжилт, агаарын бохирдол зэрэгт анхаарал хандуулах ёстой. Учир нь, хүний эрүүл мэнд чухал. Манай сумыг уул уурхайн чиглэлээр ашиглая гэвэл нийгмийн асуудалд нь төр анхаарах ёстой гэдгийг Цогтцэций сумын Засаг дарга Н.Амгалан хэлсэн.

Нэгэнт хүн ам төвлөрсөн газар уул уурхайн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг төр өгсөн учир Цогтцэцийчүүдийг одоо яах вэ. Энэ хэвээр удаан амьдарвал тэдний эрүүл аюулгүй орчинд аж төрөх эрх алдагдах нь. Цаашдын ирээдүй нь ч бүрхэг байна. ■



“Номадс” рестораны салбар



“Цэций” их дэлгүүр

ТОМИЛОЛТ

ЦОГТЦЭЦИЙГЭЭС ГАШУУНСУХАЙТ



Фотог Зохиогч

Тавантолгой уурхайн олборлолтын хэсэг

НҮҮРС ҮНЭГҮЙДЭХИЙН УЧИР

С.ЗАЯА

Сул шороо гутлын уланд наалдаж, цааш алхах бүрт улам лавширч хөлийн шагайгаар татсан учраас туучихаас өөр аргагүй болов. Харуй бүрий болсон хойно очсон надад говийн хөрс зөөлөн учраас ийм

байдаг байх нь гэсэн бодол төрөв. Үүрийн гэгээ орохтой зэрэгцэн босч ойр орчмоо ажвал шороо бус нүүрсэн дундуур явсан юмсанж. Энэ газар бол “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Цагаан хадан дахь Гаалийн хяналтын бүс юм. Энд уурхайгаас ирсэн нүүрсийг

агуулахад буулган, шилжүүлэн ачиж экспортолдог юм байна. Ингэхдээ агуулах болон ойр орчмынх нь талбайг бэлтгэхийн тулд өнгөн хөрсөн дээр исэлдсэн нүүрс дэвсэж өгдөг аж. Энэ хэсэгт нүүрс ачсан машинууд хэдэн зуугаараа явах учир хөө тортог, тоос шороо манантана. ▶

ХҮРТЭЛХ СААРАЛ АМЬДРАЛ-2

► Уртаас урт шороон зам бий болж, олон машин явсан үед нэгнийгээ харахгүй мөргөлдөж, осол гарах нь энүүхэнд. Цагаан хадан дахь аж амьдралыг дараагийн сурвалжлагадаа өгүүлэх учир түр азная. Үүнийг дурдсаны шалтгаан нь “Эрдэнэс Тавантолгой” компанийн Баруун, Зүүн цанхийн уурхайн нүүрс олборлолт ч ийм дүр зурагтай байсан учраас тэр. Уурхайн гүнд 60-240 тоннын даацтай машинууд олборлосон нүүрсийг ачиж, агуулахад буулгаж байв. Хамгийн гүн хэсэгтээ уурхай газрын төвшнөөс 80 метрийн доор байрладаг аж. Олборлолтоо 50 орчим метрийн гүнээс явуулж буй гэсэн. Нүүрс олборлож буй хэсэг хориотой бүс учир тээвэрлэлт хийх тээврийн хэрэгсэл л явж харагдана. Уурхайг тойроод нүүрсний овоолго дүүрчээ. Хаашаа л харан коксжсон нунтаг нүүрс байх. Зарим газар хашлага үүсгэчихэж. Дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ унасан учраас экспорт төдийлэн хийгдэхгүй буй аж. Манайхан Хятадын “Чалко” компанид өрөндөө нүүрс нийлүүлж байгаад өнгөрсөн сарын 10-наас хойш түр зогсоод байна. Үүнээс үүдэж баруун, зүүн цанхийн агуулах нүүрсээр дүүрчээ. “Чалко” авах нүүрснийхээ дэгдэмхий чанарыг 28-аас ихгүй байлга гэсэн учраас зарим нүүрсийг ангилан хураасан байх. Олборлосон нүүрсээ экспортлохгүй бол хураах зайгүй болсон тухай эндхийн ажилтнууд ярьж байна. Уурхайнхаа агуулахыг суллах үүднээс Цагаан хадан дахь Гаалийн хяналтын бүсийн агуулах руу 400 гаруй мянган тонн нүүрс зөөжээ.

“Эрдэнэс Тавантолгой” өмнийн бүсийн цахилгаан түгээх сүлжээнээс эрчим хүч авч байна. Уурхайн үйл ажиллагааг явуулахын тулд дизель генератор ажиллуулдаг. Энэ жил цахилгаан дамжуулах шугам татах төлөвлөгөөтэй байгаа аж. Зүүн цанхи Австралийн “Макмахан” компанитай олон улсын гэрээгээр хамтран ажилладаг. Тэнд байгаа тоног төхөөрөмжүүд тус компанийн

өмч. Таван жилийн хугацаанд олборлолт хийж тоног төхөөрөмж, боловсон хүчнээ бэлтгэж өгөөд явах үүрэг гэрээгээр хүлээжээ. Учир нь, “Эрдэнэс Тавантолгой” 2011 онд дэлхийн зах зээл дээр IPO гаргана гэж яригдаж байхад гэрээний заалтад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн менежмент нэвтэрсэн байх ёстой гэж заасан байжээ. Энэ хүрээнд тус компанийг сонгон

“Манай улс “Чалко”-д өгөх 350 сая ам.доллараас одоо 130 сая нь үлджээ. Үүнийг нүүрсэнд шилжүүлбэл 2.3 сая тонныг өгөх тооцоо бий аж. Ийм хэмжээний нүүрсийг ч олборлоод агуулахдаа хадгалсан байна. Гэвч Хятадын тал өр дуусах дөхөнгүүт янз бүрийн шалтаг тоочиж, өөнтөглөх нь их болж. Ингэж хугацаа алдаж байтал нүүрсний үнэ улам унах төлөвтэй болсон гэнэ. Тэгэхээр өрөндөө багаар бодоход 2.5 сая тонн нүүрс өгөх шаардлага гарсан гэх”

хамтарч ажиллаж буй аж. Гэсэн ч эвдэрсэн тоног төхөөрөмжийг засах сэлбэгийн төв байдаггүй нь зарим тохиолдолд ажил саатахад хүргэдэг гэнэ. Ажилтнууд нь тийм ч сайн ур чадвартай биш гэдгийг уурхайн ажилтнууд хэлж байсан. Харин Баруун цанхийн хувьд дотоодын олборлогч компанитай гэрээтэй. Нэг шоо метр хөрсийг төдөн төгрөгөөр хийнэ гээд тухайн компани хүн хүч, техник тоног төхөөрөмжөө гарган ажлыг нь хийж өгдөг бөгөөд гүйцэтгэл нь ч маш сайн байдаг гэсэн.

“Чалко”-д 413 мянган тонн нүүрс өгчээ

Уурхайн олборлолтыг дагаад агаарт дэгдэх тоос шороог төсөөлж хэлэхэд бэрх. Газрын гүний усаар хиймэл нуур үүсгэн, зам талбай, ойр орчмоо усжуулж тоосжилтыг бага ч атугай

дардаг байна. Агуулахад хураасан нүүрс найман метрээс дээш өндөр байх ёсгүй учраас энд тэндгүй нүүрс “хөглөрөх”. “Эрдэнэс Тавантолгой”-н Зүүн цанхиас дөрөвдүгээр сарын эхний хагас хүртэл 360 орчим мянга, он гарсаар 457.5 мянган тонн нүүрс олборложээ. Өмнөх үлдэгдэлтэйгээ нийлээд одоогоор 1.5 сая орчим тонн нүүрс Зүүн цанхийн агуулахад хураалттай байна. Харин цанхийн баруун уурхайгаас он гарсаар 40 мянган тонн л нүүрс олборлосон гэнэ. Агуулахад нь өмнөх үлдэгдэл болох 1.2 сая тонн нүүрс буй. 2014 он гарсаар нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр унаснаас борлуулалт эрс багассаныг тус компанийн ажилтнууд хэлж байна.

Баруун цанхиас 242 мянган тонн нүүрс худалдаад буй аж. Тонн нүүрсийг өнгөрсөн онд 40 ам.доллараар худалдаж. Үнэ унасан энэ үед одоо чухам хэд болох нь тодорхойгүй байгаа аж. Энэ нь “Чалко”-гийн өр бус уурхайн аман дээрээс компаниудад зарсан нүүрс. Баруун, Зүүн цанхийн агуулахад нүүрс хангалттай бий учир одоогоор барууны олборлолтыг түр зогсоожээ. Мөн эдийн засгийн байдлаас шалтгаалан гэрээт олборлогч компаниудын үйл ажиллагаа түр хугацаагаар саатсан аж.

“Чалко” компанид он гарсаар 413 мянган тонн нүүрс өгчээ. Өнгөрсөн сард өрдөө 35 мянган тонныг л экспортлосон аж. Уг нь ирэх зургадугаар сард өрөө төлж дуусах байсан ч худалдан авагч талаас шалтгаалан зарим нэг саад тотгор үүсчээ. Өрөө дарах зорилгоор уурхайн ажилтнууд бүхий л хүчин чадлаа дайчилж ажилласан аж. Гэтэл худалдан авагч талтай үл ойлголцол үүссэнээс тээвэрлэлэлт тодорхойгүй хугацаагаар зогссон учир бүх агуулахууд нь дүүрчээ. Манай улс “Чалко”-д өгөх 350 сая ам.доллараас одоо 130 сая нь үлджээ. Үүнийг нүүрсэнд шилжүүлбэл 2.3 сая тонныг ►

▸ өгөх тооцоо бий аж. Ийм хэмжээний нүүрсийг ч олборлоод агуулахдаа хадгалсан байна. Гэвч Хятадын тал өр дуусах дөхөнгүүт янз бүрийн шалтаг тоочиж, өөнтөлгөх нь их болж. Ингэж хугацаа алдаж байтал нүүрсний үнэ улам унах төлөвтэй болсон гэнэ. Тэгэхээр өрөндөө багаар бодоход 2.5 сая тонн нүүрс өгөх шаардлага гарсан гэх.

Шороон замаар тээвэрлэх эрсдэлтэй ч...

Тээврийн компаниуд мөнгөө бодон ихэнх нь шороон замаар нүүрс тээвэрлэдэг байна. Учир нь, засмал замаар явахад 70 тонноос илүү нүүрс тээвэрлэх ёсгүйн дээр Тавантолгойн уурхайгаас Ганцмодны боомт хүртэл явахад нэг машин 300 гаруй мянган төгрөгийг зам ашигласны төлбөрт төлдөг. Мэдээж энэ мөнгө нүүрс тээврийн компаниудын хэтэвчнээс гарах учраас жолооч нараа шороон замаар явуулах нь түгээмэл аж. “Эрдэнэс Тавантолгой”-н уурхай ид ачаалалтай үедээ өдөрт 220-250 орчим машинд нүүрс ачдаг. Баруун цанхиас хоногт 300 машин нүүрс ачиж байсан тохиолдол ч бий гэсэн.

Зүүн цанхиас нүүрс тээвэрлэж буй дотоодын 12 компани засмал замаар явж байгаа аж. Зарим компани даац хэтрүүлэн 100-гаас дээш тонн нүүрс ачдаг учраас шороон замаар явдаг байна. Энэ талаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ний уурхайн менежер Р.Нацагдаш “Манайх шороон замаар явуулахгүй гэсэн бодлого барьж байна. Бүх компаниуд өмнө нь шороон замаар явж байв. Тус зам “Энержи ресурс”-ийн мэдэлд байхад замын төлбөр өндөр байсан. Одоо төр үнийг нь хямдруулаад бүх машиныг засмал замаар явуулах бодлого барьж байгаа. “Чалко”-д өгөх нүүрсийг тээвэрлэх зорилгоор манайх дотоодын 12 компанитай гэрээ хийсэн. Тэд уртын тээвэр буюу уурхайн амнаас ачсан нүүрсээ БНХАУ-ын Ганцмодны боомт руу шууд гаргадаг” гэв.

Харин Баруун цанхийн хувьд аман дээрээс шууд зардаг учир тухайн компани тээвэрлэлтээ өөрсдөө хариуцдаг. “Эрдэнэс Тавантолгой”-н уурхайн олборлолтын хэсэг 340 гаруй ажилтантай. Ажилтнуудын 12 нь австрали бусад нь монгол.

Тус уурхай 2011 онд жилд нэг сая тонн нүүрс олборлосон бол 2012 онд гурван сая тонныг гаргахаас 2.5 сая, өнгөрсөн жил зургаан сая тонн нүүрс олборлохоос 2.5 сая тонныг л хөрсөн дээр гаргасан байна. Үүнд зах зээлийн нөхцөл байдал нөлөөлжээ. Энэ жил мөн зургаан сая тонныг олборлохоор зорьсон ч одоогоор 457 мянган тонныг л олборлоод байгаа юм. Цанхийн баруун уурхай өнгөрсөн жил анх олборлолт явуулахдаа нэг сая тонныг гаргаж байсан ч 2.5 сая тонныг олборлож төлөвлөгөө давуулан биелүүлжээ. Энэ жил таван сая тонныг олборлох төлөвлөгөөтэй ч он гарсаар 40-хөн мянган тонн нүүрс гаргасан байна.

Нүүрс баяжуулахаар төлөвлөсөн ч ашиглах ус байхгүй

Зүүн цанхийн уурхай 2010 оны наймдугаар сарын 27-ноос хөрс хуулалтын ажил эхэлжээ. ТЭЗҮ-д



Тавантолгой уурхайн бүс

нөхөн сэргээлтийг тодорхой хугацааны дараа хийхээр тусгасан байна. Энэ хүрээнд Зүүн цанхид нөхөн сэргээх хэмжээний овоолго энэ жил дүүрэх аж. Уг нь өнгөрсөн онд дүүрэх байсан ч нүүрс олборлох ажил түр хугацаагаар зогссонтой холбоотойгоор ийн хойшилжээ. Ирэх оноос эхний техникийн нөхөн сэргээлтийг эхлүүлэхээр төлөвлөжээ.

Уурхайн олборлолтын улмаас байгаль орчинд үүссэн тоос шороог дарахын тулд гүний шүүрүүлсэн ус ашиглаж байгаа аж. Энэ ус уурхайн гүнд байгаа учир насосоор татан усалгаа хийж, байгальд нь буцаагаад ашигладаг байна. Уг нь Балгасын улаан нуурыг түшиглэн уурхайг байгуулжээ. Гэтэл тус уснаас орон нутаг ашиглуулахгүй байгаа учир нүүрсээ баяжуулж чадахгүй байгаа аж. Их хэмжээний нүүрс угаах Хятадын зах зээлд нийлүүлэх төлөвлөгөө бий ч дээрх шалтгааны улмаас зогсонги байдалд оржээ. Гэхдээ усгүй гээд гараа хумхин суулгүй “Энержи ресурс”-ийн үйлдвэрт 4-5 сая тонн нүүрс угаалгаж урд хөршийн зах зээлд нийлүүлэхээр болжээ.

“Чалко” нүүрс авахгүй бол агуулахад хураалттай байгаа нүүрсээ баяжуулах гэнэ. Баяжуулсан нүүрс түүхийгээсээ харьцангуй өндөр үнэтэй. Тухайлбал, нэг тонн түүхий нүүрс 30 ам.доллар байхад баяжуулбал үнэ нь хоёр дахин өсөх аж. Үүнээс баяжуулсныхаа зардалд 10-15 ам.доллар шингээвэл цаана нь мөн хэмжээний ашиг гарна. Тэгэхээр тус компани өөрсдийн баяжуулах үйлдвэртэй болох шаардлага бий. Гэхдээ хөрөнгө мөнгөний бэрхшээл байгаагаас ТЭЗҮ-ийн дагуу явж чадаагүй гэнэ. Төлөвлөгөөний дагуу явсан бол таван сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн эхний хэсэг өнгөрсөн жил ашиглалтад орох байжээ.

“Эрдэнэс Тавантолгой”-д байдал ийм байна. Биднийг томиллолтоор ажиллаад ирэх үеэр тус компанийн дансанд 17 сая ам.доллар орж ирсэн нь зогсонги байдалд орсон ажлыг хөдөлгөх хүч болоо биз ээ. Гэхдээ л энэ нь дотоодод хуримтлагдсан өр ширний асуудлыг гал унтраах төдийд шийдэхээс бус экспорт болоод үнэд дорвитой өөрчлөлтийг авчрахгүй юм. ■

Үргэлжлэл бий.

ГААЛЬ

Б.БАТГЭРЭЛ: ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙГ ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛСЭН

С.АЗ

Гаалийн байгууллага байцаагчдынхаа сэтгэхүй, боловсролд ихээхэн анхаарч, хийж буй ажлаараа үлгэрлэн тэднийг олон жил дагасан муу нэрээ цэвэрлэхээр зориг шулуудсан аж. Энэ шинэчлэлийн хүрээнд гаалийн байгууллагад олон ажил хийж эхэлжээ. Ар гэр, хувийн амьдрал, эрүүл мэндээ үл ажран Монгол Улсын өмнө өргөсөн тангаргаа биелүүлэхийн төлөө ажиллаж буй тэднийг нэг талаараа буруутгаж



боломгүй. Гаальчин хүний ажил, амьдралыг нүдээр үзэн, бодит байдлыг харвал тэд ч бас бидэнтэй адил хүн шүү дээ гэх бодол төрөх. Энэ талаар дараагийн сурвалжлагадаа өгүүлэе.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлтээрээ гаалийн байгууллага дотроо гуравдугаарт бичигддэг Гашуунсухайт гаалийн газрын дарга Б.Батгэрэлтэй ярилцлаа. Тус боомт нийслэлээс 780 км-ын зайд оршдог юм.

-Уул уурхайн бүтээгдэхүүн голлон гардаг Гашуунсухайт гаалийн газрын бусдаас ялгарах онцлог юу вэ?

-Монгол Хятад хоёр улсын Засгийн газрын хэлэлцээрийн дагуу 1992 оны зургадугаар сараас Гашуунсухайт боомт түр ажиллагаатай байхаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Энэ хүрээнд улиралд нэг, жилд дөрвөн удаа тус бүр 20 хоног хилээ нээж байсан юм. Улмаар 2000 оноос Өмнөговь аймаг дахь Гаалийн газар болж өргөжиж, энэ үедээ Гашуунсухайт-Шивээхүрэн дэх боомтыг давхар хариуцан, Даланзадгадад үйл ажиллагаа явуулж байв. Харин 2007 оноос Гашуунсухайт, Шивээхүрэн бие даасан хороо болон өргөжиж, Өмнөговийн Гаалийн газар татан буугдсан. Гаалийн ерөнхий газрын даргын 2010 оны хоёрдугаар сарын 5-ны тушаалаар манай боомт байнгын ажиллагаатай болж, Гашуунсухайт гаалийн газар болон өргөжсөн. Оюутолгой, Тавантолгойн үйл ажиллагаатай холбоотойгоор уул уурхайн бүтээгдэхүүнийг Гашуунсухайт боомтоор цаг алдалгүй нэвтрүүлэхийн тулд чиг үүрэг нь ийн өөрчлөгдсөн. Ашигт малтмал эрдэс баялгийг өдрийн

08.00-20.00, зорчигчдыг 08.00-17.00 цаг хүртэл хоёр улсын хилээр нэвтрүүлдэг. Манай газрын салбар Оюутолгой, Ухаахудагт бий. Гашуунсухайтаас Оюутолгой дахь гаалийн салбар 100 км зайтай, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг. Харин Ухаахудаг 260 км-ийн зайтай. Манай газарт төрийн тусгай албан хаагч 62, төрийн үйлчилгээний албан хаагч 10 ажиллаж байна. Хилийн боомтын тухай хууль дөрөвдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Энэ хүрээнд боомтын захиргаатай болно. Тэгэхээр бид аж ахуйн хэсгээ тийш шилжүүлж, үндсэн чиг үүргийнхээ ажлыг хэрэгжүүлээд явах боломж бүрдэх юм.

-Эрдэс баялаг экспортлоход гаалийнхан хүнд суртал гаргаж буйгаас ажил хийхэд хүндрэлтэй байгаа зарим компанийн удирдлага хэлж байсан. Танай газарт хүнд суртал хэр байгаа бол?

-Эрдэс баялгийн экспортыг дэмжин цаг хугацаа хэмнэж, хурдан хугацаанд хилээр нэвтрүүлэх нь бидний зорилго. Ингэхийн тулд 12 зам ашиглан уул уурхайн бүтээгдэхүүний экспорт

явуулж байна. Зөвхөн Эрдэнэс Тавантолгойн нүүрсний экспортыг дэмжихийн тулд тусгайлан хоёр зам гаргаж өгсөн. Оюутолгойн зэсийн баяжмалыг тээвэрлэх мөн хоёр зам бий. Бусад найман зам нь гадаад худалдаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагууд бүтээгдэхүүнээ экспортлоход зориулсан юм. Өдөрт давхардсан тоогоор 2000 гаруй том оврын машин хилээр нэвтэрдэг. Ямар их ачаалалтай байдгийг эндээс харж болно. Өглөөнөөс үдшийн бүрий болтол манай байцаагчид 12 цаг цайны цаггүй тасралтгүй ажиллаж албан үүргээ гүйцэтгэж байна. Гашуунсухайтын гаалийн газар үйл ажиллагааны хувьд нэлээд эрсдэлтэй.

-Яагаад?

-Гаалийн байгууллага Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, улсын төсвийн орлогын тодорхой хувийг бүрдүүлэх, гадаад худалдааг хөнгөвчлөх үүрэг хүлээн ажилладаг. Ингэхдээ Дэлхийн гаалийн болон худалдааны байгууллагаас тавьж буй шаардлагыг хүлээж ажиллах ёстой байдаг. Тэгэхээр аль болох түргэн ➤

► шуурхай, цаг хугацаа хэмнэсэн гаалийн хяналт шалгалтыг хийхийн тулд биет үзлэгийн хувийг багасгаж, эрсдэлийн менежмент, мэдээлэл солилцоо зэрэгт үндэслэх үүрэг хүлээдэг. Гэтэл УАБ-ыг хамгаалах үүднээс хяналт шалгалтыг хийхээс өөр аргагүй болдог. Монгол Улсын үнэт өв соёл хилээр гарчих вий гэдгийг зайлшгүй шалгах шаардлага гарна. Хориглосон хязгаарласан бараа хилээр нэвтрүүлэхгүйн тулд бүгдийг нь үзэхээс өөр аргагүйд хүрдэг. Тэгэхээр энэ хоёрыг тэнцвэржүүлж ажиллах хэрэгтэй болно. Энэ асуудалд гаалийн байгууллагын томоохон бодлогууд үе шаттайгаар хэрэгжиж байна. Эрсдэлийн менежментийг нэвтрүүлэх, бичиг цаасыг багасгах, мэдээлэл технологи болон рентген аппаратаа сайжруулах шаардлага бий. Одоохондоо рентген аппарат бидэнд байхгүй. Байцаагчид маань гараараа л шалгаж байна.

-Танай газар гаалийн бүрдүүлэлтийн цаасыг багасгасан гэсэн. Энэ тухайд?

-Засгийн газраас төрийн байгууллагуудыг нэг цонхны үйлчилгээнд оруулахаар бэлтгэл ажил хийж байгаа. Энд гаалийн байгууллага тэргүүн эгнээнд нь яваа. Учир нь, мэдээлэл технологи нь дэлхийн стандартад дөхөж очсон. Өмнө нь гаалийн бүрдүүлэлтэд 10 бичиг баримт шаарддаг байсан бол одоо дөрөв болсон. Гашуунсухайтын гаалийн газар улсын хэмжээнд анх удаа гаалийн мэдүүлэг хэвлэхгүй байна. Бүгдийг цахим хэлбэрт шилжүүллээ. Эрдэнэс Тавантолгойн нүүрсийг энэ зарчмаар хил нэвтрүүлж байна. Өөрөөр хэлбэл, 260 км-ийн цаана байрладаг Ухаахудагийн гаалийн салбараас ачигдсан нүүрсийг онлайн сүлжээгээр харан мэдээгээ татаж авч буй юм.

-Улсын төсөвт энэ жил хэчнэн тэрбум төгрөг төвлөрүүлэх вэ?

-Гашуунсухайтын боомтоор өдөрт дунджаар 80-100 орчим зорчигч тээврийн хэрэгсэл нэвтэрдэг. Ер нь, 150-180 тээврийн хэрэгсэл эргэлдэж байдаг. Импортоор барилгын материал, уул уурхайд хэрэглэгдэх химийн бодис, тоног төхөөрөмж гол төлөв орж ирнэ.

Манай газар улсын төсөвт төвлөрүүлдэг татварын орлогоороо гаалийн салбар дотроо гуравдугаарт ордог. Нэгд Улаанбаатар хотын, хоёрт

Замын-Үүд дэх гаалийн газар ордог юм. Энэ оны төсөвт бид 136.5 тэрбум төгрөг төвлөрүүлнэ. Өнөөдрийн байдлаар 16 орчим тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.

-Гааль шинэчлэгдэхийн тулд багагүй ажил хийж байна. Бодит байдал дээр та бүхэнд шинэчлэл мэдрэгдэж байна уу. Шинэчлэлийг ямар хэлбэрээр хийвэл зүгээр байна вэ?

-Гаалийн байгууллагад шинэчлэл хийгдэж байгаа. Дэлхийн гаалийн байгууллагаас тавьж буй шаардлага болон олон улсын стандартад нийцүүлэхээр ажиллаж байгаа. Гаалийн тухай хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулах гэж байна. Хууль эрхзүйн орчин нь дэлхийн жишигт нийцэж байна уу гэдгийг авч үзэх ёстой юм. Үүнтэй зэрэгцэн Дэлхийн худалдааны байгууллагад Монгол Улсын эзэлж буй байр урагшлах ёстой. Энэ бүгд уялдаатай хөгжинө. Гаалийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх таван асуудал байдаг. Хөрш зэргэлдээ орнуудтайгаа хамтарсан хяналт шалгалтын системд шилжих, харилцан зөвлөцөх зэрэг үүнд багтана. Тиймээс хүнд суртал, авлигаас ангид байх нь бидний нэн тэргүүний үүрэг юм.

-Танай газарт томоохон хэрэг зөрчил хэр гарч буйг сонирхмоор байна.

-Он гарсаар 59 зөрчил дутагдал бүртгэгдсэн. Үүнээс тав нь эрүүгийн үлдсэн нь захиргааны хариуцлага тооцох шинжтэй байна. Ихэнх нь хориглосон хязгаарласан бараа бүтээгдэхүүнийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан байдаг. Байцаагчид гадны нөлөөнд автаж, хэн нэгэнтэй үгсэн хуйвалдаж зөрчил дутагдал гаргасан үйлдэл одоогоор Цаашид ч ийм дутагдал гаргахгүй байхаар ажиллана. Гаальчдын дунд байдаг муу нэр өөрчлөгдсөн. Сэтгэхүй, боловсролын түвшин ч дээрдсэн. Шилжилтийн нийгмийн үеийн арга барил ч хоцрогдож, хууль эрхзүйн орчин маань ч хэд хэдэн удаа шинэчлэгдлээ. Энэ бүхэнд гаальчид хөл нийлүүлэн алхаж байна. Уулын мод урттай, богинотой учир алдаа дутагдал байгаа л байх. Тэр болгоныг цаг тухай бүрт нь засч залруулдаг. Үүнтэй зэрэгцэн хилээр нэвтэрч буй иргэн, аж ахуйн нэгж хуулийн мэдлэгээ сайжруулахад анхаармаар байна.

-Гаальчдыг сэлгэн ажиллуулах тал дээр та ямар бодолтой явдаг вэ?

-Бид төрийн тусгай албан хаагчид учраас Монгол Улсынхаа өнцөг булан бүрт очиж ажиллах тангараг өргөсөн. Нэг газар хоёр жилээс дээш ажилласан хүмүүсийг сэлгэн ажиллуулах шаардлагатай юм шиг санагддаг. Улсын хэмжээнд 1000 гаруй гаалийн байцаагч ажиллаж байна. Тэдний ар гэр, нийгмийн асуудлыг нь харгалзан үзээд хоёр жил болгоод сэлгэх эсэхэд Гаалийн ерөнхий газар хүний нөөцийнхөө бодлогоор зохицуулж шийддэг. Ер нь, тодорхой хугацааны дараа сэлгэн ажиллуулах нь зөв. Энэ онд хийсэн сэлгээгээр манай байцаагчдын 80 хувь нь солигдсон. Дархан, Орхон, Сэлэнгэ, Улаанбаатар, Буянт-Ухаа дахь гаалийн газраас хүмүүс ирсэн. Энэ олон газар бүгд өөрийн гэсэн онцлогтой. Манайх гэхэд хилийн байгууллага. Дархан, Орхонынхон гүний гааль. Тэнд ажиллаж байсан хүмүүс ажилдаа дасан зохицлоо тодорхой хугацаа зарцуулна. Гэхдээ бид дасан зохицоод ажиллахаас өөр аргагүй. Төрийн хууль хатуу, бид ч дагаж мөрдөх үүрэгтэй.


-Гаальчдын нийгмийн асуудлыг танай газар хэрхэн шийдвэрлэдэг вэ?

-Гашуунсухайтын гаалийн газрын байцаагчдын нийгмийн асуудал хүнд. Анх манай газар байгуулагдахад найман айлын жижиг байшин ашиглалтад оруулсан юм билээ. Тэр үед боомт түр ажиллагаатай байсан. Түүнээс хойш өргөжиж, гадаад худалдаа нэмэгдсэн. Одоогийн байдлаар бид сэндвичэн байшинд амьдарч байна. Өвөлд хүйтэн, зунд нь бүгчим учир тенг, агааржуулагч байнга ажиллуулдаг. Ингэхгүйгээр говийн халуунд амьдрахад маш хүнд. Энэ нь хүний эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлэх билээ. Гэр бүлээрээ амьдрах ямар ч боломжгүй. Тэр хэрээр гэр бүл салалт гаальчдын дунд бий. Тиймээс нийгмийн асуудлыг нь шийдэж өгөх нь болоод байна. Эмнэлэг, сургууль, цэцэрлэггүй. Манай газарт бага эмчийн орон тоо батлагдсан ч одоогоор эмчгүй. Хилийн боомтын тухай хууль хэрэгжиж эхэлсэн учраас цаашид сайжрах байх гэж бодож байна даа.

-Ярилцсанд баярлалаа. Таны ажилд амжилт хүсье. ■

ТООН МЭДЭЭ

Зээлийн ашиглалт (хугацаагаар)



Монгол Улсын Засгийн газар чөлөөтэй хөрвөх валютаар олон улсын банк, санхүүгийн байгууллага, түншлэгч улс орнуудаас 1990-2013 оны хооронд 2.8 тэрбум ам.долларын гадаад зээлийг авч ашигласан байна.

Эх сурвалж: Сангийн яам


Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2012	12/21/2013	Өөрчлөлт	
			Дүн	Дахин
Нийт гадаад өр	15,384.5	18,920.6	3,536.1	1.2
Засгийн газар	4,261.1	4,256.3	-7.8	1.0
Төвбанк	412.9	1,065.3	651.5	2.6
Банк	1,074.4	1,264.7	190.3	1.2
Богино хугацаат	58.2	118.0	59.8	2.0
Урт хугацаат	1,016.1	1,146.7	130.6	1.1
Бусад сектор	1,274.8	1,884.0	609.2	1.5
Богино хугацаат	508.2	451.3	-56.9	0.9
Урт хугацаат	766.6	1,432.7	666.1	1.9
Хөрөнгө оруулагчаас авсан зээл	8,357.4	10,450.3	2,092.9	1.3

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2013 оны IV улирлын байдлаар 18,9 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 3,5 тэрбум ам.доллаар буюу 1,2 дахин нэмэгдсэн байна.

Эх сурвалж: Монголбанк


Монгол Улсын гадаад өрийн тулгамдсан асуудал



Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн төсөлд улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийг 10.311.7 тэрбум төгрөг байхаар тооцсон нь ДНБ-ий 50.3 хувьтай тэнцэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д заасантухай шаардлагыг хангахгүй байна.

Эх сурвалж: Үндэсний аудитын газар

Өр ба ДНБ-ий харьцаа



Эх сурвалж: ЗЗБӨЧСТ

РЕДАКЦИЙН УУЛЗАЛТ

“ХЯМРАЛ ХУРЦДАХЫН ХЭРЭЭР ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨН ГААРЧ БАЙНА”

ТЭМДЭГЛЭСЭН Э.ЗОРИГТ, Б.БАЯРТОГТОХ

Нийгэм, эдийн засгийн байдал зүтгүү. Төр засгийн шийдвэр булингартай энэ цаг үед “Mongolian Economy” сэтгүүл болон “Economy” телевизийн студийн хамт олон “Бизнесийн амьдрал” буландаа бизнес

эрхлэгчдийн төлөөллийг урьсан юм. Энэ удаагийн хэлэлцүүлэгт “БСБ сервис” компанийн ерөнхий захирал Б.Жаргалсайхан, ноос ноолуурын “Хатан сүлжээ” компанийн захирал Б.Бадамханд, “Бридж” группын ТУЗ-

ийн дарга, МҮХАҮТ-ын тэргүүлэгч гишүүн Л.Даваажаргал нар оролцож эдийн засаг, бизнесийн өнөөгийн байдал болон гарц шийдлийн талаар ярилцлаа.



Б.ЖАРГАЛСАЙХАН
“БСБ сервис” компанийн
ерөнхий захирал



Б.БАДАМХАНД
“Хатан сүлжээ” компанийн ерөнхий захирал



Л.ДАВААЖАРГАЛ
“Бридж” группын ТУЗ-ийн дарга,
МҮХАҮТ-ын тэргүүлэгч гишүүн

“...Монголбанкнаас бидэнд өгсөн тайлбараар бол одоо л төгрөг ам.доллар хоёрын бодит ханш тогтлоо гэсэн. Өмнө нь ханш хиймэл байсан юм шиг байгаа юм...”

“...Татвар төлөгчдөөс болж төсөв тасраагүй. Татвараа төлдөг хэсэг нь төлсөөр л байсан. Харин төрийн буруу бодолгоос болж төсөв тасарсан...”

“...Унасан мориныхоо бөгс рүү нь биш, толгой руу нь ташуурдаад байгаа. Толгойг нь ташуураад байхаар морь хаашаа явахаа мэдэхгүй байна...”

▶ “Ард түмэн дан байтугай нөмрөх ч дээлгүй блочихоод байна”

-Манай сэтгүүлийн уламжлал болсон нэгэн асуултаар хэлэлцүүлгээ эхлүүлэе. Амьдрал ямар байна вэ?

Б.Ж: -“BSB сервис” компани цахилгаан бараа, компьютер, гэрийн болон албан байгууллагын тавилгын худалдаа эрхэлдэг. Өнөөдрийн байдлаар манай дөрвөн салбарын үйл ажиллагаа өөр өөр байна. Тухайлбал, компьютер болон албан тасалгааны тавилгын борлуулалт тааруу байхад цахилгаан бараа, гэрийн тавилгын харьцангуй сайн байгаа. Үүнийг Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа орон сууцны найман хувийн зээлтэй холбоотой гэж бодож байна.

Б.Б: -Монгол хүн “Амны билгээс ашдын бэлэг” гэдэг. Тэр утгаараа амьдрал сайн байна л гэж хэлэе. Би ноолуурын салбарт ажиллаад 33 жил, компани байгуулаад 22 жил болж байгаа. Энэ жилийнх шиг эдийн засгийн хямралыг мэдэрч байсан үе байхгүй. Эдийн засгийн хямрал бизнесийн амьдралд хүнд тусч байна. Одоогийн байдлаар дотооддоо үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэгчид болон импортлогчид нэлээд хүнд байдалд ороод байна. Экспортлогчдын хувьд байдал арай дээр байх шиг.

-Ноос, ноолуурын салбарын хувьд төрийн дэмжлэгийг багагүй хүртдэг. “Чингис” бондоос мөнгө өгсөн. Тэгээд яагаад хямралыг маш ихээр мэдрээд байна вэ?

-Манай салбарт “Чингис” бондын мөнгөнөөс санхүүжилт өгч байгаа. Ингэж дэмжиж байгаад нь бид баярладаг. Гэхдээ эдийн засгийн хямралын үед тухайн хөрөнгө оруулалт хөрсөндөө бууж, үр дүн үзүүлж байна уу гэвэл учир дутагдалтай. Өнөөдрийн байдлаар бондын мөнгөнөөс өгөх ёстой 94 тэрбум төгрөгийн дөнгөж 30 хувь нь л олгогдоод байна. Үлдсэн хөрөнгө оруулалт хийгдээгүй. Төрөөс өгсөн зээлээр тоног төхөөрөмжөө худалдаж аваад түүхий эд, ажлын байраа

бэлэн болгочихлоо. Гэтэл эцсийн бүтээгдэхүүний борлуулалт байхгүй болсон. Ажилчдаа цомхотгохгүй, цалин хөлсийг нь бууруулахгүй хүндрэлийг давчих санаатай хичээгээд байгаа боловч энэ нь давагдашгүй хүчин зүйл болоод байна. Тийм болохоор үүнийг төрийн бодлогын түвшинд авч үзэхгүй бол нөхцөл байдал улам л дордоно.

Л.Д: -“Бридж” группын хувьд гурван чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд барилга, жижиглэн худалдаа, гадаад худалдаа хамаарна. Манай үйл ажиллагаа явуулдаг салбар бүгдээрээ л хямралтай байна. Валютын чангаралтай холбоотой эдийн засгийн хямралыг бид богино хугацаанд даваад гарчих байх гэдэг итгэлтэй байсан. Гэтэл энэ итгэл найдвар бага багаар алдарч, хямрал 1-2 жил үргэлжлэх төлөвтэй байна. Байдал энэ хэвээр удаан үргэлжилбэл Монголын хувийн хэвшлээс хэд нь тэсч үлдэх бол гэсэн бодол дунд хөвж явна.

-Хямралын эсрэг ямар арга хэмжээ авч байна вэ?

-Магадгүй бүх зүйл сайхан байсан бол бид өөрсдийн алдаа дутагдлаа олж харахгүй, илүү зардлаа хасах, зарим шаардлагагүй салбараас гарах зэрэг бүтцийн өөрчлөлтийг хийхгүй байсан байх. Нөгөө талдаа хямрал болоогүй бол бид ажлын байраа танах арга хэмжээ авахгүй байлаа. Ер нь нөхцөл байдлыг ажиглаад байхад хувийн хэвшлийн ихэнх байгууллага ажлын байрны цомхотгол хийж байна.

-Дотоодын үйлдвэрлэгчид хямралыг давж гарахын тулд дор бүрнээ хичээж байна. Мөн төр засгаас юу хийж, ямар шийдвэр гаргах бол гэсэн хүлээлт өндөр байх шиг. Гэтэл хаврын чуулганаар “давхар дээл тайлах” асуудлыг ярьж цаг нөхцөөж байна. Уг нь эдийн засгийн байдалтай уялдуулаад төсвийн тодотгол, татварын шинэчлэл гэдэг ч юм уу арай өөр асуудлыг түрүүлж ярих хэрэгтэй байсан юм болов уу. Энэ тал дээр та бүхэн ямар бодолтой байна вэ?

Б.Ж: -Монголбанкнаас бидэнд өгсөн тайлбараар бол одоо л төгрөг ам.доллар хоёрын бодит ханш

тогтлоо гэсэн. Өмнө нь ханш хиймэл байсан юм шиг байгаа юм. Байдал энэ чигээрээ үргэлжлэх юм бол импортлогч компаниуд сөхөрнө. Сайн талыг нь харвал урт хугацаандаа экспортлогчдыг дэмжсэн бодлого болох байх. Өнөөгийн валютын болон төгрөгийн ханшийн нөхцөл байдал онолын дагуу бол зөв байх. Гэхдээ амьдралд буух үр дагавар нь тийм ч таатай биш.

Давхар дээлийг тайлах асуудал бол улс төрийн шоу юм болов уу. Сөрөг хүчин арай өөр асуудалд анхаарлаа хандуулах нь зөв байх. Эдийн засгийн нөхцөл байдал тааруу байхад Засгийн газар тодорхойгүй байдалд орчихвол байдал улам л дордоно. Улс төр, бизнес аль аль нь ялгаагүй тогтвортой байдлыг эрхэмлэдэг. Хэдийгээр өнөөдрийн сайд нар шаардлага хангахгүй байгаа ч гэсэн өөрчиллөө гээд мэдэгдэхүйц сайн үр дүн гарахгүй.

Б.Б: -Цаг үеэ олоогүй асуудал. Давхар дээлтэй байлаа гээд муудсан юм алга. Давхар дээлтэй олон жил явсан. Дан дээлтэй боллоо гээд нөхцөл байдал сайжирна гэвэл худлаа. Ер нь сүүлийн үеийн нөхцөл байдлыг харахад улс орны эрх ашгийг харсан биш, намууд нэг нэгнээсээ өшөө авах гэсэн үйл ажиллагаа явуулаад байх шиг. Бүх компани хямралд өртсөн. Ард түмэн дан байтугай нөмрөх ч дээлгүй болчихоод байна. Ийм үед Засгийн газар хийж байгаа ажлынхаа үр дүнгийн талаар ярих хэрэгтэй. Өнөөдөр бондын мөнгөнөөс үйлдвэрлэгчдийг дэмжсэн гээд байна. Гэтэл банкны өндөр босгыг давж чадаагүй олон компани бий.

“Засгийн газрын нэг үүрэг бол замыг гэрэлтүүлэх”

-Хаврын чуулганаас бизнес эрхлэгчид эдийн засаг, хувийн хэвшлийг дэмжсэн ямар хууль гараасай гэсэн хүлээлттэй байна вэ?

Л.Д: -Бизнесийн салбарынхан өнөөдөр төрөөс юу хүсч байна вэ гэхээр шударга өрсөлдөх боломжийг хангахыг хүсэж байна. Хямрал хурцдахын хэрээр шударга бус өрсөлдөөн гаарч байна. Монголын бизнесийн салбарт засч залруулахгүй бол болохгүй ▶

► бугшиж эдээ бээр болсон нэг асуудал байгаа нь албан бус бизнесийн үйл ажиллагаа. Өөрөөр хэлбэл, шударгаар татвараа төлөөд явдаг хэсэг нь хохирдог. Сүүдэрт үйл ажиллагаагаа явуулдаг, татвараас зайлсхийдэг хэсэг нь хождог буруу тогтолцоо бугшчихаад байна. Тиймээс хаврын чуулганаар сүүдрийн эдийн засгийг эрүүлжүүлж, шударга өрсөлдөөнийг дэмжих тал дээр ажиллаасай гэж хүсмээр байна. Мөн Засгийн газрын нэг үүрэг бол замыг гэрэлтүүлэх. Монгол Улс ирээдүйд юунд хүрэх юм бэ. Бид хаашаа явах юм бэ гэдгийг тодорхой болгох хэрэгтэй.

-Таны бодлоор шинэчлэлийн Засгийн газар замыг хэр гэрэлтүүлж байна вэ?

-Замыг гэрэлтүүлж чадахгүй байна. Цаасан дээр хөгжлийн үзэл баримтлал, намын мөрийн хөтөлбөр гээд олон зүйл байдаг. Гэтэл тэр цаасан дээрхийг хэрэгжүүлэх бодлого гэдэг зүйл чухал. Төр бизнесийг зөв тогтолцоогоор дэмжих хэрэгтэй.

Хэрвээ энэ замаар явбал та нарыг төр дэмжиж байгаа шүү, арай өөр замаар явбал дэмжихгүй шүү гэдгээ тодорхой болгоогүй. Магадгүй зарим талаар маш буруу бодлого явуулж байгаа гэж хэлмээр байна. Тухайлбал, манай улс эмзэг эдийн засагтай, жижиг орон. Гэтэл ийм эдийн засагт Америк, Японд үйлчилдэг зах зээлийн хууль үйлчилэхгүй. Манайхан монополийн эсрэг бодлого гэж ярьдаг. Магадгүй жижиг, дунд бизнес эрхлэгчдийг томууд нь шахаад байгаа бол ийм бодлого хэрэгтэй. Гэтэл өнөөдөр Монголд жижиг нь томыгоо идэж байна. Тэгш бус орчин үүссэн. Товчхондоо унасан мориныхоо бөгс рүү нь биш, толгой руу нь ташуурдаад байгаа. Толгойг нь ташуураад байхаар морь хаашаа явахаа мэдэхгүй байна. Ер нь манайд уруугаа харчихсан бодлого олон салбарт бий. Боловсролын салбарыг хар. Бүгдээрээ их дээд сургууль төгсөөд сэхээтэн болох юм гэнэ. Тэгээд хэн ажил хийх юм бэ. Энэ бол маш том гажуудал. Тиймээс ийм гажуудлыг төр засах хэрэгтэй. Мөн эдийн засаг хүнд байхад богино хугацаанд ямар арга хэмжээ авах вэ. Урт хугацаандаа эдийн засгаа хэрхэн төрөлжүүлэх вэ гэдэг асуудлыг ярих учиртай. Хэрвээ тэгэхгүй бол жижиг эдийн засагтай



2014.04.24

оронд ийм хямрал байнга л болно.

-Татварын II шатны шинэчлэлийг хийх гэж байна. Тухайлбал, НӨАТ-ын босгыг өндөрсгөх, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын 90 хувийн буцаан олголт гээд тодорхой хуулийн төслүүдийг УИХ-д өргөн барьсан. Бизнес эрхлэгчдийн хувьд татварын шинэчлэлийг хэрхэн харж байна вэ?

- МҮХАТ эдийн засаг таагүй байгаа энэ үед зарим асуудлыг илүү хурцаар хөндөн тавьж байгаа. Түүний нэг нь татварын асуудал. Танхимаас хийсэн судалгаанаас харахад татварыг дөрвөн 10-аас дөрвөн тавын бодлогод шилжүүлэх шаардлагатай гэдэг нь ажиглагдсан. НӨАТ-ын босгыг өндөрсгөх нь далд эдийн засгийг улам гааруулна. Харин дөрвөн тавын бодлого илүү үр дүнтэй. Мөн хямралын үед нийт бизнес эрхлэгчдийн нуруунаас бага ч гэсэн ачааллыг бууруулах юм.

Б.Ж: -НӨАТ өнөөдөр 10 хувь байгаа. Танхимаас таван хувь болгох асуудлыг ярьж байна. Энэ бол татварын хувь хэмжээ хоёр дахин бага болж байгаа хэрэг биш юм. Татвараас зайлсхийдэг олон хүн татвар төлдөг болох байх. 10 хэвээрээ байх юм бол үргэлжлүүлэн

нуун дарагдуулсаар байх болно. Нуун дарагдуулсаар байвал зах зээлд шударга өрсөлдөөн байхгүй. Татвар төлдөггүй хэсэг нь илүү хямдхан үнэтэй бараа бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлнэ. Энэ нь татвар төлдөг хэсгийн борлуулалтыг зогсоочихдог. Ингээд ирэхээр татвар төлдөг хэсэг нь ашиг байтугай борлуулалт ч үгүй болно. Даваажаралын жижиг нь томоо идэж байна гэдэг нь энэ санаа юм. Тэгэхээр 10 хувийг зайлшгүй багасгах хэрэгтэй.

Б.Б: -Төсөв, татвар бол нэг зоосны хоёр тал. Төсөв тасалдсаны улмаас татвар хураах замаар төсвийн алдагдлыг нөхөх гэж улайрдаг. Уг нь татвар төлөгчдөөс болж төсөв тасраагүй. Татвараа төлдөг хэсэг нь төлсөөр л байсан. Харин төрийн буруу бодолгоос болж төсөв тасарсан. Өнөөдөр нийт аж ахуйн нэгжийн бараг 40-50 хувь нь татвараас зайлсхийдэг. Иргэд ч гэсэн мөн ялгаагүй. Тиймээс миний хувьд татварын бодлогыг 10-5 болгох асуудал тийм хурдан шийдэгдчихгүй байх гэж харж байна. Харин тэрний оронд татварыг нийтийн тогтолцоонд шилжүүлэх олон ажлыг эхлүүлмээр байна. Жигд татвар төлөлтийг төрөөс дэмжих хэрэгтэй.

-Төсвийн алдагдалтай холбоотой ►►



Фотог Э.Зоригт

Бизнес эрхлэгчид татварын дөрвөн "5"-ын бодлогыг чухалчилж байна. Мөн тэд хямралтай үед эзэлийн асуудлаар төр банкуудтай хамтран ажиллах шаардлага үүссэн талаар ч ярилаа.

▶ **татвар төлөгчдийг дарамтлах нь гаарлаа гэх хэл үг огт тасрахгүй юм. Энэ үнэн үү. Ерөнхий сайд бизнес эрхлэгчидтэй хийсэн уулзалт дээрээ татвар, гаалийн дарга нараа өмнөө зогсоогоод ийм дарамт байгаа юм уу гээд асуухаар үгүй гэж хариулж байсан. Татвар төлөгчид ч гэсэн энэ үеэр юм хэлэхгүй дуугаа суусан. Тэгсэн хэрнээ ийм яриа байсаар л байх юм. Ямар учиртай юм бэ?**

Л.Д:-Дарамтлах асуудал улам нэмэгдэж байгаа. Гаалийн болон татварын байгууллагуудад дээрээс норм өгчихдөг юм болов уу гэж би боддог. Гэхдээ энэ дарамт бүгдэд тэгш байна уу гэвэл үгүй. "Номхон тэмээ ноолоход амар" гэдэг шиг нөгөө л шударгаар явдаг хэсгээ л дарамтлаад байдаг. Албан бус бизнес эрхлэгчдэд халдаж чаддаггүй.

-Яагаад тэр хэсэгт халдаж чаддаггүй юм бол. Та юу гэж боддог вэ?

-Нэг инээдтэй хариулт байдаг. Албан бус бизнес эрхлэгчдээс татвар бүрдүүлэхэд гарах зардал нэмэгддэг гэдэг. Энэ бол маш эмгэнэлтэй хэрэг. Татварын байгууллагын мэргэжилтнүүд хэвлэл мэдээллийн хэрэгслээр "100 төгрөгийн татварыг

бид ганцхан төгрөгийн зардлаар хураадаг" гэдэг юм билээ. Энэ чинь татварынхаа мөн чанарыг ойлгохгүй байгаа хэрэг. Уг нь бол бүх нийтийг л татварт хамруулах хэрэгтэй. Үүний тулд их бага нь хамаагүй зардал гаргах учиртай юм. Түүнээс биш, байнга ноолдог хэсгээ дарамталж татвар хураачихаад бид бага зардлаар их татвар хураадаг гээд онгилоод суух нь инээдтэй. Татварын бодлого нийгэмд гурван үүрэгтэй. Эхнийх нь улсын төсөв бүрдүүлэх. Дараагийнх нь нийгмийн баялгийг дахин хуваарилах. Сүүлийнх нь нийгмийн гажуудлыг засч залруулах байдаг. Гэтэл манай татварын бодлого улсын төсөв бүрдүүлэхэд голчлон анхаараад нөгөө хоёрыг нь орхигдуулаад байна.

"Мөнгө төсөвт биш, хувийн компанид үлдвэл илүү ашигтай"

Б.Ж: Манай ДНБ-ий 40-50 хувийг улсын төсөв бүрдүүлж буй. Төр төсвийг татвараас бүрдүүлдэг. Гэтэл олон улсын жишгээр бол энэ нь 20-25 орчим хувь л байдаг. Эндээс харахад манай улсын цуглуулсан татвар дэлхийн дунджаас хоёр дахин өндөр байна. Уг нь мөнгө төсөвт биш хувийн

компанид үлдвэл илүү ашигтай. Компанид үлдвэл адгийн наад зах нь ажлын байр бий болгодог. Гэтэл тэр мөнгийг төсөв бүрдүүлэх нэрээр татаад авчихдаг. Эндээс юу харагдаж байна гэхээр хамгийн үр ашигтай хэсгээс нь хамгийн үр ашиггүй хэсэгт мөнгө татан төвлөрүүлээд байгаа юм. Тиймээс улсын төсөв ДНБ-ий төдөн хувиас хэтрэх ёсгүй гэдэг хуультай болмоор байна. Татварын мөнгийг бизнес эрхлэгчид ажилчдаа урамшуулах, шагнах мөнгөө харамлан байж бий болгодог. Гэтэл тэр мөнгийг нь нэг нөхөр улс төрд орохын тулд зарцуулаад л. Тэгэхээр татварын мөнгө ихдээд байгаа юм биш үү.

Б.Б: -Би МҮХАТ-ын Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн үүрэгт ажлыг олон жил хийсэн. Хямарч ядахын хажуугаар татварын байцаагч нар аль болох торгох, илүү төлбөр авах зэрэгт их анхаарал хандуулдаг болчихсон гэдгийг бизнес эрхлэгчид хэлсээр байгаа. Энэ бол бодит үнэн.

-25 хувийн татварыг орлогоос нь зарлагыг нь хасаад гурван тэрбумыг давж байвал авах ёстой. Үүнийг манайхан нэлээд буруу ойлгодог юм шиг.

Б.Ж: -Манай татварын тогтолцоо ашиг их олоод байвал татвар өндөр авна шүү л гэсэн утгатай. Өнөөдөр хэн ч орлогоо гурван тэрбумаас дээш гэж мэдүүлэх сонирхолгүй. Их татвар төлөхгүйн тулд компани жижиглээд эхэлсэн. Журмаараа бол нэг л тайлантай байх ёстой компани маань гурван компани болчихоор гурван санхүүгийн болон татварын тайлан, гурван нягтлан, компани хоорондын гүйлгээ гээд зардал нэмэгдэнэ. Энэ бол ямар ч утгагүй зүйл. Ийм л нөхцөл байдлыг манай татварын хууль бий болгочихсон.

-Татварын системийг сүүлийн 20 жилд хамгийн их шинэчлэгдэн сайжирсан салбар гэж үздэг юм билээ. Нээрээ ч татварын байцаагчийг царайчилдаг байсан үеийг бодоход эрс шинэчлэгдсэн биш үү?

-Дэлхий даяаршиж байна. Өнгөрсөнтэйгээ харьцуулах биш, олон улс болоод урд, хойд хөрштэйгээ харьцуулж үзэх хэрэгтэй. Өнөөдөр манайд уул уурхайгаас бусад салбарт яагаад гаднын хөрөнгө оруулалт орж

► ирэхгүй байгаа юм бэ. Үүний цаад шалтгаан нь татварын тогтолцоо нь болохгүй байгаатай холбоотой. Тиймээс нэг шатлалтай татварын системийг бий болгох шаардлага тулгарч байна. Тэгэхгүй бол компаниуд томрохгүй. Одоо бол “та нар жижигхэн бай, нуун дарагдуул” гэсэн тогтолцоо үйлчилж байгаа. Тиймээс авах хэмжээнээсээ илүү үр дагаварыг нь бодох хэрэгтэй.

-Үнэ тогтворжуулах хөтөлбөр бизнесийн шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байна. Зогсоох ёстой гэсэн байр суурь гадуур нэлээд түгээмэл. Гэтэл нөгөө талд тус хөтөлбөрийг эдийн засагт үр дүнгээ өгч байна гэж үзэх хэсэг ч байна. Та бүхэн хөтөлбөрийг хэрхэн үзэж байна вэ?

Б.Ж: -Үнэ тогтворжуулах бодлого нь хямд үнийг барья гэсэн ажил болж хувираад байна. Үнэ хямд байх нь сул талтай. Эцсийн дүнд асар их мөнгө үрэн таран хийдэг. Ер нь юунаас айж үнэ тогтворжуулах гээд байгааг нь сайн ойлгохгүй байна. Хөтөлбөр зогсоход асуудал шийдэгдээгүй хэвээрээ л байна шүү дээ. Үр дагавараа эртнээс ойлгоод дараагийн зүйлээ бодох хэрэгтэй.

Б.Б: -Үнэ тогтворжуулах бодлогыг би хувьдаа дэмждэг. Гэхдээ Монголын эдийн засгийн хөгжлийг авч явж байгаа хувийн хэвшлийн салбарт нь тааруулсан бодлого байх ёстой. Мах,шатахуун гээд гол нэрийн бараа бүтээгдэхүүн дээр тогтворжуулалтын бодлогыг барихгүй бол болохгүй.

“Монголд өнөөдөр банкны засаглал тогтсон”

-Төр бизнесээс хол байх нь хувийн хэвшилд хэрэгтэй гэдэг. Тэгсэн хэрнээ төрийн дэмжлэг оролцоо хэрэгтэй байна гээд л ярих юм. Төр аль замаар нь явах ёстой юм бэ?

Л.Д: -Манайх шиг эмзэг эдийн засагтай орны хувьд тодорхой хэмжээнд төрийн оролцоо байх шаардлагатай. Гэхдээ төр оролцоо ёстой зүйлдээ оролцох нь оновчтой. Түүнээс шаардлагагүй тохиолдолд орж ирээд саад болж, бизнесийн үйл ажиллагаанд гажуудал үүсгэж болохгүй. Үнэ тогтворжуулах бодлогын хувьд төрийн оролцоо

зүйл нь мөн үү гэвэл нэг талаар мөн. Монголын эдийн засагт нэн чухал, ирээдүйд хэрэгтэй гэж үзсэн салбараа дэмжих замаар бодлогын хүрээнд хөнгөлөлттэй зээл олгох. Ингэснээр тухайн нялх салбарыг хөл дээрээ зогсол дэмжих гэсэн санааг уг бодлого тээж байгаа юм болов уу гэж хардаг. Харин хэрэгжилт тал дээр асуудал үүсч байна. Хоёрдугаарт, тогтворжуулах бодлогын хүрээнд өгч байгаа зээл үйлдвэрлэлийн салбарт тохиромжгүй богино хугацаатай. Ийм зээлээр урт хугацааны бодлого хэрэгжихгүй. Харин “Чингис” бонд нь арай илүү амьдралтай сонсогддог.

-Бизнесийн зээлийн хүтээмж чанар ямар байна вэ?

-Өнөөдөр бидэнд урт хугацааны, илүү хөнгөлөлттэй зээл хэрэгтэй. Тухайн зээлээ баялаг бүтээгчдэд төгрөгөөр өгөх ёстой. Валютаар орж ирсэн учраас валютаар зээл өгнө гэх нь эргээд хямралыг улам даамжруулах эрсдэлтэй. Монголд өнөөдөр банкны засаглал тогтсон гэж хэлж болно. Банкууд нь хуулиас гадуур явж болдог. Бизнесийн байгууллагууд валютаар үйлчилгээ хийхгүй, барьсан барилгаа валютаар худалдаж болохгүй. Тэгсэн мөртлөө банкууд нь валютаар зээл өгч болдог. Арилжааны банкууд бол “Хувийн хэвшилд төгрөгөөр зээл өгмөөргүй байна. Валютаар ав, авахгүй бол боль” гэх жишээтэй. Валютын зээлийг нь авахаас аргагүй. Нэг талаар банкууд өөрсдөө хямралыг өөгшүүлж байна. Энэ нь давхар хувийн хэвшлээ унагаж, шим шүүсийг нь сордог тогтолцоо болж хувирлаа. Үүн дээр төр анхаарах цаг болсон.

Б.Б: -Валютын ханшийн талаар бид Монголбанкны ерөнхийлөгчөөс тодруулахад ханшийн эрсдэлийг өөрсдөө хариуцах ёстой гэсэн. Ам.долларын зээл авсан бол тухайн эрсдэлийг тооцон байх хэрэгтэй гэж хэлсэн. Ийм хариу сонсоод сэтгэл үнэхээр гонсойсон. Уг нь 1384-1780 болтлоо савлаж байгаа ханшийг тогтворжуулах ажлыг төр л хийх ёстой баймаар. Энэ ажлыг хийх гэж төр байгаа. Төрд хандаж бас нэг зүйлийг онцлон хэлэхийг хүсэж байна. Өнөөдөр бизнес эрхлэгчид татвараа төлөхөөс гадна зээлийн дарамтад орчихоод байна. Бидэнд үйлдвэрлээд зах зээлд гаргачихсан бүтээгдэхүүн

олон. Гэтэл борлуулалт нь тэг дүнтэй. Тиймээс татвараас гадна зээлийн асуудлаар банкуудтай төр хамтран ажиллах шаардлага үүсчихсэн. Бараг бүх компани банкны зээлтэй байгаа. Хямралын үед үндсэн зээлийг нь түр зогсоох, эсвэл зөвхөн хүүгээ төлөх гэдэг ч юм уу. Ингэхгүй бол татвар төлдөг хэсэг зээлийн дарамтад ороод юун татвараа төлөх манатай сууна. Ер нь байдал энэ чигээрээ үргэлжлэх юм бол бизнес эрхлэгчид жагсаал хийх хүртэл арга хэмжээ авч магадгүй.

“Гадаадын хөрөнгө оруулалт хүнийг ажилд сургаж, дэлхийтэй ойртуулдаг хэрэгсэл”

-Сүүлийн үед гадаадын хөрөнгө оруулалтын тухай маш их ярьдаг болсон. Ам. доллар оруулж ирэхийг гадаадын хөрөнгө оруулалт гэж харахаас илүүтэй шилдэг менежмент, дэлхийн стандарт зэргийг онцлох нь зүйтэй байх. Энэ тал дээр манайхан хэр олз омогтой байгаа бол.

Б.Ж: -Дэлхий даяаршиж байгаа гэдгийг байнга санах ёстой. Манайхан асуудлыг сөргөлдүүлж үндэсний үзэл гэмээр зүйлээр босго тавьдаг. Сөргөлдөх биш гаднынхантай хамтарч ажиллах хэрэгтэй. Бид дэлхийн хөгжлөөс нэлээд хоцрогдсон нийгмээс гарч ирсэн. Ялангуяа англи хэл байхгүй. Ийм үед гадаадын хөрөнгө оруулалт, татварын тааламжтай орчин бүрдүүлж чадсан ч бид өөрсдөө бэлтгэлтгүй байна. Өнөөдөр гаднын компаниуд орж ирээд ажил хийе гэхээр боловсон хүчин алга. Англи хэлээр ярьдаг хүн бэлэн байна уу. Гадаадынхан орж ирлээ, бид тэдэнтэй хамтарлаа гээд Монголоо алдчихгүй. Харин зэрэгцэн амьдрах шинэ орчин бүрдүүлэх. Хамтарч байж сурна. Зөв, буруугаа хүлээн зөвшөөрч, суралцах хэрэгтэй. Гадаадын хөрөнгө оруулалт хүнийг ажилд сургаж, дэлхийтэй ойртуулдаг хэрэгсэл.

-Хэдийгээр бид өнөөдөр хямрал ярьж суугаа ч тэнгэр цэлмэх үед зах зээлээ өргөжүүлэх бэлтгэлийг хангах учиртай. Энэ талаар юу хийж болох вэ?

-Бэлтгэл хангахын тулд хамгийн түрүүнд англи хэл сурах хэрэгтэй. Бүх ►

► нийтийн англи хэлний боловсролыг дээшлүүлэхэд томоохон ахиц гаргах нь нэн түрүүнд хийх ажил. Арван жил, их сургуулиас нь чанартай англи хэлийг сургахад анхаарах. Гадаад хүнтэй чөлөөтэй харилцдаг түвшинд хэлийг хэрэглээ болгох хэрэгтэй. Амжилт олсон Азийн бар орнууд ихэвчлэн хүндээ хөрөнгө оруулсан байдаг. Хүнээ хөгжүүлж улс хөгждөг болохоос бөөн мөнгө орж ирлээ гээд хөгжихгүй. Мөнгийг баялаг болгож хувиргах хүнээ бэлтгэх хэрэгтэй.

Б.Б.: -Гадаадын хөрөнгө оруулалт зогсохоор эдийн засаг хэрхэн унаж, ганхаж байгааг Оюутолгойн далд уурхайн жишээгээр амсалаа монголчууд. Хөрөнгө оруулалт бол үйлдвэрлэл хөгжих хөшүүрэг. Тиймээс хөрөнгө оруулалтын нэг хэлбэр удаан хугацааны төслийн зээл. Ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэлд энэ чиглэлийн санхүүжилт шаардлагатай байдаг.

Л.Д.: -Бидний хүлээж байгаа зүйл том хөрөнгө оруулалт. Уул уурхайн салбарт стратегийн орд гэж хуульд заагаад байгааг нэг талаасаа зөв гэж боддог. Гэхдээ төр тухайн ордын 50 хувийг эзэмшинэ гэхээс илүү дотоодын аж ахуйн нэгжийн мэдэлд байвал онох юм шиг санагддаг. Дотоодын хөрөнгө оруулагчид тухайн хөрөнгийг нь гаргаж байгаа бол төр оролцохгүй байсан ч болно. Хамгийн гол нь төр оролцохгүй тохиолдолд гаднынхан дангаараа орж ирээд 100 хувь ашиг хийгээд гараад байвал манайд хэцүү. Үндэсний хөрөнгөтнийг бий болгох, техник технологийг бүрдүүлэх, ажиллуулах нь чухал. Уг нь хувийн хэвшилд нь илүү мэдрэмж бий.

“Бүхнийг маш нимгэн мэдсэн хүн олон байна”

-Танай компаниуд хүний нөөцийн бодлогоо ямар түвшинд авч явна. Өнөөдөр хүний нөөцийн бодлого дээр хамгийн тулгамдсан асуудал юу байна вэ?

Б.Ж.: -Хүний нөөцийн бодлого бүгдийг шийдвэрлэнэ. “BSB сервис” компани нь 300 гаруй ажилтантай. Манайх аль болох гадаадад төгсөгчдийг ажилд авахыг хичээдэг. Ажилчдаасаа ч гадаадад сургаж байна. Нэг хүнийг гадаадад сургах зардал жилийнх нь

бараг 30 мянган ам.доллар. Үүнийг хувийн компани өөрөө хийж дийлэхгүй.

Дараагийнх нь хүмүүжил. Монголын боловсролын системд хүмүүжил орхигдсон. Ажил хийхийг ял гэж үздэг болчихсон. Эцэг эх нь хүртэл зөв хүмүүжил өгч чадахгүй. Ажилд орж байгаа хүнээс ажил хийе гэсэн сэтгэл, чин эрмэлзэл харагдахгүй байна. Тэгсэн мөртлөө бэлэн, хөнгөн амьдрал хөөцөлдөх болж. Бусад улсад хүүхдийг хөдөлмөрт дуртай болгох хүмүүжлийг багаас нь өгдөг. Нэг үгээр хэлбэл, Боловсролын системийг бүхэлд нь төр хариуцсан шиг хариуцах хэрэгтэй.

Б.Б.: -Мэргэжилтэй боловсон хүчний хүний нөөцийн бодлого алдагдсан. Өнөөдөр өөрийнхөө төлөө хөдөлмөр хийгээд ажиллаж байгаа шүү гэсэн сэтгэгдэлтэй хүн байхгүй. Хэн нэгэн захирлын төлөө, хэн нэгэн компанийн төлөө ажиллаж өгч байгаа гэсэн бодолтойгоор ажлын цагийг хий дэмий өнгөрөөх сонирхолтой нь олширсон. Гэтэл тэр импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн бий болгох үйлдвэрийн машины ард зогсох хүн алга. Энэ нь төрийн бодлогын гажуудалтай шууд холбоотой. Мэргэжилтэй боловсон хүчний асуудлыг төрийн бодлогын түвшинд бэлтгэх ёстой. Сүүлийн үед нэг компаниас нөгөө компани руу сүргээрээ нүүдэллэх байдал ч гаарсан.

Л.Д.: -Манайд нүүдэлчин маягийн сэтгэлгээ яваад байна. Би Японд сургууль төгссөн. Япон хүн хоёр байтугай дөрөв дахин ахиу цалин амласан ч явдаггүй. Япончууд тухайн компаниас өөрийн гэр бүл гэж үздэг. Компанийнхаа төлөө насаараа ажиллана гэсэн философитой. Харин манайд ажиллах, амьдрахтай холбоотой философийн асуудал сул. Манай компани хүмүүсээ боловсруулах чиглэлээр нэлээд ажил хийдэг л дээ. Өнөө үед хүний нөөцийн асуудалд гурван зүйлийг чухалчилж байна. Мэдлэг, чадвар, хандлага. Тухайн чиглэлээр мэдлэгтэй, чадвартай байж болно, хандлага хүмүүжил маш чухал шалгуур. Энэ үүднээс монгол хүний мэдлэгийг нь аваад үзвэл маш нимгэн бөгөөд өргөн байдаг. Бүхнийг мэддэг. Жаахан маажингуут дороо зэс нь цухуйдаг. Би залуучуудад хэлдэг юм. Хүний мэдлэг


хасах тэмдэг шиг биш “Т” үсэг шиг байх ёстой гэж. Бүхнийг өргөн мэддэг. Гэхдээ нэг зүйлийг гүнзгий мэддэг байх хэрэгтэй гэж захидаг. Монголд нэг зүйлийг ухсан хүн ховор. Харин бүхнийг маш нимгэн мэдсэн хүн олон байна. Дээрх гурван чанарын хамгийн чухал нь хүн чанар буюу хандлага. Далайд явж байна гэвэл хандлага завь нь юм. Нөгөө хоёр нь сэлүүр. Бид дан сэлүүрээр яваад байна. Манайхан ажил, мэргэжлийн праимидаар үзэхээр дээд сургууль төгссөн дарга улс болсон. “Чин” гэж төгссөн малчин, тариачин олширч, “тэн”, “ч” төгсгөлтэй мэргэжилтэн зохиостой хэмжээнд байгаасай.

“Хямралтай жил Улсын баярыг бүү тэмдэглэ”

-Хэлэлцүүлгийн төгсгөлд юу хэлэхийг хүсэж байна вэ?

Л.Д.: -Бизнесийн салбарынхан төдийгүй иргэд бүсээ чангалсан. Одоо хязгаартаа тулчихаад, чангалсан бүс нь тасарчих гээд байна. Иймээс тогтворжуулах арга хэмжээ байдаг бол үр дүнтэй авч хэрэгжүүлэхээ л гэж хэлье. Нэг үг байдаг. “Ой харсан хүн мод хардаггүй, мод харсан хүн ой хардаггүй” гэж. Өөрөөр хэлбэл, ойд яваа хүн өмнөх модоо л харна. Харин дээрээс харвал ой бүтнээрээ харагдана. Ой харах чинь улстөрчдийн хийх ажил. Бид бол модон дотор явж байгаа. Тиймээс модоо л харна гэсэн үг. Ойгоо бүтнээр нь харж байгаа хүмүүс болохгүй байгааг засч залруулах үүрэгтэй. Мөн “Булингартай усанд л том загас амьдардаг. Тунгалаг усанд хэзээ ч том загас амьдардаггүй” гэсэн үг бий. Монголд далд эдийн засаг дотор л том загаснууд хөвж яваа. Тиймээс том загаснуудтайгаа ажиллах хэрэгтэй. Бизнесийн тэгш шударга өрсөлдөөнийг бий болго. Энэ бол төр засгийн зүгээс авч хэрэгжүүлэх том тус юм.

Б.Б.: -Ерөнхий сайд саяхан наадмыг хэдэн тэрбум төгрөгөөр хийх талаар ярьж байна лээ. Эдийн засаг ийм хүнд байхад наадам хийж яах вэ дээ. Тэр их мөнгийг баяр тэмдэглэх нэрээр салхинд хийсгээд юм хожих юм. Ийм илүү зардлаа болиоч ээ. Татвараар төвлөрүүлсэн төсвөө зөв зарцуулаач гэж хэлмээр байна. ■



MLLS Led's make
the world happy!

MONGOLIAN LED LIGHTING SYSTEMS
Installation, Service, Trade, Consulting, Entertainment

Гэрэл гэгээтэй амьдралын төлөө

ШИДЭТ ГЭРЭЛ

Дэлхийн олон улс орнуудад өдөр шөнө нь ялгагдахгүй гэгээтэй байдгийн нууц нь орчин цагийн дэвшилтэт технологи бүхий Лед гэрэлтэй холбоотой байдаг байна. Энэхүү шидэт гэрэл нь цахилгааны асар өндөр хэмнэлт болон олон жилийн ажиллагаа, зөв таатай тусгал зэрэг тал талын ашиг тусаараа дэлхий нийтэд сайшаагдсаар байна. Манай компани нь Германы Osram чиптэй EFG брэндийн албан ёсны дистрибьютерээр сонгогдон 2 дахь жилдээ ажиллаж байна. Бид хэрэглэгчиддээ эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй / Эко гэрэл /, 50,000 цагын найдвартай ажиллагаатай, халалтын эсрэг хөргөлтийн системтэй, гадна, дотор орчны 191 нэр төрлийн Лед гэрэлнүүддээ 3 жилийн баталгаа өгөн айл өрх, аж ахуйн нэгжүүдэд худалдаалж байна. Та бидний өргөнөөр хэрэглэж ирсэн 60, 80, 100 ваттын лампуудыг энэхүү Лед гэрэл нь бүрэн орлож, олон талын ашиг тусаараа гайхагдан зах зээлээс түрэн гаргасаар байна. Улс эх орныхоо их бүтээн байгуулалтад зүтгэж буй аж ахуйн нэгж, айл өрхүүд маань ирээдүйд Лед гэрлийг хэрэглэснээрээ тогны зардлаа 90% хүртэл хэмнээд зогсохгүй, цахилгаан түгээх станцуудын ачааллыг эрс багасгаж, тогны хязгаарлалтаас ангид байж, эдийн засгийн бодит хэмнэлтийг мэдрэх болно.



Цахилгаан хэмнэлтийн тооцоо
/зөвхөн 1ширхэг гэрлээр тооцов/

1 квт цахилгааны үнэ 84төг

	Энгийн 1ш гэрэл /100ватт/	1ш Лед гэрэл /7ватт/
Өдөрт /8 цаг/	67,2 төг /0,8 квт/	4,7 төг /0,056 ватт/
Жилд	24,192 төг	1,692 төг
3 жилд	72,576 төг	5,076 төг

Хэмнэлт : 1 ширхэг гэрэл жилд 22,500 төгрөг

Хаяг: Баянгол Дүүрэг, 1-р хороо Алтай хотхон, 17-р байр, #101,102 тоот
Э-Мейл: info@mlls.mn
Web: www.mlls.mn
Утас: 88113403, 99084050, 95668877

БОДЛОГО, ШИЙДВЭР

107-ГИЙН БАЛАГ

С.ЗАЯА

Газрын доорх баялаг маань манайхыг дэлхий дахинд “моодонд” оруулсан шигээ эргээд шалдаа буулгачихаад байна. Мэдээж баялгийг хэрхэн ашиглах талаар гаргасан бодлого шийдвэр нь ийм үр дүнг бий болгосон. Үүнийг хоёрхон жил хүрэхгүй хугацаанд гадаадын хөрөнгө оруулалт 70 гаруй хувиар буурснаар баталж болох. Нэгэнт унтарсан хөрөнгө оруулалтыг сэргээхэд уул уурхайн салбарыг юун түрүүнд итгэлээр ташуурдах нь чухал байна. Тиймээс манай сэтгүүл энэ удаа тус салбар уналтад ороход юу нөлөөлсөн, цаашид хэрхэх талаар хөндлөө.

Ашигт малтмалын газрын холбогдох удирдлагуудын 2009, 2010 онд хууль бусаар олгосон 107 лицензийг

хүчингүй болгож, төр мэдэлдээ авсан нь хөрөнгө оруулагчдыг хүлээлтийн байдалд оруулахад ихээхэн нэрмээс болж буй аж. Энэ талаар ямар шийдвэр гарахыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид чих тавин хүлээж байна. 107 лицензийн хүрээнд 24 аж ахуйн нэгж 34 тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар нэгдэж, шударга эзэмшигч гэдгээ илэрхийлж буй аж. Учир нь, хууль бусаар олгосныг компаниуд тухайн үедээ мэдээгүй нь хохирогч гэдгийг гэрчлэх баримт гэж тэд үзжээ. Ашигт малтмалын тухай хуульд лиценз цуцалдаг тав, Аж ахуйн нэгжийн тухай хуульд 2-3 үндэслэл бий. Эдгээрээс бусад үед лиценз цуцлах эрх зүйн зохицуулалт байхгүй. Лицензээ цуцлуулсан дээрх 24 компани 25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байжээ. Тэдний дунд

жоншны баяжуулах үйлдвэр барьсан хүн ч байсан аж. Банкнаас зээл аваад үйлдвэр бариад удаагүй байтал лицензийг нь цуцалчихсан гэнэ.

Компаниудын ихэнх нь гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай аж. Тэд нөхцөл байдал ийм болсныг Торонто, Австралид бүртгэлтэй гадаадын хувьцаат компанидаа мэдэгдэж байх ёстой гэнэ. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл очингуут биржүүдээр тарж, англи хэл дээр гардаг дэлхийн бүхий л мэдээллийн хэрэгслээр цацагддаг байна. Энэ нь Монголын нэр хүндийг дэлхий дахинд унагасан явдлуудын нэг болжээ. Уг асуудлыг шийдвэрлэхээр Уул уурхайн яамнаас Ажлын хэсэг байгуулагдсан ч ямар шийдэлд хүрэх нь тодорхойгүй байгаа аж.

Үүнээс гадна Засгийн газраас “Урт ▶



► нэртэй” хуулийг хэрэгжүүлэхийн тулд 200 гаруй шороон ордын лицензийн үйл ажиллагааг хоёр жилээр зогсоогоод байгаа. Энэ хүрээнд зөвхөн нөхөн сэргээлт хийх үүрэг өгсөн. Гэтэл хоёр жил нь дууссан ч үйл ажиллагааг нь явуулахгүй байсаар. Тухайн компаниуд олборлолт явуулж мөнгө олж байж, нөхөн сэргээлт хийнэ. Мөн Засгийн газар нөхөн сэргээлт хийлгэхийн тулд компаниудад хохирлыг нь өгөх ёстой. Тэгж чадахгүй байгаагаас аль аль талдаа байдал гагцхиад буй.

Засгийн газраас алдсан нэр хүндээ олж авахын тулд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хөрөнгө оруулагчдыг дэмжих гэж байна. Түүнчлэн манайх анх удаа Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигтэй болсон. Уг бодлогод нийцүүлэн хуульдаа өөрчлөлт оруулахаар Уул уурхайн яамнаас мэргэжлийн төлөөллийг оролцуулсан Ажлын хэсэг гарчээ. Бодлогын баримт бичигт ашигт малтмалыг хувийн хөрөнгөөр ашиглах уу, хайж олборлоход эрсдэлийг хэн үүрэх, хэрхэн хуваах талаар тусгасан ерөнхий тойм төдий зүйлийг тусгажээ. Харин нарийвчилсан зүйлийг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулж өгөх аж. Өөрөөр хэлбэл, компанийн нийгмийн хариуцлага, хувийн хэвшилд суурилсан, ил тод уул уурхайг хөгжүүлэх зарчимд тулгуурлаж, бодлогоо оруулсан байна. Энэ талаар Монголын уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа “АНУ-д 1872 онд Ашигт малтмалын тухай анхны хууль батлагдсан. Үүнээс хойш 10 гаруйхан удаа өөрчлөлт орсон байдаг. Уг хуулийн гол үзэл баримтлал нь холбооны газар нутаг дээр нийтийн өмчийг хувийн хөрөнгө оруулалтаар хайгуул хийж нөөцийг нь олвол тухайн хүний өмч болно гэх заалт юм. Одоо ч энэ заалт мөрдөгдөж байна. Энэ бодлого юм. Харин манайхан нийтийн үү, төрийн өмч үү гэдгийг шийдсэн нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй. Бодлого хуулийн журам, стандартын иж бүрдэл юм. Манайх хууль, бодлогоо холиод байгаа” гэв.

Ашигт малтмалын тухай хуульд хувийн хэвшлийг дэмжсэн зүйл заалт бага аж. Төрийн байгууллагын зүгээс хийх нэмэлт зохицуулалтууд түлхүү орж ирэх болчихоод буй нь хувийн хэвшлийнхнийг сандаргаж байгаа гэсэн. Хуулийн төсөл долоо хоног бүр өөрчлөгдөж буй учраас яг ямар заалт орох эсэх нь эргэлзээтэй байгааг хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт орж ажиллаж буй нэрээ нууцлахыг хүссэн эх сурвалж хэлсэн. Уул уурхайн яам мэргэжлийн байгууллагын саналыг хүлээж авахдаа хойрго байгаа тухай ч салбарын мэргэжилтнүүдийн төлөөлөл учирласан. Бодлогын баримт бичигт “Бодлогын зөвлөл”-тэй байна гэж заажээ. Гэтэл өнөөг хүртэл ийм зөвлөл байгуулагдаагүй байх жишээний. Уг нь зөвлөл хуулийн төслийн өөрчлөлтийг тухай бүрт нь хэлэлцээд явах боломжтой байж. Харамсалтай нь зөвлөлгүй учраас байн байн өөрчлөгдөөд байгаа аж.

Хуулийн төсөл хаврын чуулганаар батлагдвал бүх зүйл сайхан болно гэдгийг эрх баригчид удаа дараа тайлбарлаж байсан. Гэтэл гэнэт өргөс авсан мэт сайхан болохгүй гэдгийг энэ чиглэлийн мэргэжилтнүүд хэлж байна. Учир нь, манайд хууль эрхзүйн орчин таагүй болонгуут хөрөнгө оруулагчид өөр оронд хөрөнгө оруулалт хийсэн байдаг гэнэ. Манай эрхзүйн орчин тогтворжоогүй байхад тэд хийж буй ажлаа орхиод нааш ирэх нь мянгуужингийн үлгэр аж. Тиймээс хөрөнгө оруулалт татах нь цаг хугацааны асуудал. Хүнд сурталгүй байх, бизнесийг дэмжих, өмчийг хамгаалдаг болсон цагт манайх хөрөнгө оруулалт татна гэдгийг ч Н.Алгаа хэлсэн. Тэгэхээр хууль эрхзүйн орчноо тодорхой болгон тогтворжуулах нь цаг алдалгүй хийх ажил болжээ. Нөгөөтэйгүүр алдсан нэр хүндээ сэргээж, хөрөнгө оруулагчдын итгэлийг олохын тулд татвараараа байн байн оролдохгүй байх нь чухал юм байна. ■



УУЛ УУРХАЙ

ДУУСДАГГҮЙ ХЭЛЭЛЦЭЭР

Б.ТОГТОХ

Эдийн засгийн хямрал “Оюутолгой”-д найдлага тавихад хүргэж байна. Тэгвэл хямралыг гэтэлгэх аварга төслийн гүний уурхайн санхүүжилт хойшилж байгааг тус төслийн удирдагч “Туркойз Хилл Ресурс” ►►



“ Валютын орох урсгалын 50 орчим хувийг далд уурхайн санхүүжилт түгжээд байгаа аж. Хэдий гүнийн уурхайн санхүүжилт гацсан ч ил уурхайн үйлдвэрлэл хэвийн явж байна. “Оюутолгой” компанийн өөрсдийн тооцооллоор энэ онд 692 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх төлөвлөгөөтэй. Үүнээс одоогийн байдлаар 98.3 мянган тонныг нь одоо үйлдвэрлээд байгаа юм байна. ”

► компаниас мэдэгдсэн. Ингэснээр есдүгээр сарын 30-н хүртэл далд уурхайн санхүүжилт “завсарлага” авлаа. Уг нь төслийн санхүүжилтийг шийдэх хугацаа гуравдугаар сарын 30 байсан. Гэвч хувь нийлүүлэгч талууд харилцан тохиролцоонд хүрч чадаагүйн улмаас далд уурхайн бүтээн байгуулалт дахиад таван сар гацах нь. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн онд Лондонд эхэлсэн хэлэлцээр сунжирсаар байгаа нь энэ.

Валютын нөөцөө дундалж буй манай эдийн засаг мөддөө өндийхгүй нь бололтой. Уг нь гүний уурхайн хөрөнгө оруулалт болох эхний ээлжийн хоёр тэрбум ам.доллар зах зээлд ороод эхэлбэл нөхцөл байдал дээрдэх гээд байгааг Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх, тус банкны

ерөнхий эдийн засагч С.Болд хэлсэн юм. Гэвч ирэх намар хүртэл далд уурхайн санхүүжилт шийдэгдэхгүй нь.

Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Рио Тинто” группын гүйцэтгэх захиралд гуравдугаар сарын 27-нд захидал илгээгээд ч асуудал нааштай эргэсэнгүй. Уг захидлын араас “Эрдэнэс Оюутолгой” компанийн гүйцэтгэх захирал Д.Ганболд дахин захидал явуулсан. Гэвч үл ойлголцол арилсангүй. Харин Оюутолгой төслийн далд уурхайн санхүүжилт хойшилсон нь Монголын Засгийн газраас хамаараагүй гэдгийг Ерөнхий сайд олон нийтэд өнгөрсөн сард зарласан юм.

“Рио Тинто” компанийн зүгээс Оюутолгойн далд уурхайн 5.1 тэрбум

ам.долларын бүтээн байгуулалтаа царцаагаад жил болох гэж байна. “Туркойз Хилл Ресурс” компанийн гүйцэтгэх ерөнхий захирал Кэй Пристли хэлэлцээ үргэлжилж байна гэснээс өөр тодорхой зүйл өгүүлээгүй. Энэ нь гүний уурхай тойрсон асуудал есдүгээр сард баталгаатай цэгцэрнэ гэсэн үг бас биш юм. Өөрөөр хэлбэл, гүнийн уурхайн санхүүжилт алсарч байгаа нь хүндрэлийг улам дордуулах нь ээ.

Монголбанкны тооцоолж байгаагаар “Оюутолгой” энэ онд 93.2 мянган тонн цэвэр зэс агуулсан баяжмал үйлдвэрлэж, түүнээс 57.2 мянган тонныг гадаад зах зээлд нийлүүлэх учиртай. Түүнчлэн 9.9 тонн алт олборлож, үүнээс дөрвөн тонныг гадагш гаргахаар төлөвлөжээ. Ингэснээр нийт экспортын жилийн өсөлтөд 10, бодит ДНБ-ий жилийн өсөлтөд 5.7 хувийн нөлөө үзүүлэхээр байгаа аж. Хэрэв энэ онд “Оюутолгой” 700 мянган тонноос дээш зэсийн баяжмал экспортолсон тохиолдолд уул уурхайн татварын орлогын 26 хувийг, нэгдсэн төсвийн орлогын таван хувийг дангаараа бүрдүүлэх юм.

Монголын эдийн засагт эргэлдэж буй гурван төгрөг тутмын нэг нь Оюутолгойнх. Өөрөөр хэлбэл, таны авч буй цалингийн гуравны нэг нь уг төсөлтэй шууд болон шууд бус байдлаар холбоотой байжээ гэдгийг монголчууд эдийн засаг хүндэрсэн өнгөрсөн өдрүүдэд илүүтэй мэдэрч сууна. Тиймээс Оюутолгойгүйгээр эдийн засгийн нөхцөл байдлаа төсөөлж үзэхэд хүнд. Цаашдаа ч аварга төслийн эдийн засагт үзүүлэх нөлөө барьцаа лавшруулсаар байх нь.

Валютын орох урсгалын 50 орчим хувийг далд уурхайн санхүүжилт түгжээд байгаа аж. Хэдий гүнийн уурхайн санхүүжилт гацсан ч ил уурхайн үйлдвэрлэл хэвийн явж байна. “Оюутолгой” компанийн өөрсдийн тооцооллоор энэ онд 692 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх төлөвлөгөөтэй. Үүнээс одоогийн байдлаар 98.3 мянган тонныг нь одоо үйлдвэрлээд байгаа юм байна. Ил уурхайн үйлдвэрлэл бол зөвхөн эхлэл төдий. Харин жинхэнэ эдийн засгийг эрчимжүүлэх “мотор” нь далд уурхай. ■



Б.ЭНХЦЭЦЭГ

Турк болон Монгол Улс анх 1969 онд дипломат харилцаа, хамтын ажиллагаагаа албан ёсоор үзэглэсэн бөгөөд энэ онд 45 жилийн ой тохиож буй. Тиймээс манай сэтгүүл хоёр орны харилцаа хамтын ажиллагаа бусад улсаас юугаар ялгаатай болоод цаашид хэрхэн хамтын ажиллагаагаа өргөжүүлж болох талаар манай улсад Турк улсыг төлөөлөн суугаа Элчид сайд Мурат Карагозтой ярилцлаа.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

ТУРКИЙН БИЗНЕСМЭНҮҮДЭЭС МОНГОЛ ИЛҮҮ ИХИЙГ ХҮЛЭЭЖ БОЛНО

-Манай хоёр улсын харилцаа бусад улсынхтай харьцуулахад юугаараа онцлог вэ?

-Турк болон Монгол улс хоёул олон талт соёл болон үндэстний өлгийд төрж өссөн үр хойч нь. Монгол Улс Чингис хааны байгуулсан Их эзэнт гүрний залгамж бол Турк нь Оттаманы хаант улсын удам. Туркийн анхны төрт улсууд Монголын газар нутагт үүссэн. Тиймээс ч Туркийн үеийн чулуун дээр сийлсэн бичээсүүд Монгол Улсад өргөн тархсан байдаг.

Турк хэлээр ярьдаг, манай улсад сурч боловсорсон олон мянган Монгол хүнтэй би таардаг. Бидний хэл Алтай язгуурын Монгол бүлэгт харьяалагддаг учир ижил төстэй олон үг манай хоёр улсын хэлэнд бий. Эдгээр онцлогууд

нь биднийг нягт холбож байдаг.

Өнгөрсөн 45 жилийн хугацаанд харилцаа хамтын ажиллагааны хувьд бид дэвжиж олон зүйлд хүрсэн. Амжилтаа өдөр өдрөөр ахиулж буй. Бидний харилцаа илүү бэхжиж, стратегийн түншлэлд хүрнэ гэж харж байна.

-Турк улс аялал жуулчлалын голлох цэгүүдийн нэг. Тэгвэл энэ салбарт Монгол Улсын урдаа барих онцлогуудыг Та юу гэж боддог вэ?

-Монгол ер бусын үзэсгэлэнтэй орон. Энэ бол магтаал биш. Харин бодит байдал. Уудам цэлгэр газартай Монгол нь түүх соёл, байгалийн гоо үзэсгэлэн бүрдсэн өвөрмөц нутаг. Тиймээс аялал жуулчлалын салбарт

санал болгох онцлог, боломж их бий.

Улаанбаатар хот төдийгүй бусад 21 аймаг бүр өөрийн онцлог боломжуудтай. Тиймээс аялал жуулчлалд өндөр чадавхи байна. Энэхүү баялгийг таньж, сайн "Know how", хамтын ажиллагаатай хамтатгаж мөн ирээдүйнхээ төлөө энэ салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Аялал жуулчлал удахгүй Монголын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болно гэдэгт итгэлтэй байна.

-Турк улсын иргэд аялах газраа сонгохдоо тухайн нутаг орны юуг нь илүүд үзэж, анхаардаг вэ?

Визгүй зорчих журам, аяллын зардал, соёлын үнэт зүйлүүд нь аялах газраа ►

► сонгоход ихээхэн нөлөөлдөг.

-Монгол Улс Турк хүмүүсийн хувьд анхаарал татдаг газруудын нэг байж чадна. Тэд Монголд өөрсдийн түүхээ эргэн сөхөж, Туркийн анхны төрт улсуудын гарал үүслийн мөрөөр аялж болно. Мөн Монголын соёл заншил, гоо үзэсгэлэнтэй танилцах нь тэдэнд сонин байх болов уу.

Энэ оны дөрөвдүгээр сарын 11-нээс хоёр орны хооронд 30 хоног визгүй зорчих журам хэрэгжиж эхэлсэн байгаа.

-Турк улсын аялал жуулчлалын амжилтын нууц нь юу вэ?

- Засгийн газар 1980-аад оноос эхлэн аялал жуулчлалд ухаалаг замаар ихээхэн хөрөнгө оруулж эхэлсэн. Холбогдох хуулиудыг шинэчилж, татвараас чөлөөлж, хөрөнгө оруулалтыг дэмжиж, хувийн хэвшлийг хөхиүлэх болов. Гэвч энэ нь дардан замаар хэрэгжчихсэн зүйл биш л дээ. Асуудал олон байсан. Эцэстээ сайн бодлогуудыг гаргаж ирж чадсан.

Өнөөдөр Туркийн аялал жуулчлалын салбар дотроо нэлээд төрөлжчихсэн. Аялагчид “далай-нар-элсийг” таалахаас гадна эрүүл мэнд, шашин, өвлийн спортын аялал зэрэг олон сонголттой байдаг болсон байгаа. Тиймээс энэ жил хамгийн олон уншигчтай аялал жуулчлалын “TripAdvisor” цахим хуудас Истанбул хотыг жуулчдын “номер” нэг сонголтгоор тодруулсан нь санаандгүй явдал биш юм.

Өнгөрсөн жил Турк улсад 35 сая шахам аялагч зочилсон. Үүний дүнд аялал жуулчлалаас газар дундын тэнгисийн энэ орон 33 тэрбум ам.долларын ашиг олсон. Дэлхийн ТОП 10 газрын жагсаалтад Туркийн Анталья болон Истанбул хот багтдаг. Анталья хот гэхэд хоёрхон сая хүнтэй ч 11 сая жуулчин жилдээ хүлээн авдаг. Эдгээр наад захын жишээ нь манай хоёр улсын хооронд хамтран ажиллах ямар их боломж байгааг харуулна.

Турк руу манай залуус өндөр боловсрол эзэмшихээр олноороо зорих болсон. Монгол оюутнуудын суралцдаг голлох мэргэжлүүд юу вэ?

Манай хоёр улсын харилцаа хамтын

ажиллагааны хүчирхэг тулгуур салбаруудын нэгт боловсрол зүй ёсоор багтдаг. Ерээд оноос монголчууд Турк руу идэвхтэй зорчих болсон. Өнөөгийн байдлаар 900 гаруй монгол хүн манай улсад сурч байна. Тэдний 340 орчим нь Туркийн Засгийн газрын тэтгэлэгтэй суралцаж байгаа юм.

Тэтгэлгээр бакалавраас дээш зэрэг эзэмшихийг хүсэгчдийн хувьд энэ жил бид 180 хүний

“**Монгол ер бусын үзэсгэлэнтэй орон. Энэ бол магтаал биш. Бодит байдал.**”

хүсэлт хүлээн аваад байна. Өнгөрсөн сард урьдчилсан ярилцлагыг авсан. Харин бакалаврын зэргээр суралцахыг хүсэгчдийн танилцуулгыг тавдугаар сарын дунд үе хүртэл хүлээн авна. Бид тэтгэлэг олгох квотоо 2014 онд найман хувиар нэмэгдүүлэх хүсэлтэй байгаа. Цаашид ч өсгөх зорилт бий. Харин сонгон суралцах мэргэжлүүдийн хувьд анагаах ухаанаас эхлээд ХАА, мэдээлэл технологи, хэл судлал зэрэг бүхий л чиглэлээр суралцаж байна.

-Барилгын салбарт тухайлбал

Монгол, Турк хэрхэн түншилж болохоор байна вэ?

-Статистикээс үзэхэд, Дэлхийн ТОП 235 барилгын компанийн 33 нь Туркийн барилгын компани байдаг. Энэ үзүүлэлтээрээ салбарынхаа хэмжээнд дэлхийд хоёрт жагсдаг. Туркийн бизнесмэнүүд дэлхийн өнцөг булан бүрт томоохон барилгын төслүүдийг хэрэгжүүлдэг. Тиймээс тэдэнд Монголд өөрсдийгөө харуулах бүх чадамж нь бий.

“**Монголын зах зээлд Туркийн томоохон компаниуд орж ирж байгааг дуулгахад таатай байна.**”

Энэ бол зөвхөн эхлэл. Туркийн бизнесмэнүүдээс илүү ихийг хүлээж болно.

-Туркийн барилгын компаниуд өөрийн гэсэн стандартаар үйл ажиллагаа явуулдаг байх. Тэгвэл онцлог нь юу вэ?

-Туркийн барилгын салбартай хамтарч ажиллаж буй учир богино хугацаанд үүнийг мэддэг болж, дасч байна. Туркуудын ажиллах арга барил нь нэг ►

Туркийн эдийн засгийн үзүүлэлтүүд, 2013 оны байдлаар

Турк улсын эдийн засаг	Дэлхийд 17-р байрт
	Европт 6-р байрт/ 2012 он
Хүн ам	76 сая
Ажилгүйдэл	9.7 хувь
Ажиллах хүч	28 сая
ДНБ	820 тэрбум ам.доллар
ДНБ-ий өсөлт	4 хувь
ДНБ дундаж өсөлт	5.2% /2002-2012/
Нэг хүнд ногдох ДНБ	10.782 ам.доллар
Инфляци	7.40%
Төсвийн алдагдал	ДНБ-ий 1.1 хувьтай тэнцүү
ГХО-ын дотогшлох урсгал	12.7 тэрбум ам.доллар
ГХО-ын гадагшлах урсгал	3.2 тэрбум ам.доллар
Гадаад худалдааны хэмжээ/ өсөлт	403.5 тэрбум ам.доллар/ 3.7 хувийн жилийн өсөлт
Экспорт	151.8 тэрбум ам.доллар
Импорт	251.6 тэрбум ам.доллар
Аялал жуулчлал	39 сая жуулчин хүлээн авсан
-Салбарын орлого	-32.3 тэрбум ам.доллар
-Дэлхийд эзлэх байр суурь	-Зургаадахь хамгийн их зорьдог орон
Хөрш/ 8 орон	Болгар, Грек, Гүрж, Армен, Иран, Азербайжан, Иран, Сири

▶ талаар Монголын хэрхэн бизнесийн үйл ажиллагааг явуулах вэ гэдэг сэтгэхүйг өөрчлөх болов уу. Зориг, зарчим, дэг журам, нөр их хөдөлмөр, зүтгэл нь Туркийн компаниудыг тодорхойлдог. Тиймдээ ч тэд итгэл даахуйц байдаг. Нэгэнт зах зээлд ороод ирвэл хариуцсан ажлаа тогтсон хугацаандаа нямбай хийж гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна. Тэд бага унтаж, их хийдэг хүмүүс.

-Ойрын ирээдүйд Монгол болон Турк улс хамтын ажиллагаагаа өргөжүүлж болох ямар салбарууд байна вэ?

-Турк улсын эдийн засаг сүүлийн 10 жилийн хугацаанд дунджаар таван хувитын тогтмол өсөлттэй байж ирлээ. Туркийн Засгийн газрын авч хэрэгжүүлсэн макро эдийн засгийн хүчтэй стратеги, төсөв, мөнгөний хянамгай бодлого, бүтцийн шинэчлэл нь өндөр өсөлтийг бий болгож, эдийн засагт итгэх итгэлийг нэмэгдүүлсэн. Тэр дундаа бүтцийн шинэчлэл нь улсын макро эдийн засгийн суурийг бэхжүүлсэн.

Үйлдвэрлэдэггүй орон өндөрт хүрч чаддаггүй. Тиймээс Монгол улс үйлдвэрлэгч орон болохыг чармайж байгааг дэмжиж байна. Гэвч үүнд сайн туршлага, түншүүд хэрэгтэй. Турк улсыг би энэхүү хамтрагч нь байж чадна гэж бодож байна.

Монголын хувьд уул уурхай бол түлхүүр нь гэдгийг мэдэж байгаа. Гэвч тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангахын тулд эдийн засгаа төрөлжүүлэх нь зайлшгүй. Турк улсын хувьд Монголын эдийн засгийн чухал салбарууд болох газар тариалан, мал аж ахуй, хүнс, ноос, ноолуур, арьс ширний салбарт онцгой хувь нэмэр оруулж, туршлагаасаа хуваалцаж чадна.

-Танай улс Сири, Иран, Ирак болон Йордан тэргүүтэй улс төрийн хувьд тийм ч тогтвортой бус улсуудтай хиллэдэг. Тэгвэл ийм геополитикийн сонирхолтой байршилтай орны гадаад бодлогын онцлог юу байдаг вэ?

Турк бол Евроазийн голомт болсон цэг. Манай улс Европ, Ази болон Африк гэсэн гурван тивээр хүрээлэгддэг. Энэхүү соёл болон

түүхийн гүн хамаарал бүхий геостратегийн байршил нь манай улсын онцлог болж байдаг. Энэ нь хөршүүдтэйгээ эдийн засгийн хувьд түншлэхэд тус болдог. Бүсийн байгууллагууд тухайлбал BSEC D8, ECO зэрэгт Турк улс гишүүнчлэлтэй нь эдийн засгийн хүрээнд Туркийн гадаад бодлогын бүсийн хандлага, олон талт байр суурийн тусгал юм. Түүнчлэн G20-ийн нэгт багтдаг нь дэлхийн эдийн засгийн засаглалд хариуцлагатай оролцогч талын байр сууриа нэмэгдүүлж буйг илтгэж байгаа.

Турк улс хэцүүхэн хөршүүд дунд буюу халуун цэгт оршдог. Гэвч бид тэдгээр улсын хооронд тогтвортой байдлыг тогтоох үүргийг гүйцэтгэдэг.

Өдөр ирэх тусам Туркийн “зөөлөн” хүч идэвхжих шилжилт харагдаж байна. Хүйтэн дайны үед бид цэрэг зэвсэг болон холбоотон улсууддаа найддаг байсан байж болно. Харин сүүлийн 10-15 жилийн хугацаанд Турк нь бүсийн шинэ хүч болон гарч ирж байгаа бөгөөд бидний авч хэрэгжүүлж буй арга хэмжээ глобал нөлөөллийг ч дагуулж болох талтай.

Манай улсын хувьд гадаад бодлогын чигийг тодорхойлдог голлох байгууллага Гадаад хэргийн яам. Мөн холбогдох агентлагууд тэр дундаа Хамтын ажиллагаа, хөгжлийн агентлаг чухал үүрэгтэй. Мөн хувийн хэвшлийн компаниуд энэ тал дээр мөн дутахгүй чухал байр суурийг эзэлдэг. ■

ҮНЭ ТОГТВОРЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

ТОГТООЖ ДИЙЛСЭН ҮҮ

Б.БАЯРТГОХ

Үнэ тогтворжуулах хөтөлбөр энэ онд үргэлжилнэ. Тус хөтөлбөрийн хүрээнд өнгөрсөн онд таван дэд хөтөлбөр хэрэгжсэн. Хөтөлбөр нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгах. Ингэснээр нэг оронтой тоонд инфляцийг царцаах гэж Монголбанк дээрх хөтөлбөрийг мөнгөжүүлсэн. Шинэчлэлийн гэх тодотголтой Засгийн газарт Төвбанк жилийн өмнө ингэж итгэл үзүүлэн үнэ тогтворжуулах зориулалтаар гурван их наяд төгрөгийг зах зээлд гаргасан юм.

Инфляцийг бараг л хоёр дахин бууруулахаар Монголбанк Засгийн газартай хамтарч ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд өнгөрсөн оны турш зах зээл дээрх зарим бараа бүтээгдэхүүний үнийг барьсан гэж хэлж болно. Энэ нь чөлөөт зах зээлийн эдийн засагтай манай орны

хувьд гажуу үзэгдэл мэт боловч эрсдэлийг төр хуваалцсан хэрэг. Хоёр оронтой инфляцийн эсрэг зогсох мөнгөний бодлоготой дэд хөтөлбөрүүд гол нь нийцэж байсан юм.

Жил тойрон “явсан” таван дэд хөтөлбөрийн үр дүнд суурь инфляци өнгөрсөн гурван жилийн дунджаас 5.9 хувиар буурсан. Тухайлбал, махны үнийн өсөлт өнөөдрийн байдлаар өнгөрсөн гурван жилийн дунджаас 2.1 дахин бага байжээ. Энэ нь махны үнэ огт өсөөгүй гэсэн үг биш. Харин өсөлтийн хурдацыг сааруулж, иргэдэд очих байсан үнийн дарамтыг тодорхой хэмжээнд хазаарлаж, эрсдэлийг шингээсэн гэж Ерөнхий сайд үнэлсэн. Гэвч энэ оны дөрөвдүгээр сарын 26-ны байдлаар үхрийн цул мах кг нь “Хүчит шонхор” зах дээр 10500 төгрөгт хүрээд байна. Өнгөрсөн ономын үед үхрийн цул мах нэг кг нь 9500 хүрч байсан юм. Уг нь хөтөлбөрийн хүрээнд махны үнийг тогтворжуулах гэж 87 ▶



Үнэ тогтворжуулах хөтөлбөр:

-Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулахад 248 / тэрбум төгрөг/

-Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулахад 303 /тэрбум төгрөг/

-Шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулахад 167 /тэрбум төгрөг

-Эрчим хүчний үнэ тарифыг тогтворжуулахад 80 /тэрбум төгрөг/

-Барилгын гол нэр төрлийн материалын үнийг тогтворжуулахад 1608 / тэрбум төгрөг/

▶ тэрбум төгрөгийг гурван компанид хувааж олгосон. Үүний үр дүн гарсан эсэх нь өнөөг хүртэл ойлгомжгүй байгаа юм. Махны үнэ өнгөрсөн жилийнхээс 15 хувиар өсөөд байгаа нь хөтөлбөр хэрэгжээгүй жилийнхтэй адил өсөлт болж таарч байна.

Хөтөлбөрийн хүрээнд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг тээвэрлэх хугацаа өнгөрсөн гурван жилийн дунджаас 2.2 дахин түргэссэн. Үүнээс гадна хөтөлбөрийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний биет нөөц 95 мянган тоннд хүрч, өнгөрсөн гурван жилийн дунджаас 2.2 дахин өсөөд байгаа нь чамлахааргүй амжилт болохыг албаны хүмүүс хэлж буй. Ингэснээр өнгөрсөн онд шатахууны үнэ харьцангуй тогтвортой байсан. Шатахууны үнийг валютын ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор 13 компанид 192 тэрбум төгрөгийн зээлийг 3.8 хувь буюу маш бага хүүтэй олгосон байдаг. Цаашдаа дээрх

нөхцөл хэр удаан үргэлжлэх нь таамаг төдий.

Барилгын салбар 2013 онд 125 хувийн өсөлттэй гарсан. Энэхүү өсөлт нь өмнө байгаагүй “тэсрэлт” бөгөөд Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн амжилт байсан гэж тэмдэглэж болохоор. Хөтөлбөрийн хүрээнд арматур, цемент импортлодог компаниудад 276 тэрбум төгрөг олгосон. Үүнийг задалбал, цементийн нийлүүлэлтэд 48 тэрбум, арматурт 81 тэрбум, энэ чиглэлийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд 146 тэрбум төгрөгийг гаргасан. Ингэснээр цементийн үнийг тодорхой хугацаанд тогтоон барьсан ч үнэ өссөн юм.

Инфляцийг тогтворжуулах анхны тохиолдол буюу Монголбанк инфляцийн эсрэг төгрөг хэвлэсэн гэдгээрээ түүхэнд үлдэж байна. Энэ мөнгө нь ажлын байраа хадгалах, эдийн засгийн бодит өсөлтийг хамгаалах зорилготой байсан. Үр

дүнд нь 170 мянган ажлын байрыг зах зээлд авч үлдсэн гэж Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал хэлсэн удаатай.

УИХ-дахь МАН-ын бүлгийн дарга С.Бямбацогт “Үнэ тогтворжуулах нэрийн дор гурван их наяд төгрөгийг төсвөөс гадуур тодорхой улс төрийн бодлогын хүрээнд зарцуулсан. Гэвч мах, гурил, барилгын материал, орон сууцны үнэ бодит байдал дээр ямар байгааг хүн бүр мэдэж байгаа” хэмээсэн. Тогтворжуулах хөтөлбөрийн мөнгө валютын ханшийг чангаруулсан гэж сөрөг хүчин болон зарим эдийн засагч үзэж байна.

Тэдний зүгээс нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцийг бууруулах гэж оролдохдоо эрэлтээс үүдэлтэй инфляцийг хөөрөгдсөн хэмээн Төвбанкийг буруутгаж байгаа юм.

Харин Засгийн газар Үнэ тогтворжуулах хөтөлбөрт ам сайтай байдаг. Манайх шиг эмзэг эдийн засагтай оронд төрийн зохицуулалт зарим талаараа байх шаардлагатайг хувийн хэвшлийнхэн хэлж байсан. Тиймээс энэ онд Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг арай өөр нэрээр буюу Зарим стратегийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах гэсэн хувилбараар УИХ-д тогтоолын төсөл байдлаар оруулахаар зэхжээ.

Гурван жилийн “мандат”-тай Үнэ тогтворжуулах хөтөлбөрт энэ оноор хаалтаа хийх үү, цаашаа үргэлжлэх үү гэдгийг хэлэхэд эрт байна. Эдийн засаг хүнд, импортыг хязгаарлаж буй энэ үед уг хөтөлбөрийг үргэлжлүүлэх нь ч дээр байж магад. Нэг үгээр хэлбэл хэлбэл, Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг сайшаах, шүүмжлэх нь эн тэнцүүхэн жин татаж буй. Хэрвээ үргэлжлүүлэхээр бол хөтөлбөрт хамруулах компани, аж ахуйн нэгжийг том жижиг гэж арын хаалга харахгүйгээр үйлдвэрлэж, бүтээж чадах хүмүүсээ ижил тэнцүү дэмжээсэй гэдгийг баялаг бүтээгчдийн зүгээс хэлж байсан юм. Эдийн засагчдын хувьд болон Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг байгууллагын зүгээс Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг зогсоох нь дээр гэж үзэх нь ч бий. Эцсийн шийдвэрийг улстөрчид гаргах учраас иргэд олон нийтийн зүгээс илүү үр дүнг л хүлээж сууна. ■

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ӨСӨЛТ СААРАХ Ч, ХЯМРАХ
ДОХИО БИШ

Б.ЭНХ

Өнгөрсөн жилийн хувьд онцлох эдийн засгийн салбар нь үнэт цаасны зах зээл байсан. Дэлхийн томоохон хөрөнгийн захууд ид шидийн гэмээр өндөр өсөлтийг үзүүлж байлаа. Тухайлбал, Америкийн S&P индекс 2013 онд 30 хувиар өссөн бол Японы Nikkei 57 хувиар өсч гайхшруулсан. Үүнийг “The Economist” сэтгүүл нэгдүгээрт дэлхийн эдийн засаг сэргэнэ гэсэн итгэл хоёрдугаарт, улсуудын мөнгөний дэмжих бодлоготой холбон тайлбарласан байдаг. Харин энэ жилийн эхэнд дээрх гайхамшиг замхарч, дэлхийн үнэт цаасны зах зээлээс гурван их наяд ам.доллар арчигдсан. “S&P” индекс таван хувийн бууралттай байгаа бол Nikkei 14 хувь, хөгжиж буй зах зээлийн MSCI индекс өсөн хувиар тус тус унаад байна.

Эдийн засагчдын зүгээс энэ жил шинээр гарч ирж буй зах зээлүүдийн үл хөдлөхийн салбарын уналтын дүр зураг эдийн засгийн өсөлтийг хамгийн их чангаа хүчин зүйл гэж үзэж байгаа. Учир нь тэдгээр улсуудад зээлийн шаардлага чангарч, гаднын хөрөнгө оруулалт хангалттай орж ирэхгүй байгаа юм. Үүгээр зогсохгүй, таваарын үнэ төдийлэн сэргэхгүй хэвээр байгаа бөгөөд төмрийн хүдэр л гэхэд өнгөрсөн сард 8 хувиар, энэ жилийн эхнээс хойш өдийг хүртэл нийтдээ 17 хувиар уначихаад байна.

Гэхдээ сонин хэвлэлийн нүүр дүүргэж буй энэхүү гутранги эдийн засгийн тоонууд Америк эдийн засгийн сэргэлтээсээ ухарч, Хятадын эдийн засгийн өндөр өсөлт огцом уруудна гэсэн үг биш. Хэдийгээр хөгжиж буй

орнуудын эдийн засгийн өсөлт энэ жил саарахаар байгаа ч “хямрах” шинж байхгүй. Тэр дундаа Хятадын эдийн засгийн үзүүлэлтүүд буурсан дүнтэй гарч байгаа ч аюулын харанга дэлдэхээр хэмжээнд биш гэдгийг эдийн засагчид хэлж байгаа юм. Тиймээс энэхүү одоогийн бууралттай дүр зураг нь уналт гэхээсээ илүү түр зуурын “ганхалт” байж болохыг тэд хэлж байгаа юм.

Тэд юу гэв

Дэлхийн эдийн засаг өнгөрсөн жилийнхээс өөдрөг байна гэж дэлхийн томоохон санхүүгийн байгууллагууд үзэж байгаа ч өнгөрсөн дөрөвдүгээр сард тэдний дийлэнх нь эдийн засгийн өсөлтийн төлвөө бууруулсан билээ.

Хэдийгээр тэд ийнхүү тооцооллоо шинэчлэсэн ч энэ жил дэлхийн тэр дундаа хөгжингүй орнуудын эдийн засаг өнгөрсөн жилийнхээс харьцангуй дээшилсэн үзүүлэлттэй гарна гэсэн тооцооллоосоо ухарсангүй. Дэлхийн эдийн засгийн өсөлт ямартай ч өнгөрсөн жилийн гурван хувийг давна гэж үзэж буй шинжээчид санхүүгийн байгууллага олон байна. Тэд энэхүү таамаглалаасаа буцах эсэх нь оны дунд үеэс мэдэгдэнэ.

Олон улсын валютын сан дэлхийн эдийн засаг өнгөрсөн оны эцсээр нэлээд сайжирсан гэдгийг хэлж буй. Гэвч тус сан Дэлхийн эдийн засаг энэ жил 3.7 хувиар өснө хэмээж байсан ч энэ дөрөвдүгээр сард өсөлтийн төлвөө бууруулж, 3.6 хувь болгосон билээ. Хэдийгээр АНУ, Герман болон Их Британийн эдийн засаг эрүүл сэргэлтийг үзүүлж байгаа ч голлох хөгжиж буй эдийн засагтай орнууд

болох Орос, Бразил болон Өмнөд Африкийн бүрхэг төлөв дэлхийн эдийн засгийн өсөлтийг доош дарахаар байгаа аж. Тус сангаас манай улсын ▶

“ Эдийн засгийн голлох хөдөлгөгч хүч нь улс хоорондын худалдаа байдаг. Тэгвэл дэлхийн худалдааны өсөлт энэ жил хурда авна гэж Дэлхийн худалдааны байгууллагын мэргэжилтнүүд үзэж байгаагаа дөрөвдүгээр сарын сүүлээр хэлсэн юм. ”



► хойд хөрш Оросын Украинтай өдүүлсэн асуудлаас үүдэн эдийн засгийн өсөлтийн төлвийг нь 0.6 хувиар бууруулж, 1.3 хувь болгосон. Харин Хятадын хувьд 7.5 хувийн эдийн засгийн идэвх үзүүлнэ гэсэн таамгаа өөрчлөлгүй үлдээсэн байгаа.

Харин тус сангаас хөгжиж буй эдийн засагтай орнууд нэлээд эрсдэлтэй тулгарч буйг сануулсан бол хөгжингүй орнуудын хувьд геополитикийн асуудлууд болон хэт нам дор инфляци аюулын харанга дэлдэж буйг анхааруулсан байгаа.

Харин Азийн хөгжлийн банкнаас голлох аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн сэргэлт улам бүр эрчимжиж байгааг онцолж буй. Тус банкны жил бүр гаргадаг “Азийн хөгжлийн төлөв 2014” тайланд Азийн хөгжиж буй орнуудын ДНБ-ий өсөлт энэ онд 6.2 хувь, 2015 онд 6.4 хувь байна гэж төсөөлжээ.

Харин дэлхийн эдийн засгийн толгой орнууд болох АНУ, Евро бүс хийгээд Японы ДНБ-ий өсөлт дунджаар өнгөрсөн онд нэг хувь байсан бол 2014 онд 1.9 хувьд хүрч улмаар ирэх онд 2.2 хувьд хүрнэ гэж төсөөлжээ.



Урд хөршийн хувьд эдийн засгийн өсөлтийн хурдац саарах төлөвтэй байгааг АХБ мөн л батлан хэллээ. Тус улс зээлийн өсөлтийг сааруулж, аж үйлдвэрийн илүүдэл хүчин чадлыг хумиж эхэлсэн, орон нутгийн засаг захиргааны өр ихэсч, цалингийн зардал өссөн, мөн юанийн ханш чангарсан, улсын хөгжлийн бодлогыг тооноос чанар руу хандуулах болсон зэрэг шалтгаанаар эдийн засгийн өсөлт нь өнгөрөгч онд 7.7 хувь болж буурсан. Тэгвэл дээрх хүчин зүйлсийн нөлөө үргэлжилсээр байгаа тул Хятадын ДНБ-ий өсөлт энэ онд 7.5 хувь, 2015 онд 7.4 хувь болж тус тус буурах төлөвтэй аж.

Дөрөвдүгээр сард Дэлхийн банк мөн тодорхой улсуудын тэр дундаа Азийн хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийн төлвөө бууруулсан юм. Тухайлбал, Хятадын эдийн засгийг энэ жил 7.7 хувиар өснө гэж тооцож байсан ч тэд 7.6 хувь болгон засварласан бол Тайландын эдийн засгийг 4.5 хувиар өснө гэж байсан ч гурван хувь болгон огцом багасгалаа. Тус банкнаас хямралаас хойш дэлхийн эдийн засгийн түлхүүр хүч болон өсч буй Зүүн Ази номхон далайн бүс нутгийн эдийн засгийг өмнө нь 7.2 хувиар өснө гэж үзэж байсан бол энэ удаад 0.1 хувиар бууруулаад байна. Гэсэн ч Дэлхийн банкны шинжээчид тус бүс нутгийн хувьд тогтвортой эдийн засгийг зөгнөөд байна. Дэлхийн эдийн засаг харьцангуй өмнөх жилтэй харьцуулахад өндөр өсөлттэй байхаар байгаа нь тус бүс нутагт эдийн засгаа тэлэх боломжийг олгохоор байгаа бөгөөд харьцангуй тогтвортой өсөлтийн замд оруулахаар байгаа аж.

Эдийн засгийн голлох хөдөлгөгч хүч нь улс хоорондын худалдаа байдаг. Тэгвэл дэлхийн худалдааны өсөлт энэ жил хурдаа авна гэж Дэлхийн худалдааны байгууллагын мэргэжилтнүүд үзэж байгаагаа дөрөвдүгээр сарын сүүлээр хэлсэн юм. 2008 болон 2009 оны хямрал дэлхийн худалдаанд хамгийн урт хугацаанд нөлөөлсөн хямрал байсан хэмээн тус байгууллагын мэргэжилтнүүд хэлсэн. Тэгвэл энэ жилээс худалдааны салбарт эрс сэргэлт гарч 4.7 хувийн өсөлттэй байх бол ирэх онд 5.3 хувийн өндөр өсөлт үзүүлэхээр байгааг Дэлхийн худалдааны байгууллагын судалгаа

харуулж байна. Тус байгууллагын шинэ тооцоолол Хятад улсыг манай дэлхийн хамгийн том бараа бүтээгдэхүүн худалдаалагч болсныг баталж байна. Харин Европын холбоо нэг бүхэл гэж авч үзвэл Европын холбоо худалдаагаараа тэргүүлсээр байгаа билээ.

ОУВС-гийн эдийн засгийн өсөлтийн таамаг 2014, 2015 онд

Хятад	7.5%	7.3%
Орос	1.3%	2.3%
Энэтхэг	5.4%	6.4%
Их Британи	2.9%	2.5%
АНУ	2.8%	3.0%
Евробүс	1.2%	1.5%
Хөгжиж буй орнууд	4.9%	5.3%

Олон улсын эдийн засгийн эрсдэл харьцангуй намжаад байгаа ч дараах гурван нөхцөл байдлыг анхааралдаа байлгах нь чухал гэж Азийн хөгжлийн банк үзэж байна. Нэгдүгээрт, БНХАУ-д зээл олголтыг хязгаарлах зорилготой арга хэмжээг огцом бөгөөд эдийн засгийн өсөлтийг сааруулахуйц хэмжээнд авсан тохиолдолд, эдийн засгийн илэрхий удаашрал нь Монгол зэрэг худалдааны түнш орнуудад хүчтэй нөлөөлөх магадлалтай. Хоёрдугаарт, голлох аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн сэргэлтийн талаарх мэдээлэл алаг цоог байгаагаас үүдэн Азийн бараа бүтээгдэхүүний эрэлт тэдгээр улс орнуудад хүлээсэн хэмжээнд хүрэхгүй байх магадлалтай. Гуравдугаарт, АНУ-ын мөнгөний бодлогод орох өөрчлөлтөөс үүдэн дэлхийн санхүүгийн зах зээлд дахин цочрол үүсч болзошгүйг анхаарах нь чухал гэнэ.

Хэрэв одоогийн гараад буй шинжээчдийн анализ дүгнэлт үнэн бол одоогийн зах зээлийн “гутрал” түр зуурынх бөгөөд эдийн засаг сөхөрчихгүй гэсэн хөрөнгө оруулагчдын итгэл бага багаар сэргэхээр байгаа. Гэхдээ Америкт найдаж, Хятадаас эмээж буй одоогийн эдийн засаг эрүүл өсөлтийн замд орох хараахан болоогүйг эдийн засагчид хэлж байна. Гэсэн ч энэ жил дэлхийн эдийн засаг тийм ч гайхмаар өсөлт, сэргэлтийг үзүүлэхгүй нь тодорхой боллоо. ■

УСАН ЦАХИЛГААН СТАНЦ

ЭГИЙН ГОЛ БА МӨРӨӨДӨЛ

Д.БЭХЭЭ

Эгийн голын усан цахилгаан станц барих төслийг дахин эхлүүлж буйд сэтгүүлчийнхээ хувьд баяртай байна. Өдгөөгөөс 14 жилийн өмнө сэтгүүлч болох зорилго өвөртлөн “Өнөөдөр” сонины үүдийг алхсан цагаас Эгийн голыг эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглах асуудлыг хөндөж, олон нийтэд зөв ойлголт өгөхөд чиглэсэн нийтлэл, ярилцлага олныг хийжээ. “Эгийн голын станц амьдрал тэтгэнэ”, Эгийн голын усан цахилгаан станцыг барьснаар эрчим хүчээс хараат бус болно, “Усан цахилгаан станц барих нь зөв” гэх мэт гарчигтай нийтлэлүүд “Өнөөдөр” сонины хуудаснаа түүх болон үлдсэн. Монгол Улс гол мөрөн олонтойн хувьд том чадлын усан цахилгаан станцыг барьж байгуулах нь өндөр ач холбогдолтой хэмээн үздэг салбарын ажилтнуудын гэгээлэг хүсэл мөрөөдөл, зорилгыг дэмжин хамтарч олон жил ажилласны дүнд өндөр технологийг илтгэх усан станц манай улсад хэрэгтэй юм байна, хойд хөршийн эрчим хүчний хараат байдлаас гарах ганц арга зам бол том чадлын усан цахилгаан станц барьж байгуулах гэдгийг сайтар ойлгосон тул энэ асуудлыг босч ирэх бүрт байнга дэмжиж ирсэн билээ.

Энэхүү төсөл нь тэртээ 1991 оноос эхлэн яригдаж буй урт настай удаан жаргалтай 3-4 Засгийн газрын нүүр үзсэн урагш явдаггүй төсөл. Бүгд л улс орны хөгжилд тэсрэлт авчрах том бүтээн байгуулалт гээд хэрэгжүүлэх шийдвэр гаргадаг. Төслийн судалгаа, техник эдийн засгийн үндэслэлийг хийж, хөрөнгө оруулалт татаад ирэхийн цагт эрх баригч намууд маргалдаж, санал зөрөлдөөд л



Эгийн голын УЦС-ыг барьснаар эрчим хүчээр ОХУ-аас хараат байдлаас гарна

унагачихдаг гашуун туршлага бий. М.Энхболдын тэргүүлсэн засгийн үед уг төсөл олон даваа гүвээг давж, гэрээ хийж, барилгын ажлыг эхлүүлэх л үлдээд байх мөчид С.Баярын Засгийн газар гарч ирээд эрчим хүчний мэргэжилтнүүдийн мөрөөдлийг хөсөрдүүлсэн юм. Сэтгүүлчийнхээ хувьд маш их харамссан. Учир нь энэ төслийг бодит биелэл болгохын төлөө эрчим хүчний салбарынхан бүх л хүч авьяасаа, сэтгэл зүрх, цаг заваа зориулсныг, мөн багагүй мөнгө гарсныг мэдэх юм. Хятадын Засгийн газраас олгох 300 сая ам.долларыг Эгийн голын усан цахилгаан станц байгуулахад оруулах, тусгай баг урд хөршийн алдарт Гурван хавцлын усан цахилгаан станцыг очиж үзэх, туршлага судлахаар төлөвлөсөн байж билээ. Зогсоосон шалтгаан нь их энгийн. Зүгээр л улстөржилт. Улстөржилтөөс болж улс оронд

хэдийнэ хэрэгжээд явчих том төслүүд унаж байгаад улстөрчид нэгийг бодох цаг ирсэн. Үүний томоохон жишээ нь Эгийн голын станц. Маш их хэмжээний мөнгөн дүнтэй, иргэдэд ажил хийсэн юм шиг харагдах бодит үр дүнтэй төсөл учраас намууд хоорондоо булаацалдаж, нэрээ гаргах, мөн их мөнгөнөөс идэх гэсэн олиггүй санаархал улстөржсөн үйл явдлууд энэ төслийг урагшлуулахгүй өнөөдрийг хүргэсэн билээ.

Харин Шинэчлэлийн Засгийн газраас төслийг дахин эхлүүлэх шийдвэр гаргаж, төслийн нэгжийг байгуулсан. Тус нэгж өнөөдөр хуучин ТЭЗҮ-ийг шинэчлэх, судалгаа үнэлгээнүүдийг нарийвчлах, хуулийн болон зөвлөх компаниудыг сонгох, зам, эрчим хүчний шугамын судалгааны ажлуудыг хийгээд байна. Бүх ажлыг дахин эхнээс нь хийж байна гэсэн үг. Цаг ➔

▸ хугацаа их алдсан төсөл ч эрчим хүчнийхэн дахин бүдрэхгүй гэдэгт итгэн сэтгэл өөдрөг, эрч хүчтэй ажиллаж байна.

Эгийн голын усан цахилгаан станцыг яагаад барих ёстой гэж...

Нэгдүгээрт, жил ирэх тусам өсөн нэмэгдэх эрчим хүчний хэрэгцээг хангах шинэ эх үүсвэртэй болж, эрчим хүчний салбарынхан толгойны өвчнөөсөө сална. Хоёрдугаарт, цахилгаан эрчим хүчээр ОХУ-аас хараат байдлаас бүрмөсөн гарна. Монгол Улсын төвийн эрчим хүчний системийн гаднаас үл хамаарах бие даасан байдлыг хангаж, Оросын холбооны улсаас жил бүр импортоор авдаг 25-26 сая ам.долларын зардлыг хэмнэнэ. Гуравдугаарт, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал улам баттай, тогтвортой болно. Дөрөвдүгээрт, ихэнхдээ хилийн гадагш урсан одох гол мөрнийг ашиглах, улсын хөгжилд том хувь нэмэр оруулах төсөл. Тавдугаарт, цаг уурын дулаарал, өөрчлөлттэй холбоотойгоор орчин тойронд чийгшил өгч, зөөлөн орчныг бүрдүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Зургадугаарт, түүхий нүүрсний хэрэглээг жилд 200 орчим мянган тонноор бууруулж, Улаанбаатар хот болон бусад хот суурин газруудын агаарын бохирдлыг бууруулахад үнэтэй хувь нэмэр оруулна.

Эсэргүүцэгчид

Асуудлыг нэг өнцгөөс хараад л зүтгэдэг хүмүүс байдаг. Тэд усан цахилгаан станц барьснаар байгаль орчин сүйрч, гол мөрөн ширгэж, загас жараахай үхэж үрэгддэг мэтээр олон нийтийн санаа бодлыг буруу тийш эргүүлэхийг хичээдэг. Усан цахилгаан станц бол дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн өндөр технологи. Дэлхийн улс орнууд энэхүү гайхамшигтай технологийг ашиглаж, эрчим хүчнийхээ хэрэглээг хангаж, өндөр хөгжилтэй сайхан амьдарч байна. Мөн байгальд ээлтэй технологи юм. Хүрээлэн буй орчинд хөнөөлтэй, ан амьтанд сөрөг нөлөөтэй, гол мөрнийг ширгээгээд алга болгодог хөнөөлтэй бол усан цахилгаан станцууд дэлхийгээр нэг босох байсан гэж үү. Бусад улс монголчуудаас дутуугүй л ухаантай баймаар. Яагаад гэвэл тэд биднээс хэд дахин хөгжлөөр түрүүлсэн өндөр технологиудыг хэрэглээд ашиглаад, үр дүнг нь хэдийнэ мэдэрсэн хүмүүс. Усан цахилгаан станц байгальд хортой бол улс орнууд барихгүй байхыг дэлхийд уриалж, хүчтэй тэмцэл өрнүүлж жагсмаар юм.

Усан цахилгаан станцыг барихад байгаль орчинд нөлөөлөх талаас нь маш анхааралтай хандаж, судалж, нарийвчилсан үнэлгээ хийж, барьсны дараа эргэн хэвийн байдалд оруулах төлөвлөгөөг ч нарийн төлөвлөсөн

байдаг. Эгийн голын станцад энэ бүх төлөвлөгөө олон улсын стандартын дагуу хийгдэнэ гэдгийг хэлэх хэрэгтэй. Олон улсын стандартын дагуу шүү гэдгийг онцлон тэмдэглэмээр. Ер нь манайхан стандарт гэх ойлголтыг ойлгож, ухаарах цаг болсон мэт. Тэр дундаа олон улсын өндөр түвшний стандартыг ойлгож, мэдрэх, таних зайлшгүй шаардлагатай. Монгол Улсын, бидний мэдэх стандарт гэж юу билээ. Тэр л ядмагхан, доогуур түвшний стандартаар олон улсын стандартаар барьж байгуулах ажлуудыг ойлгож, хүлээн аваад эсэргүүцээд давхих нь хэр үр дүнтэй бол.

Тайшир, Дөргөний усан цахилгаан станцууд өндөр технологийн бодит жишээ. Тус станцуудын шав тавих арга хэмжээг сурвалжилж явснаараа бахархдаг юм. Баруун хязгаарын гурван аймгийн иргэд өвөлдөө эрчим хүчний гачланд орж, хөлдөх дээрээ тулдаг, аргагүйн эрхэнд хойд хөршөөс эрчим хүч авч байж онд ордог байсан он жилүүд саяхан. Дөргөний станцыг барьснаар аймгуудын иргэд цахилгааны хязгаарлалтаас гарч, тэнд амьдрал цэцэглэж эхэлснийг бүгд мэднэ. Тайширын усан цахилгаан станц Говь-Алтай, Завханы зарим сумын иргэдэд шинэ амьдрал бэлэглэсэн. Малчдаасаа ч дор, гэрэлгүй амьдардаг дээрх аймгийн сумдын өрх айл өнөөдөр гэрэл цахилгаантай, телевизийн хүссэн ▶▶



Тавдугаарт, цаг уурын дулаарал, өөрчлөлттэй холбоотойгоор орчин тойронд чийгшил өгч, зөөлөн орчныг бүрдүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

► сувгаа үзэж, гар утсаа цэнэглэн, хоол ундаа цахилгаан зуухан дээр хийж байна. Завхан гол урсдаараа урсан байгаль дэлхийгээ чимсээр. Тухайн үед Завхан гол тасарч, элсэн нүүдэл үлдлээ гэх мэтчилэн сөрөг мэдээлэл гарч байсан нь тэр л жилийн цаг уурын байдалтай холбоотой байсан нь тогтоогдсон. Монголын их элсэн манхны бэлээр намуухан урсах Завхан гол миний хүүхэд насны жаргалтай амьдралын дурсамжийн түүх. Орчин тойрондоо амьдрал бэлэглэн цэлэлзэх энэ л голд угаагдаж өссөн хүний хувьд усан цахилгаан станц барьснаас үүдэн ширгэж, алга болсон бол би энэхүү өндөр технологийг барьж байгуулах нь зөв хэмээн нийтлэл бичээд суухгүй байсан нь ойлгомжтой. Зуны дэлгэр цагаар жил бүр л нутгаа санагалзан очих бүрт эргээ даван халих Завхан гол юутай үзэсгэлэнтэй, сайхан харагддаг гээч. Хүн малыг ундаалсан Завхан гол өнөөдөр өндөр технологийн ид шидийг үзүүлж, эрчим хүчээр бусдыг гийгүүлэн байна. Тийм ч учраас голгүйн, усгүйн зовлонг мэдрэх алтайчууд Тайширын станцын үүсгэсэн нуурыг Гэгээн нуур хэмээн нэрийдсэн биз ээ. Хүн, байгалийн зохилдолгоо, байгальд ээлтэй хөгжлийн суурь энэ бус уу.

Эцэст нь

Улс төрийн шуурганд хэдэнтээ бүдэрсэн Эгийн голын төсөл дахин бүү зогсоосой. Энэхүү бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд төр, засгийн хүсэл эрмэлзэл, итгэл үнэмшил, эх орны төлөө зохилох зүрх сэтгэл, зориг хэрэгтэй. Эргээд харахад хийсэн зүйлтэй, хэлэх юмтай байхыг хүсвэл эрх баригч нам бүтээн байгуулалт эхлүүлэх замыг шулуун дардан байлгах нь хамгаас чухал. Туршлагаас харвал зогсоох шийдвэрт улс төр л нөлөөлсөн байдаг. Түүнээс уг төсөлд мөнгө олдоно. Хүн хүч, мэргэжлийн баг, эрчим хүчний салбарынхны хүсэл, итгэл үнэмшил, өөдрөг сэтгэл зүтгэл бүгд байгаа билээ. Эгийн голын усан цахилгаан станц бол эрчим хүчний мэргэжилтнүүдийн мөрөөдөл. Тэдний мөрөөдөл биелээсэй, мөрөөдлийг нь биелүүлээсэй. ■

Эгийн голын төсөл

Эгийн голын усан цахилгаан станцыг Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутгаар урсан өнгөрөх Эгийн гол дээр барина. Өндөр нь 93 метр, 710 метр урт булдаж нягтруулсан бетон далан барихаар төлөвлөж байна. Далангийн ард 125 ам дөрвөлжин километр толио бүхий усан сан байгуулах бөгөөд түүний усны хамгийн дээд буюу бүрэн дүүрэх түвшин нь далайн түвшнээс дээш 900 метрт тогтоно. Станцын хүчин чадал нь 220 МВт, тус бүрдээ 55 МВт хүчин чадал бүхий дөрвөн турбин генератор суурилуулах юм. Эгийн голын усан цахилгаан станцын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг 220 кВ-н хоёр хэлхээ бүхий цахилгаан дамжуулах агаарын шугамаар Эрдэнэт дэд станцаар дамжуулан Монгол Улсын төвийн эрчим хүчний системд нийлүүлнэ. Төслийн талбар болон Эрдэнэт хотыг холбосон 70 км урт цахилгаан дамжуулах шугам, 125 км авто замыг барьж байгуулах аж. Эдгээр нь 2007 оны ТЭЗҮ тооцоолол юм. Үүнийг улам сайжруулахаар өнөөдөр төслийн багийнхан ажиллаж байна.

Дулааны цахилгаан станцууд үйлдвэрлэсэн эрчим хүчнийхээ 20 хүртэл хувийг дотоод хэрэгцээндээ зарцуулдаг бол Эгийн голын усан цахилгаан станц нь ердөө нэг хувийг зарцуулах учраас жилдээ 96 сая кВт цаг цахилгаан эрчим хүч, дунджаар 4.7 сая ам.долларыг хэмнэнэ. Станц нь хөрөнгө оруулалтаа 10-15 жилд нөхөх ба 100 жилийн хугацаанд анхны хөрөнгө оруулалтаа 6-7 дахин нөхөх урьдчилсан тооцоо бий.

Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг анх 1993 онд “Усны эрчим хүч” ХХК, “Электроконсулт” ХХК хамтран боловсруулсан ба 2007 онд нэмэлт судалгааг хийжээ. Судалгаанд тусгаснаар байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, ялангуяа хөрсөн бүрхэвч, ой мод, ус, биологийн төрөл зүйлд хор хөнөөл багатайгаар хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн байна. Энэхүү төслийн нөлөөгөөр Эгийн гол дагуу 60 км урт, хоёр км өргөн усан мандал үүсэх бөгөөд ингэснээр усны ууршилт нэмэгдэж, ойр орчимд чийглэг, таатай уур амьсгал зонхилох аж. Энэ жил төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг шинэчлэн, дотоодын аж ахуйн нэгжээр хийлгэхээр болсон. Эг-Сэлэнгийн бэлчрээс дээших газарт УЦС-ын далан барих тул Эгийн голын загасны судалгааг Геоэкологийн хүрээлэн, Монголын тул хамгаалах сантай хамтарч хийх юм байна. Судалгааны дүгнэлтэд үндэслэн тухайн орчинд хамгийн тохиромжтой загас өнгөрүүлэх байгууламж байгуулна. Ингэснээр Эг-Сэлэнгийн экосистемд учрах сөрөг нөлөөллийг бууруулж, загасны хэвийн амьдралын шинэ орчин бүрдэнэ гэж үзэж байгаа аж. Төслийн талбайд 1300 га мод, сөөг хамрагдаж байгаа. Усан сан үүсэх нутаг дэвсгэр дэх мод, сөөгнөөс амьдрах чадвар сайтай модыг ялган, мэргэжлийн байгууллагаар өөр газарт шилжүүлэн суулгах зэрэг олон ажлыг хийх юм байна. Дэлхийд УЦС-ын ач холбогдлыг ингэж үздэг ажээ.

УЦС-ын ач холбогдол:

1. Усан Цахилгаан Станц бол сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр
2. Бусад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглах боломжтой болгодог.
3. Баталгаат эрчим хүч, үнийн тогтвортой байдлыг тэтгэдэг.
4. Ундны ус хадгалахад хувь нэмэр оруулдаг.
5. Цахилгаан эрчим хүчний системийн тогтвортой байдал болон найдвартай байдлыг нэмэгдүүлдэг.
6. Цаг уурын өөрчлөлтийн эсрэг тэмцэхэд тусалдаг.
7. Бидний амьсгалж буй агаарыг сайжруулдаг.
8. Улсын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулдаг.
9. Өнөөдрийн болон маргаашийн цэвэр, хямд эрчим хүч.
10. Тогтвортой хөгжлийн үндсэн арга юм. ■

RECLAM6S.MN

Гарч хайснаас гараасаа хай...

Та reclam6s.mn сайтад бараа бүтээгдэхүүнээ реклам, видео зар сурталчилгаатай нь хамгийн хямд үнээр байршуулах боломжтой.

Таны худалдаа үйлчилгээг бид түгээнэ.



ВЭБ, МОБАЙЛ ВЭБ БОЛОН APPLICATION

3

ХОСОЛСОН ҮЙЛЧИЛГЭЭ



 **91116586, 96606586**

Бид хамтран ажиллахдаа таатай байх болно.